




МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,  
ТҮҮНД ХОЛБОГДОХ СУДАЛГАА**

*/Албан хэрэгцээнд/*



Улаанбаатар хот  
2026

## ГАРЧИГ

I: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШИГТГЭСЭН ХУВИЛБАР .....	2
II: ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА .....	26
2.1. Парламентын хяналтын үр ашигтай зохицуулалтын механизмыг бүрдүүлэх чиглэлээр Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ны зөвлөмж.....	27
2.2. Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл, зохион байгуулалт.....	40
2.2.1. Хяналт шалгалтын арга хэрэгсэл .....	40
2.2.2. Хяналт шалгалтын үйл ажиллагаа .....	41
2.2.3. Хяналт шалгалтын төлөвлөлт .....	43
2.2.4. Байнгын, дэд хороодоос хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт .....	44
2.2.5. Хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ .....	46
2.3. Улсын Их Хурлын хяналт хэрэгжүүлэх .....	47
2.3.1. Асуулга тавих .....	47
2.3.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, дүн шинжилгээ .....	48
2.3.3. Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх .....	50
2.3.4. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн тайланг хэлэлцэх .....	53
2.4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих .....	56
2.5. Төсвийн хяналт .....	62
2.6. Нэр дэвшигчийн сонсгол .....	64
2.7. Улсын Их Хурлын хяналт шалгах тү хороо .....	65
2.7.1. Хянан шалгах түр хорооны эрх зүйн байдал .....	65
2.7.2. Нотлох баримт .....	68
2.7.3. Хянан шалгах түр хорооны сонсгол .....	71
2.7.4. Хянан шалгах түр хорооны тайлан, зардал .....	73
2.8. Ашигласан эх сурвалж .....	75
2.9. Парламентаас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын талаарх: бусад орнуудын туршлага .....	76
2.9.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх онол, арга зүйн асуудал .....	79
2.9.2. Бусад орнуудын хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж буй аргачлал, практик туршлага .....	83



I.  
**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШИГТГЭСЭН ХУВИЛБАР**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ОРУУЛАХ  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ**

*Шигтгэсэн хувилбар 05.13  
Bold – шинээр нэмсэн;  
Bold underline - өөрчлөлт.*

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
АРГА ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын  
арга хэрэгсэл**

6.1. Улсын Их Хурал хянан шалгах хяналт шалгалтын бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:

6.1.1. асуулт ~~тавих~~;

6.1.2. асуулга ~~тавих~~;

6.1.3. хууль тогтоомжийн ~~биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх~~  
хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ;

6.1.4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;

6.1.5. төсвийн хяналт;

6.1.6. хяналтын сонсгол ~~хийх~~;

6.1.7. хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.

6.2. “Улсын Их Хурлын хяналт” гэж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын болон Улсын Их Хурлаас удирдлага нь сонгож, томилогддог байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд энэ хуулийн 6.1.1-6.1.6-д заасан хяналтын арга хэрэгсэлд заасны дагуу шинжлэх, дүгнэх, хянах байнгын шинжтэй үйл ажиллагааг ойлгоно.

6.3. “Улсын Их Хурлын шалгалт” гэж хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 34.1.1-д заасан аргаар нотлох баримт цуглуулах парламентын тусгай шалгалтыг ойлгоно.

6.4. Энэ хуулийн 6.1.1-6.1.6-д заасан Улсын Их Хурлын хяналтын дүн энэ хуулийн 6.1.7-д заасан Улсын Их Хурлын шалгалтыг тухайн асуудлаар явуулах үндэслэл байж болно.

**7 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын  
хянан шалгах үйл ажиллагаа**

7.1. Байнгын, дэд болон хянан шалгах түр хороо, Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ хороо, Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлж, хянан шалгах түр хороо Улсын Их Хурлын шалгалт явуулна.

7.2. Төрийн аудитын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл болон төрийн бусад байгууллага холбогдох Байнгын хорооны даалгаснаар хяналт шалгалт явуулж

~~болно. Холбогдох Байнгын хороо эдгээр байгууллагыг хууль тогтоомжид заасан чиг үүргийнх нь хүрээнд Улсын Их Хурлын хяналт шалгалтад оролцуулахдаа тухайн байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлж үл болно. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл Төрийн аудитын байгууллага, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад хараат бус хянан шалгах чиг үүрэгтэй байгууллагад түшиглэн явуулна. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс нөлөөлж үл болно.~~

7.3. Улсын Их Хурлаас хийх хяналт шалгалтыг ~~Улсын Их Хурлын нэгдсэн удирдамжийн дагуу хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд~~ төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хяналт шалгалттай давхцуулахгүйгээр хэрэгжүүлнэ.

7.4. Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хяналт шалгалт явуулахдаа аливаа байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцохгүй.

7.5. Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл, тооцоо судалгаа, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан нуун дарагдуулахыг хориглоно.

7.6. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай бол тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулж болох бөгөөд тэдгээрийн ажиллах журам, эрх, үүрэг, хариуцлагыг Тамгын газартай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

7.7. Улсын Их Хурлын хяналт шалгалтад энэ хуулийн 7.6-д заасан этгээдийг оролцуулах бол энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөж, шаардлагатай зардлыг Улсын Их Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

**7.8. Хяналт шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн Улсын Их Хурлын үйл ажиллагаа, холбогдох шийдвэрийн биелэлтийг давтан хянаж болно.**

**7.9. Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал хяналтын сонсгол, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлттэй холбогдуулан үр дүнгийн давтан хяналт хийнэ.**

## **8 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөлт**

8.1. Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй хэлбэртэй байна.

8.2. ~~Байнгын, дэд хорооноос хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг Улсын Их Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар /цаашид “цаглавар” гэх/-т тусган хэрэгжүүлнэ. Байнгын хороод ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө дараагийн ээлжит чуулганы хугацаанд хийх хяналт шалгалтын цаглаварт тусгуулахаар хуралдаанаараа шийдвэрлэсэн саналаа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.~~

8.3. ~~Байнгын, дэд хороо дараагийн ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулах саналаа ээлжит чуулган~~

~~завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /цаашид “Төрийн байгуулалтын байнгын хороо” гэх/ нд хүргүүлнэ. Байнгын хорооноос ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг энэ хуулийн 7.2-т заасан байгууллагын шалгалтын сэдвийг харгалзан, энэ хуулийн 8.2-т заасан саналыг үндэслэн боловсруулсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын цаглаварт тусган хэрэгжүүлнэ. Дэд хороо шаардлагатай гэж үзвэл цаглаварт тусгуулах саналаа холбогдох Байнгын хороонд уламжилна.~~

~~8.4. Нам, эвслийн бүлэг цаглаварт тусгуулах саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж болно. Хяналт шалгалтын цаглаварт энэ хуулийн 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан хяналт, дараагийн ээлжит чуулганы хугацаанд үргэлжлэн ажиллах хянан шалгах түр хороо, Байнгын хорооноос байгуулах ажлын хэсэг, энэ хуулийн 13, 16 дугаар зүйлд заасан нэгдсэн дүн, тайлан, үнэлгээг тусгана.~~

~~8.5. Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлэг хороо энэ хуулийн 8.3, 8.4-т заасны дагуу саналаа ирүүлээгүй бол хяналт шалгалтын цаглаварт тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.~~

~~8.6. Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөгөөт цаглаврын төслийг холбогдох шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж, шийдвэрлүүлнэ.~~

~~8.7. Цаглаварт хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т зааснаас бусад тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, төсөв, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах болон хяналт шалгалтын бусад асуудлыг тусгана. Хяналт шалгалтын цаглаварт тайлан, илтгэл, мэдээллийг тусгахдаа энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т зааснаас бусад тайлан, илтгэл, мэдээллийг тусгана.~~

8.8. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах тохиолдолд явуулна:

8.8.1. энэ хуулийн 8.4-т заасан цаглаварт тусгагдаагүй асуудлаар хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах тухай гишүүний саналыг энэ хуулийн 9.2-т заасны дагуу Байнгын хороо хэлэлцэж, дэмжсэн;

8.8.2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн ~~39.4.2~~ 39.5.2, 39.5.3-т заасан хяналт шалгалт явуулах саналыг Байнгын хороо хэлэлцэж дэмжсэн.

### 9 дүгээр зүйл. Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт зохион байгуулах

9.1. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах, эсхүл хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг дангаар болон хамтран байгуулна.

9.2. Гишүүн энэ хуулийн 9.1-д заасны дагуу хяналт шалгалт явуулах саналыг өөрийн харьяалагдах Байнгын хороонд эрхлэх асуудлын хүрээнд гаргаж болох бөгөөд уг саналыг Байнгын хороо хэлэлцэж дараах шийдвэрийг гаргана:

9.2.1.түхайн асуудлаар хяналт шалгалт хийж, дүнг танилцуулахыг эрх бүхий холбогдох байгууллагад даалгах;

9.2.2.Байнгын хорооны хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах;

9.2.3.түхайн асуудлаар хяналт шалгалт явуулах шаардлагагүй гэж үзэх.

9.3.Байнгын, дэд хороо шаардлагатай гэж үзвэл ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл тусгай мэдлэг, мэргэшил шаардагдах асуудлаар туслалцаа үзүүлэх мэргэшсэн судлаач, мэргэжилтэн, мэргэжлийн холбооны төлөөллийг оролцуулсан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулж болно.

9.4.Байнгын, дэд хороо ажлын хэсэг байгуулах тогтоолын хавсралтаар ажиллах удирдамж батлах бөгөөд ажлын хэсэг уг тогтоолд заасан хугацаанд санал, дүгнэлт гаргаж Байнгын, дэд хороонд танилцуулна. Байнгын, дэд хороонд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч танилцуулна.

9.5.Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан асуудлаар санал, дүгнэлт, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох Байнгын, дэд хороонд танилцуулж болно.

9.6.Дэд хороо энэ хуулийн 9.5-д заасан санал, дүгнэлт, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороонд, Байнгын хороо нэгдсэн хуралдаанд тус тус танилцуулж шийдвэрлүүлнэ.

9.7.Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын явц, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтаан хэлэлцэж, ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл дуусгавар болгох шийдвэрийг гаргана.

10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

10.1.Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа үр дүнг үндэслэн шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эсхүл хүчингүй болгох арга хэмжээ авна.

10.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх талаар тус тус Засгийн газар, холбогдох байгууллагад чиглэл өгөхтэй холбоотой асуудлаар тогтоол гаргана.

10.3.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгоно.

10.4.Холбогдох байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.1, 10.2-т заасан Улсын Их Хурлын шийдвэрийн тайланг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулна.

10.5.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан Улсын Их Хурлын шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан түүний хэрэгжилтийн явц болон гүйцэтгэлийн мэдээллийг дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ:

10.5.1.байгууллагын албан ёсны цахим хуудсанд тусгайлан заасан цэсэд улирал тутам шинэчлэн байршуулах;

10.5.2.эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хавсаргана.

10.6.Энэ хуулийн 10.5-д заасан мэдээллийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр байршуулаагүй, хугацаа хожимдуулсан, дутуу тайлагнасан бол холбогдох албан тушаалтанд Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЯГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

### **12 дугаар зүйл. Асуулга тавих**

~~12.1. Хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсаныг “асуулга” гэнэ.~~ 12.1. Асуулга нь дараах хэлбэртэй байна:

12.1.1. хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт, үр дүнг тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардах зорилгоор гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсан асуулга;

12.1.2. гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийг засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавьж, нэгдсэн хуралдаан дээр хариулт авахыг Улсын Их Хурлын асуулга.

~~12.4. Гишүүний асуулгын хариуг холбогдох Байнгын хөрөө Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.~~ Гишүүний асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

**13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг сонсож, хэлэлцэх**

13.1. “Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээ” гэж хууль тогтоомжийн биелэлтийн явцад хуримтлагдсан өгөгдлүүдийг задлан шинжилж, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээг тодорхойлоход чиглэсэн цогц үйл ажиллагааг ойлгоно.

13.2. Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт хийх үнэлгээг:

13.2.1. хууль тогтоомжид бүхэлд нь;

13.2.2. хууль тогтоомжийн зарим зүйл, хэсэг, заалтад;

13.2.3. тодорхой харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн зохицуулалтад хийж болно.

13.3. Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээг энэ хуулийн 8.2-т заасан цаглаварт тусгасны дагуу хийнэ.

13.4. Гишүүний хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх саналыг хөлбөгдөх Байнгын хороо дэмжсэн бол энэ хуулийн 8.3-т заасан саналд тусгуулан шийдвэрлүүлнэ.

13.5. Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийхтэй хөлбөгдөн гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

13.6. Хөлбөгдөх Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтэд хөндлөнгийн, хараат бус байгууллага, тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, төрийн бус байгууллагаар үнэлгээг хийлгэх буюу хамтарч болно.

13.7. Тамгын газар Улсын Их Хурлын, Засгийн газар, төрийн бусад байгууллага хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг 10 хоногийн дотор мэдээллийн нэгдсэн санд байршуулж, хөлбөгдөх Байнгын хороонд хүргүүлнэ.

13.8. Хөлбөгдөх Байнгын хороо Улсын Их Хурлаас хийсэн хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг хүлээн авснаас хойш нэг сарын дотор хэлэлцэнэ.

13.9. Шаардлагатай гэж үзвэл хөлбөгдөх Байнгын хороо нь Засгийн газар, төрийн бусад байгууллагын хийсэн хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг сонсож, хэлэлцэнэ.

13.10. Хөлбөгдөх Байнгын хороо хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулна.

13.11. Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт Улсын Их Хурлын үнэлгээ хийх журмыг Улсын Их Хурлын дарга батална.

### 13 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх, бусад байгууллагаас ирүүлсэн тайлан, дүнг хэлэлцэх

13.1. Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг /цаашид “үнэлгээ” гэх/ энэ хуулийн 8.2-т заасан цаглаварт тусгасны дагуу хийх бөгөөд үнэлгээний тайланг холбогдох Байнгын хороо тухай бүр хэлэлцэнэ.

13.2. Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 8.3-т заасан саналд нэгээс дээшгүй үнэлгээний ажил төлөвлөж тусгана.

13.3. Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагаас үнэлгээний тайланг тухай бүр холбогдох Байнгын хороо, Тамгын газарт хүргүүлж, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээллийн нэгдсэн санд байршуулах бөгөөд Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл үнэлгээний тайланг тухай бүр хэлэлцэнэ.

13.4. Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага нь үнэлгээний ажлын нэгдсэн дүнгээ дараа жилийн төлөвлөгөөний хамт жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурал дараах журмаар дүн шинжилгээ хийж, хэлэлцэнэ:

13.4.1.Тамгын газар холбогдох тайланд үндэслэн тайланд дурдсан асуудалд шалтгаан, үр дагаврын шинжилгээ хийх;

13.4.2.Хууль зүйн байнгын хороо үнэлгээний нэгдсэн дүнг энэ хуулийн 13.4.1-д заасан шалтгаан, үр дагаврын шинжилгээний тайлангийн хамт хэлэлцэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах;

13.4.3.нэгдсэн хуралдаанаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг дараа оны хаврын ээлжит чуулган хаахаас өмнө хэлэлцэж, шаардлагатай бол Хууль тогтоомжийн тухай хуулийн 52.1-д заасан авах арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг батлах.

13.5.Улсын Их Хурлаас үнэлгээ хийхтэй холбогдуулан Засгийн газар болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлан, баримт бичгийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж өгөх үүрэгтэй.

13.6.Улсын Их Хурлаас үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагаас үнэлгээний тайлан хүлээн авах, шалтгаан, үр дагаврын дүн шинжилгээ хийхтэй холбоотой журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батлах бөгөөд шаардлагатай бол уг журамд холбогдох аргачлалыг тусгана.

13.7.Энэ зүйл нь хууль санаачлагч Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасны дагуу үнэлгээ хийлгэхэд хамаарахгүй.

## **15 дугаар зүйл.Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх**

15.1.Улсын Их Хурал дараах тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэнэ:

15.1.1.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайланг жил бүр;

15.1.2.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг тухай бүр;

15.1.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг ~~жил бүр~~ хаврын чуулганы хугацаанд;

15.1.4.Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг жил бүр, төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн биелэлт, мөнгө, зээлийн байдлын талаарх Монголбанкны мэдээллийг шаардлагатай тохиолдолд;

15.1.5.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг жил бүр, Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг хоёр жил тутам;

15.1.6.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд;

15.1.7.банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны тайланг жил бүр;

15.1.8.Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны тайланг жил бүр;

15.1.9.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;

15.1.10.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;

15.1.11.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;

15.1.12.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн биелэлтийн тайланг гурван жил тутам, ~~өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг жил бүр;~~

15.1.13.Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг жил бүр;

15.1.14.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг жил бүр;

15.1.15.Олон Улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний биелэлтийн талаарх Засгийн газрын тайланг хоёр жил тутам;

15.1.16.жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн биелэлтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн биелэлт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг хоёр жил тутам;

15.1.17.Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн биелэлтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг тухай бүр;

15.1.18.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр.

**15.2.Улсын Их Хуралд дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд ирүүлнэ Улсын Их Хурал дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд хэлэлцэнэ:**

15.2.1.авлигатай тэмцэх хууль тогтоомжийн биелэлт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр;

15.2.2.эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг жилд нэгээс доошгүй удаа.

15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдээллийн нэгдсэн сан болон Улсын Их Хурлын цахим хуудсанд нийтэлж, байршуулна.

15.4.Энэ хуулийн 15.4-д заасан тайланд ажлын 10-өдрийн дотор Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна **15.1.1, 15.1.5-15.1.8, 15.1.14, 15.1.18-д заасан үйл ажиллагааны тайланд түүнийг ирүүлснээс хойш ажлын 20 өдрийн дотор Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.**

**16 дугаар зүйл.Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх, үүрэг амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих**

**16.1.Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад үүрэг, чиглэл болгосон буюу хуулиар нийтээр дагаж мөрдөх хэм**

хэмжээний акт батлахаар заасан Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг дараа оны 03 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан тайланд Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг дүгнэх үнэн зөв, бодитой, иж бүрэн, үр дүнд суурилсан, нотлох баримт бүхий мэдээллийг тусгана.

16.3.Тамгын газар энэ хуулийн 16.1-д заасан тайланг энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл холбогдох байгууллагад буцаах буюу нэмэлт мэдээллийг гаргуулж болно.

16.4.Тамгын газар Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр биелэлтийн тайланд дүн шинжилгээ хийж, Байнгын хороодод хүргүүлэх бөгөөд шийдвэрийн биелэлтийн нэгдсэн дүнг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.

16.5.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 16.1-д заасан тайлан, 16.4-т заасан дүн шинжилгээг хэлэлцэж, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, Улсын Их Хурлын шийдвэр, холбогдох заалтыг хяналтаас хасах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

16.6.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 9.1-д заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулж болно.

16.7.Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт, санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэж, нэгдсэн хуралдаанд оруулна.

16.8.Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг жил бүрийн 06 дугаар сарын 15-ны дотор хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл дараах шийдвэр гаргана:

16.8.1.Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр даалгах;

16.8.2.Улсын Их Хурлын шийдвэр, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтыг хяналтын бүртгэлээс хасах талаар холбогдох Байнгын хороо, Тамгын газарт чиглэл өгөх;

16.9.Тамгын газар Улсын Их Хурлын шийдвэрийн хяналтын бүртгэл хөтлөх, үүрэг чиглэл болгосон шийдвэрийг хяналтад авах, хяналтаас хасах санал гаргах, биелэлтийн тайланг хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх ажлыг эрхлэх бөгөөд холбогдох журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

16.10.Улсын Их Хурлын шийдвэрийг бүртгэх, хяналт тавих Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагаанд нэгдсэн цахим систем бүрдүүлж, ашиглаж болно.

16.11.Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны хэлэлцүүлгийн шатанд Засгийн газрын гишүүн, бусад байгууллагын удирдлагаас өгсөн тодорхой хугацаатай, хэрэгжих боломжтой амлалт, үүрэг бүхий тайлбарыг “Амлалт” /цаашид “амлалт” гэх/ гэж үзэж, Тамгын газар бүртгэн хэрэгжилтэд хяналт тавина.

16.12.Энэ хуулийн 16.11-д заасан амлалт, тайлбарыг холбогдох албан тушаалтан ажлын 5 өдрийн дотор Тамгын газарт ирүүлнэ.

16.13.Амлалтын биелэлт хангалтгүй, эсхүл хугацаа хоцорсон тохиолдолд холбогдох Байнгын хороо тухайн албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай бол хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

16.14.Амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын дарга батална.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ  
БИЧГИЙН БИЕЛЭЛТЭД ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ**

17 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

17.1.Улсын Их Хурал жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /цаашид “төлөвлөгөө” гэх/-ний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхдээ дараах хүрээнд хэлэлцэнэ:

17.1.1.төлөвлөсөн үр дүн, зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хүрээгүй шалтгаан нөхцөл;

17.1.2.төлөвлөсөн үр дүнгийн хүрсэн түвшинг тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрээр;

17.1.3.төлөвлөгөөний зорилтын хэрэгжилт нь дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн хэдэн хувьд хүрснийг;

17.1.4.цаашид авах арга хэмжээ.

17.2.Засгийн газар улсын төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гүйцэтгэлийн тайлангийн хамт жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.

17.3.Тамгын газар хуулийн 17.2, 17.5-д заасан тайлан болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup>.5.3-т заасны дагуу хийсэн дүгнэлтийг үндэслэн төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнгийн талаарх нэгдсэн дүгнэлт

гаргаж, цаашид авах арга хэмжээний саналын хамт 04 дүгээр сарын 10-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ.

17.4.Тамгын газар энэ хуулийн 17.3-т заасан дүгнэлт, санал гаргахад нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл Засгийн газар болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох мэдээллийг ажлын 5 өдрийн дотор авна.

17.5.Төрийн аудитын байгууллага төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, жил бүрийн 03 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.

17.6.Улсын Их Хурал Засгийн газраас ирүүлсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг энэ хуулийн 17.5-д заасан аудитын тайлан, 17.3-т заасан дүгнэлт, саналын хамт хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа Засгийн газрын үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт өгч, хэрэгжиж буй жилийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эсхүл холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар Засгийн газарт тогтоолоор үүрэг, чиглэл өгнө.

18 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

18.1.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /цаашид “үндсэн чиглэл” гэх/-ийн гүйцэтгэл, үр дүнг дуусгавар болох оны 6 дугаар сарын 20-ны дотор, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн гүйцэтгэл, үр дүнг дуусгавар болох оны 05 дугаар сарын 15-ны дотор дараах хүрээнд хэлэлцэнэ:

18.1.1.үндсэн чиглэл болон хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх;

18.1.2.үндсэн чиглэл болон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүн нь дунд хугацааны баримт бичгийн хэдэн хувьд хүрснийг;

18.1.3.хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үр дүн;

18.1.4.үндсэн чиглэл болон хөтөлбөр хоорондын төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа;

18.1.5.түхэйн бодлогын баримт бичгийн хэрэгжээгүй зорилго, зорилтын шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээ.

18.2.Засгийн газар хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гүйцэтгэлийн тайлангийн хамт дуусгавар болох жилийн 04 дүгээр сарын 01-ний дотор, үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнгийн тайлан, болон холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гүйцэтгэлийн тайлангийн хамт дуусгавар болох жилийн 04 дүгээр сарын 05-ны дотор Улсын Их Хурал, Төрийн аудитын дээд байгууллагад тус тус ирүүлнэ.

18.3.Төрийн аудитын дээд байгууллага үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайланг тухайн жилийн 05 дугаар сарын 30-ны дотор, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайланг тухайн жилийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.

18.4.Тамгын газар үндсэн чиглэл, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд энэ хуулийн 18.1-д заасан хүрээнд дүн шинжилгээ хийх бөгөөд Засгийн газраас ирүүлсэн тайлан, холбогдох мэдээллийг хянан үзэж, нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл мэдээллийг ажлын 5 өдрийн дотор авна.

18.5.Тамгын газар үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн дүн шинжилгээг тухайн жилийн 06 дугаар сарын 15-ны дотор, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн шинжилгээг тухайн жилийн 05 дугаар сарын 10-ны дотор гишүүдэд хүргүүлнэ.

18.6.Улсын Их Хурал хөтөлбөрийн болон үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнгийн тайланг энэ хуулийн 18.3-т заасан тайлан, 18.5-д заасан дүн шинжилгээний хамт хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

#### 19 дүгээр зүйл.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

19.1.Улсын Их Хурал хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнг тухайн баримт бичиг дуусгавар болохоос зургаан сарын өмнө дараах хүрээнд хянан хэлэлцэнэ:

19.1.1.хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх;

19.1.2.хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны үр дүн;

19.1.3.хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл нь урт хугацааны хөгжлийн бодлогын холбогдох зорилгын хэдэн хувьд хүрсэн, тэдгээрийн үялдаа;

19.2.Засгийн газар хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнгийн тайлан болон холбогдох хяналт-шинжилгээний тайланг Улсын Их Хурал хэлэлцэхээс гурван сарын өмнө Улсын Их Хурал, Төрийн аудитын дээд байгууллагад тус тус ирүүлнэ.

19.3.Тамгын газар хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд энэ хуулийн 19.1-д заасан хүрээнд дүн шинжилгээ хийж, Улсын Их Хурал хэлэлцэхээс 15 өдрийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

19.4.Тамгын газар хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан тайлан, үр дүнд дүн шинжилгээ хийхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас мэдээллийг ажлын 10 өдрийн дотор гаргуулан авна.

19.5.Төрийн аудитын дээд байгууллага хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайланг Улсын Их Хурал хэлэлцэхээс нэг сарын өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ. Хэрэв хөгжлийн зорилтот хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг аудитын тайландаа тусгана.

19.6.Улсын Их Хурал хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

#### 20 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

20.1.Улсын Их Хурал Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (цаашид “урт хугацааны хөгжлийн бодлого” гэх)-ын гүйцэтгэл, үр дүнг тухайн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас хоёр жилийн өмнө хянан хэлэлцэнэ.

20.2.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнг зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг зорилго, зорилт бүрээр хянан хэлэлцэнэ.

20.3.Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний хамт Улсын Их Хурал хэлэлцэхээс нэг жилийн өмнө Улсын Их Хурал болон Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлнэ.

20.4.Тамгын газар энэ хуулийн 20.3-т заасан тайланд энэ хуулийн 20.3, 20.7-д заасан тайланд тулгуурлан дүн шинжилгээ хийж, Улсын Их Хурлаар хэлэлцэхээс 45 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

20.5.Тамгын газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэл, үр дүнд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг Засгийн газар, түүний яам, агентлаг нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй.

20.6.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэл, үр дүнд аудит хийж, Улсын Их Хурлаар хэлэлцэхээс гурван сарын өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.

20.7.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт бүрэн хэрэгжээгүй, шалгуур үзүүлэлтээ бүрэн хангаагүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг тайландаа тусгана.

20.8.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнгийн талаар тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

**20.9.Энэ хуулийн 17-20 дугаар зүйлд заасан тайланд дүн шинжилгээ хийх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.**

**21 дүгээр зүйл.Төсвийн хяналтын зарчим, төрөл**

21.3.1.нэг, хөөр дахь **дэх** хэлэлцүүлгийн үе шатны хяналт;

21.3.2.гурав **хоёр** дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт.

**23 дугаар зүйл.Төсвийн төслийн нэг, хөөр дахь дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт**

*[/Энэ зүйлийн гарчигт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

23.1.Төсвийн төслийн нэг, хөөр дахь **дэх** хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавина: *[/Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

23.1.1.төсвийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;

23.1.2.Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх;

23.1.3.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал **хөөр дахь нэг дэх** хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.

*[/Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

**23.6.Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлалыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.**

**24 дүгээр зүйл.Гурав-Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт**

*[/Энэ зүйлийн гарчигт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

24.1.Гурав **Хоёр** дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнд тавих хяналтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

*[/Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

24.2.Гурав дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэхэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн шатанд уг дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ **Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргаж олонхын дэмжлэг авсан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэхэд Тамгын газар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, нэгдсэн хуралдааны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд уг дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.**

*[/Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)*

24.3.Гурав **Хоёр** дахь хэлэлцүүлгийн үе шатанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн байнгын хороог шаардлагатай тооцоо, мэдээллээр хангаж ажиллана.

### **30 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонголт**

~~30.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонголт явуулна:~~

~~30.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, дэд дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонголт;~~

~~30.1.2.Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонголт явуулахаар хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонголт явуулахаар Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.~~

**30.1.Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилохдоо нэр дэвшигчийн сонголт явуулна.**

### **ДОЛДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО**

**Нэгдүгээр дэд бүлэг  
Хянан шалгах түр хорооны эрх зүйн байдал**

### **32 дугаар зүйл.Хянан шалгах түр хороог байгуулах, татан буулгах**

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан асуудлаар Улсын Их Хуралд тогтоолын төсөл өргөн мэдүүлэх бөгөөд уг гаргасан саналд Улсын Их Хурлын тогтоолын төслийг хавсаргана. Уг тогтоолын төсөлд хянан шалгах түр хороо /цаашид энэ бүлэгт “түр хороо” гэх/-ны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана.

~~32.3.Тогтоолын төслийг энэ хуулийн 32.2-т заасны дагуу өргөн мэдүүлсэн бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан дэгийн дагуу чуулганы хуралдааны заасан тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллыг харгалзахгүйгээр даруй хэлэлцэж, түр хороо байгуулах тогтоол батална.~~

32.4.Тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар ~~Үндсэн хуульд харширсан эсэх~~ талаар санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд оруулна.

~~32.5.Улсын Их Хурал тогтоолын төсөлд тусгасан түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг зөвхөн дараах үндэслэлээр өөрчилж болно:~~

~~32.5.1.Үндсэн хуульд харширсан гэж холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт гарсан;~~

~~32.5.2.санаачлагч гишүүд санал нэгдэн зөвшөөрсөн.~~ Улсын Их Хурал тогтоолын төслийн хэлэлцүүлгийн шатанд санаачлагч гишүүд бүгд зөвшөөрснөөр түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг нарийвчлан тодорхойлж болно.

~~32.6.Түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг өөрчлөхөөр бол өнө хуулийн 32.5-д заасан үндэслэлээр Улсын Их Хурлын тогтоолоор өөрчилнө.~~

32.7.Түр хороог зургаан сар хүртэл хугацаагаар байгуулна. Шаардлагатай бол мөн хугацаагаар нэг удаа сунгаж болно болох бөгөөд хянан шалгах түр хорооны ажиллах хугацаанд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрх дуусгавар болсон бол түр хороог татан буугдсанд тооцно.

32.8.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28.5-д заасан үндэслэлээр түр хороог байгуулахгүй. Түр хороог дараах тохиолдолд байгуулахгүй:

32.8.1.Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусахад зургаан сараас бага хугацаа үлдсэн бол;

32.8.2.тухайн асуудлаар хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол;

32.8.3.яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбогдсон асуудлаар;

32.8.4.татан буугдсанд тооцсоноос хойш нэг жилийн хугацаа өнгөрөөгүй бол.

32.9.Түр хороо нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг энэ хуулийн 34.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар хянан шалгаж, дүнг тогтоосон хугацаанд Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй.

32.10.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хянан шалгах түр Хянан шалгах түр хороо шалгалтаар цуглуулсан нотлох баримтад үндэслэсэн тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах бөгөөд тайлангаа танилцуулснаар үг хороог татан буугдсанд тооцно.

32.11.Түр хороо ~~/цаашид энэ бүлэгт “түр хороо” гэх/~~ны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах Улсын Их Хурлын эрх хэмжээний хүрээнд байна. Түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно.

**32.12.Тухайн ээлжит чуулганы хугацаанд хоёр хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах түр хороо байгуулах саналыг дараагийн ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлсэн дарааллаар хэлэлцэнэ.**

**32.13.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй.**

### **33 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн**

33.4.~~Гишүүн тусгай шалгалттай холбоотой асуудлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол уг гишүүнийг түр хорооны бүрэлдэхүүнд оруулахыг хориглоно.~~**Түр хорооны бүрэлдэхүүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчилгүй гишүүн орно.**

33.5.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.1, 10.2-т заасан олонх, 10.3-т заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 33.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах, тусгай шалгалттай холбоотой асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн нэрийг ~~өөрөө~~ тогтоож, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг ~~өөрчлөхгүйгээр~~ хэлэлцэнэ. **гишүүдийнхээ нэрийг холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.**

33.8.~~Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.~~**Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг, уг гишүүн өөрөө татгалзвал түр хорооны бусад гишүүдийн дотроос хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.**

*[/Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)*

### **34 дүгээр зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэн эрх**

34.1.Түр хороо нь Байнгын хорооны **Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.3, 22.3.6, 22.3.8-д заасан** нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1.доор дурдсан аргаар нотлох баримт цуглуулах:

үнэлэх; 34.1.1.а. нотлох баримтыг **нийтийн** сонсголоор шинжлэн судалж,  
34.1.1.б. төрийн байгууллагаас нотлох баримт гаргуулж авах;  
34.1.1.в. нотлох баримт гаргаж өгөх тухай хүсэлт гаргах;  
34.1.1.г. нотлох баримт гаргаж өгөхийг хүн, хуулийн этгээдээс  
шаардах;  
34.1.1.д. гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг, **тайлбар** авах, асуулт  
тавих;  
~~34.1.1.е. шинжээч, хянан шалгагч, томилөх, тайлбар, мэдүүлэг  
авах;~~  
34.1.1.ё. нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл  
үйлдэх.

34.1.2. хянан шалгагч томилөх, **шинжээч томилох, тайлбар, мэдүүлэг  
авах;**

34.1.3. баримт бичигт дүн шинжилгээ хийх;  
34.1.4. тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах;  
34.1.5. энэ хуульд заасныг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан  
этгээдэд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд  
холбогдох саналаа хүргүүлэх.

~~34.1.6. хуульд заасан бусад.~~

### **35 дугаар зүйл. Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт**

35.4. Түр хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Түр хороо зөвхөн өөрийн  
үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой асуудлаар тогтоол батална. **Түр  
хороо нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тов, дараалал, сэдэв,  
хөтөлбөр батлах, түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг батлах, түр хорооны  
төсөв батлах, түр хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, ажлын удирдамж  
батлах зэрэг зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой  
асуудлаар тогтоол батална.**

35.7. Түр хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.7.1. түр хорооны үйл ажиллагааг зохион байгуулах, уялдуулан  
зохицуулах;

35.7.2. түр хорооны хуралдаан, сонсголыг даргалах, хуралдааны  
тэмдэглэлийг баталгаажуулах;

35.7.3. түр хорооны хуралдаан, сонсголын бэлтгэлийг хангуулах,  
шийдвэрийг баталгаажуулах, түүний биелэлтэд хяналт тавих;

~~35.7.4. түр хорооноос эрх олгосны дагуу нотлох баримтыг шинжлэн  
судлах сонсголд нэмж дуудах гэрчийн нэрсийг сонсголд болохоос долоогоос доошгүй  
хөногийн өмнө шийдвэрлэх;~~

**35.7.5. түр хороог төлөөлөх төлөөлж холбогдох байгууллага, албан  
тушаалтантай харилцах.**

### ~~35.7.6.энэ хуульд заасан бусад үүрэг.~~

**35.8.Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах, шинжээч, хянан шалгагчаар томилогдсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.**

## **Хоёрдугаар дэд бүлэг Нотлох баримт**

### **36 дугаар зүйл.Нотлох баримт**

36.2.“Баримтат мэдээлэл”-д гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, хянан шалгагчийн тайлан, дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, холбогдох байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт мэдээлэл, **цахим мэдээллийн сангийн баталгаажсан лавлагаа**, баримт бичиг, бичгийн хэлбэртэй бусад баримт, хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, хэрэв тухайн асуудлаар өмнө нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулсан бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, энэ хуульд заасны дагуу цуглуулсан бусад баримт хамаарна.

**37 дугаар зүйл.Хянан шалгах Нотлох баримт цуглуулахтай холбоотой түр хорооны шийдвэр**

### **38 дугаар зүйл.Гэрчээр дуудах**

38.1.“Гэрч” гэж тусгай шалгах асуудал, үйл баримтыг нягтлан тодруулахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ.

38.4.Түр хороо гэрчээр дуудах тухай мэдэгдэх хуудсыг гэрчид сонсгол эхлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хүргүүлэх үүрэгтэй. Гэрчээр дуудах тухай мэдэгдэлд тусгай шалгалтын сэдэв, ~~мэдүүлэг авах асуудал~~ **тухайн гэрчид шүүд холбогдох асуудал**, сонсгол болох он, сар, өдөр, цаг, минут, газар, эрх зүйн туслалцаа авах болон бусад эрх, үүрэг, мэдүүлэг өгөөгүй буюу зайлсхийсний улмаас үүсэх үр дагаврын талаар тусгана.

### **39 дүгээр зүйл.Хянан шалгагчийг томилох**

39.1.~~Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хянан шалгагчийг томилж, ажлын даалгаврыг батална.~~ **Түр хорооны гишүүдийн саналыг харгалзан хянан шалгагчийг нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилж, ажлын даалгаврыг батална. Хянан шалгагч түр хороо татан буугдах хүртэл ажлын даалгаварт заасан үүргээ биелүүлж ажиллана. Хянан шалгагчаар ажиллуулах саналыг энэ хуулийн 7.2-д заасан байгууллагаас авч болно.**

39.2.Хянан шалгагч сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй, **тухайн асуудлаар**

**мэргэшсэн**, мэргэжлийн дүгнэлт гаргах чадвартай, гурваас доошгүй жил тухайн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан туршлагатай Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна.

39.3.Хянан шалгагч энэ хуулийн 39.1-д заасан даалгаврын хүрээнд дараах ажиллагааг хараат бусаар явуулах бүрэн эрхтэй:

- 39.3.1.шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх;
- 39.3.2.нотлох баримт гаргаж өгөхийг шаардах;
- 39.3.3.тухайн асуудалд холбогдох этгээдээс тайлбар авах;
- 39.3.4.нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэх;
- 39.3.5.сонсголд оролцох гэрчийн нэрсийг **тухайн гэрчид шууд**

**холбогдох асуудал бүрээр** шинжээчтэй хамтран гаргаж, сонсгол болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө түр хороонд танилцуулж, шийдвэрлүүлэх;

39.3.6.баримт бичигт дүн шинжилгээ хийх, ~~тайлан гаргах.~~;

**39.3.7.хяналт шалгалтын дүнгийн тайлан гаргах.**

39.6.Хянан шалгагч тусгай шалгалтын дүнд үндэслэн тайлан бичгээр гаргаж, сонсголд амаар **энэ хуулийн 39.3.7-д заасан тайланг бичгээр гаргаж, сонсголд биечлэн оролцож**, танилцуулах бөгөөд уг тайлантай танилцах боломжийг түр хорооны гишүүн бүрд олгоно. Түр хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг тайланд тусгаж болно.

39.7.Хянан шалгагч энэ хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бол түр хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар түүнийг **өгцруулна огцруулж, энэ хуулийн 7.6-д зааснаар байгуулсан гэрээний хариуцлага хүлээлгэнэ.**

~~39.10.Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах, шинжээч, хянан шалгагчаар томилогдсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах, сонгож журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.~~

**39.11.Хяналт шалгагч энэ хуулийн 39.3-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, нотлох баримтыг бүрүүлэх, үнэлэхэд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг жишиг болгоно.**

#### **40 дүгээр зүйл.Шинжээч томилох**

40.1.Түр хороо тусгай шалгалтын явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлаар дүгнэлт гаргуулахаар уг асуудлаар мэргэшсэн, хувийн ашиг сонирхлын зөрчилгүй хувь хүн болон төрийн албан хаагчийг шинжээчээр томилох бөгөөд дүгнэлт гаргах хугацааг тухайн шинжээчтэй тохиролцон тогтоож, ажлын даалгаврыг батална. **Түр хороо хянан шалгагчийн санал болгосноор тусгай мэргэжлийн шинжээч томилон ажиллуулж, дүгнэлт гаргуулж болно.**

40.2.Шинжээч тогтоосон хугацааны дотор тухайн асуудлыг тал бүрээс нь бүрэн, бодитой, хараат бусаар шинжилж, **тавьсан асуулт нэг бүрээр** үнэн зөв дүгнэлтийг бичгээр гаргах бөгөөд Түр хороо хүсэлт тавибал сонсголд биечлэн оролцож амаар мэдүүлэг өгнө.

~~40.3.Шинжээч энэ хуулийн 38.8-д заасан үндэслэлээр дүгнэлт гаргахаас татгалзаж болно.~~

~~40.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол шинжээчийг дуудан ирүүлэх болон холбогдох бусад харилцаанд энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмыг баримтална.~~

40.5.Шинжээч түр хорооны өмнө ажлаа хариуцах бөгөөд олон нийтэд зориулсан мэдээлэл хийхгүй. Шинжээчид энэ хуулийн ~~39.8, 39.9, 39.10~~ 35.8, 39.8, 39.9 дахь заалт нэгэн адил хамаарна.

## **Гуравдугаар дэд бүлэг** **Хяналт шалгалтын Хянан шалгах түр хорооны сонсгол**

### **44 дүгээр зүйл.Нотлох баримтыг сонсох**

~~44.3.Нотлох баримтыг сонсгох ажиллагаанд энэ хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хяналтын сонсгол зохион байгуулах журмыг баримтална.~~

44.3.Нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол /цаашид “сонсгол” гэх/- д дараах журмыг баримтална:

#### 44.3.1.сонсголыг дараах дарааллын дагуу явуулна:

44.3.1.а.сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах;

44.3.1.б.энэ хуулийн 39.3.6-д заасан хянан шалгагчийн дүн шинжилгээ, тайланг сонсох;

44.3.1.в.шинжээчийн дүгнэлтийг сонсох;

44.3.1.г.эрх ашиг нь хөндөгдөж буй, иргэн хуулийн этгээд, эсхүл холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны мэдээлэл сонсох;

44.3.1.д.даргалагч шаардлагатай гэж үзсэн бол хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэвтэй холбогдуулан бичгээр ирүүлсэн мэдээллийн агуулгыг уншиж танилцуулах;

44.3.1.е.даргалагч болон гишүүд сонсголд хянан шалгагч, шинжээч, гэрчээс асуулт асууж, хариулт авах.

44.3.2.Сонсголын явцад сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахыг хориглоно.

44.3.3.Энэ хуулийн 44.3.1.б, 44.3.1.в, 44.3.1.г-д заасан дүн шинжилгээ, тайлан, дүгнэлт, мэдээллийг тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд танилцуулна.

44.3.4.Гэрчээс асуулт асуух, хариулт авах хугацаа 30 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно. Гишүүний асуулт, гэрчийн хариултын хугацааг тэнцвэртэй хуваарилна.

44.3.5.Даргалагч гэрчид энэ хуульд заасан эрхийг танилцуулж, асуултад хариулах боломжоор хангана.

44.3.6. Сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулахтай холбоотой бусад харилцаанд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан холбогдох журмыг баримтална.

**Гуравдугаар дэд бүлэг**  
**Хяналт-шалгалтын Хянан шалгах түр хорооны сонсгол**

**47 дугаар зүйл. Сонсголд оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах, дэг сахиулах**

47.3. Сонсгол даргалагч сонсголын дэг сахиулах бөгөөд дэг зөрчигчид сануулах, үг, үйлдлийг таслан зогсоох, шаардлагатай гэж үзвэл танхимаас гаргана.

47.4. Сонсголд гэрчээр дуудагдсан этгээдэд асуултад бүрэн хариулж, тайлбар өгөх эрхтэй.

**49 дүгээр зүйл. Гэрчийн мэдүүлэг сонсох**

49.7. Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын үеэр гэрчийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахыг хориглоно.

49.7. 49.8. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэрчээс мэдүүлэг авахтай холбогдсон бусад харилцаанд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг жишиг болгоно.

**Дөрөвдүгээр дэд бүлэг**  
**Хянан шалгах түр хорооны хуралдаан, тайлан, санал, дүгнэлт, зардал**

**55 дугаар зүйл. Түр хорооны тайлан**

55.1. Түр хороо нь сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн гаргасан сонсголын тайлан, санал, дүгнэлт, шаардлагатай бол хөлбөгдөх шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд танилцуулна. шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулна. Хэрэв түр хороо шийдвэрийн төсөл боловсруулсан бол холбогдох Байнгын хороогоор үг Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж санал, дүгнэлт гаргуулна.

55.2. Тайланд тусгай шалгах ажиллагааны агуулга, цуглуулсан нотлох баримт, тогтоогдсон үйл баримт, тусгай шалгалтын дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл хөлбөгдөх саналыг багтаана. Нэгдсэн хуралдаанд түр хороо энэ хуулийн 55.1-д заасан тайлан, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг, холбогдох Байнгын хороо түр хорооны тогтоолын төслийн талаарх санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна. Тайланд тусгай шалгах ажиллагааны агуулга, тогтоогдсон үйл баримт, тусгай шалгалтын дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл холбогдох тайлбар, мэдээлэл, саналыг багтаана.

55.7. Түр хорооны тайланг эцэслэснээс хойш 14 хоногийн дотор тусгай санал, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, бичмэл нотлох баримтын хамт мэдээллийн нэгдсэн санд байршуулна. Түр хорооны тайланг нэгдсэн хуралдаанд

танилцуулснаас хойш 14 хоногийн дотор мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

## **56 дугаар зүйл. Түр хорооны зардал**

~~56.1. Түр хорооны тусгай шалгах үйл ажиллагаатай хөлбөгдөн гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.~~ Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусган санхүүжүүлнэ.

**56.2. Түр хорооны зардлын төсвийг Улсын Их Хурлын батлагдсан төсөвт багтаан түр хороо төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.**

~~56.3. Шинжээч, хянан шалгагчийн ажлын хөлс, гэрч дуудах болон тусгай шалгалттай хөлбөөтэй бусад зардлын хэмжээг батлагдсан төсөвт багтаан түр хороо төгтөөнө.~~ Улсын Их Хурлын төсвийн шууд захирагч батлагдсан төсөвтөө багтаан хянан шалгах түр хорооны даргын саналыг харгалзан хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулна.



**II.**  
**ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА**



## 2.1. Парламентын хяналтын үр ашигтай зохицуулалтын механизмыг бүрдүүлэх чиглэлээр Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ны зөвлөмж

**Эх сурвалж:** Global Parliamentary report-2017: Parliamentary oversight - Parliament's power to hold government to account. IPU and UNDP, 2017.

№	Парламентын хяналтын механизмын бүрдэл хэсгүүд	Бусад орнуудын сайн туршлага, ОУПХ-ноос гаргасан зөвлөмж, нийтлэг жишиг
<b>1.1. Парламентын хяналтын эрх мэдэл</b>		
<p><b>Судалгааны дүгнэлт:</b> Сайн засаглалыг хөгжүүлэх, ардчиллыг бэхжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт тавихын тулд Парламент нь мандатын болон хуулиар олгогдсон бүрэн эрхтэй, эрхээ хэрэгжүүлэх бодлого, зохицуулалттай байх шаардлагатай.</p>		
1.1.1	<p>Парламентаас Засгийн газарт хяналт тавих мандатын онцгой бүрэн эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байх.</p> <p>Парламент ба Засгийн газрын хяналт, тайлагналын ялгаатай үүргийг зааглаж, Засгийн газар нь иргэдэд үйлчлэх, Парламент нь түүний үйл ажиллагаанд хяналт тавьж асуух, шалгах, чиглэл өгөх, хариуцлага тооцох эрхтэй байх</p>	<p>Хяналт ба тайлагналын систем нь хоорондоо уялдаа холбоо бүхий дараах 3 цогц үүргийн нэгдэл байх ёстой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газар болон төрийн байгууллагууд нь гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа үр дүнг Парламент болон ард түмэнд тайлагнах;</li> <li>• Парламент нь Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрт дүн шинжилгээ хийж үндэслэл бүхий цагаа олсон зөвлөмж өгөх;</li> <li>• Засгийн газар нь Парламентаас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмжийг биелүүлж, үр дүнг эргэн тайлагнах.</li> </ul>
	<p>Парламентхяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хангалттай эрх мэдэл ба чадамжтай байх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хуулиар мандат олгогдсон байх;</li> <li>• Шаардагдах санхүү, хүний нөөц, зохион байгуулалтын институционал бүтэцтэй байх;</li> <li>• Засгийн газраас хараат бусаар хяналт хэрэгжүүлэх чадамжтай, Үндсэн хуулиар олгогдсон засаглалын хяналт тэнцлийг хангах нөхцөл бүрдсэн байх.</li> </ul>
	<p>Парламентын хяналтын арга хэрэгсэл ба процессын механизм бүрдсэн байх</p>	<p>Парламент дотооддоо Засгийн газарт хяналт тавих улс төрийн болон процессын архитектуртай байх шаардлагатай. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын сайд нарт тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилттэй холбоотой асуудлаар (үүнд төсвийн асуудал хамаарна) амаар болон бичгээр асуулга, асуулт тавих;</li> <li>• Хариуг Байнгын хороонд сонсох, шийдвэрт өөрчлөлт оруулах, зөвлөмж өгөх, иргэдийн санаа бодлыг сонсох,</li> </ul>

		хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх гэх мэт.
	Парламентын гишүүдийн хяналтын эрх үүрэг хангагдсан байх	Парламентын гишүүд ард түмнээс сонгогдож, нийтийн эрх ашгийг төлөөлж байгаагийн хувьд тэдний нэрийн өмнөөс гүйцэтгэх засаглалд хяналт тавих Үндсэн хуулиар олгогдсон мандатын эрхтэй байх ёстой.
	Парламентын хяналтын хүрээг тодорхойлсон байх	Парламентын хяналтын цар хүрээний хувьд, Засгийн газар болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаа (хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, төсвийн хэрэгжилт)-нд хяналт шалгалт хийх, үр дүнг нягтлан шалгах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Өөрөөр хэлбэл, Парламентаас бодлого, хөтөлбөр, төсөв зэрэг хууль ёсны салбараас гадна иргэдэд өдөр тутмын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагуудыг хянах эрхтэй байдаг. Зарим оронд Байнгын хороод иргэний нийгэм, академи, хувийн сектор зэрэг олон төрлийн субъектүүдээс баримт нотолгоо бүхий мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх эрхтэй байдаг. Иймээс парламентын хяналтын хууль ёсны хүрээг аль болох өргөнөөр тогтоох, парламентын хяналтаас гадуур нэг ч секторыг үлдээхгүй, ялангуяа үндэсний хэмжээний онцгой, гамшгийн нөхцөл байдал үүссэн ямар ч цаг үед Парламентаас хяналтаа хэрэгжүүлэх чадамжтай байх нь чухал.
	Парламентын хяналтад оролцогчид	Парламент Засгийн газрын үйл ажиллагаанд дангаар дүн шинжилгээ хийж чадахгүй. Тиймээс Парламентад хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналтын мэдээллийн санд нэвтрэх, салбар дундын болон мэргэшсэн хяналтын чиг үүрэг бүхий Засгийн газраас хараат бус бие даасан омбудсмэн, комисс, зохицуулах хороод, аудитын байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд зэрэг субъектүүдтэй хамтран ажиллана.
1.1.2	Үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бий болгох шаардлага	Хууль тогтоох үйл ажиллагааны чанарыг сайжруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх шатанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ардчиллыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжил, хүний эрхийн хамгаалалтыг сайжруулж авилгыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах гэх мэт зорилтуудад парламентын хяналт чиглэх ба эцсийн дүндээ бодлогын үр нөлөөг сайжруулах, ардчиллын хөгжилд ахиц гаргах зорилготой.
1.1.3	Парламентын хяналтыг парламентын үндсэн функцуудтай уялдуулах	<ul style="list-style-type: none"> <li>• Төлөөллийн мандат авсан Парламентын гишүүн иргэдийн оролцоо, хяналтыг хангаж олон нийтийн санаа бодолд тулгуурлан хяналтын үүргээ биелүүлэх;</li> <li>• Хууль тогтоох хүрээнд хуулийн хэрэгжилтийн явцад гарч байгаа хийдэл, зөрчлийг арилгаж хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль хэрэгжүүлэх, зөрчлийг арилгуулах чиглэлээр Засгийн газарт шаардлага тавьж ажиллах;</li> <li>• төсвийн хяналтын хүрээнд Засгийн газарт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь зориулж хуваарилсан төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулсныг Парламент хянах ёстой. Жилийн төсөв, мөнгөний бодлого, төсвийн бодлого, банкны сектор, татвар, төгрөгийн худалдан</li> </ul>

		авах чадвар зэргийг Парламентаас хянах механизмтай байх шаардлагатай.
1.1.4	Парламентын хяналтыг урт хугацааны хөгжлийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангах тэргүүлэх чиглэл болгон авч үзэх	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний хөгжлийн бодлогын зорилтууд хэрхэн хэрэгжиж байгааг урт, дунд, богино хугацаанд нь уялдуулан нэгтгэн тайлагнах хууль зүйн механизм бүрдүүлэх;</li> <li>• “Дэлхийн тогтвортой хөгжлийн бодлогын зорилтууд-2030” гэх мэт бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хяналтыг Парламентаас хэрэгжүүлж улс орныг урт хугацааны нийгэм-эдийн засгийн хөгжилд хөтлөх;</li> <li>• Тогтвортой хөгжил, жендэрийн тэгш байдлыг тэргүүлэх чиглэл болгох.</li> </ul>
1.1.5	Парламентын хяналтын бодлого	<p>Институциональ бүтэц:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн хуулиар засаглалын эрх мэдлийн хуваарилалт, Парламент болон Засгийн газрын эрх үүрэг, зааг ялгааг тодорхойлсон байх;</li> <li>• Парламент нь хяналтын бүрэн эрхээ Засгийн газраас хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн болон институцийн чадамжтай байх;</li> <li>• Улс төрийн намууд, Парламентад суудалтай сөрөг хүчний зүгээс Засгийн газарт хяналт тавих эрх, боломж хангагдсан байх;</li> <li>• Парламент болон Засгийн газар хоорондын хяналтын механизм бүрдсэн байх;</li> <li>• Олон нийтийн зүгээс Парламентын үйл ажиллагаанд итгэлтэй байх, нийтийн эрх ашгийн үүднээс Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, авилгал, хүний эрхийн зөрчил, тэгш бус байдлыг таслан зогсоож эдийн засаг, нийгэм, хувь хүний хөгжлийг хангана гэдэгт итгэлтэй байх.</li> </ul>
1.1.6	Парламентын хяналтад тулгарч буй асуудлууд	Гишүүдийн үг хэлэх, үйл ажиллагаа явуулах эрх чөлөө, Парламент доторх олонх-цөөнх, эрэгтэй-эмэгтэй гишүүдийн оролцооны тэгш байдлыг хангах шаардлагатай.
<p><b>1.2. Парламентын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь</b></p> <p><b>Судалгааны дүгнэлт:</b> Парламентын хяналтыг үр нөлөөтэй явуулахад хууль ёсны эрх үүргээс гадна хяналтыг үр ашигтай хэрэгжүүлэх тогтолцоо, чадавх чухал юм. Тухайлбал: Засгийн газраас хараат бусаар ажиллахад хүрэлцээтэй төсөв, мэргэшсэн ур чадвартай ажилтнууд, үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь авах мэдээллийн сан болон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнуудын чадавхыг бүрдүүлэх шаардлагатай. Ингэснээр Парламентын хяналт мэргэшсэн, олон нийтийн итгэл даахуйц хэмжээнд явагдана.</p>		
1.2.1	Парламентаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрхүүдийг хуулиар баталгаажуулах	<ol style="list-style-type: none"> <li>1. Үндсэн хуулиар баталгаажсан эрх</li> <li>2. бусад хуулиар олгосон эрх</li> <li>3. Дэгийн тухай хуулийн зохицуулалт</li> <li>4. практик үйл ажиллагаа</li> </ol> <p>Мэдээлэл авах эрх, мандатын эрхээ хэрэгжүүлэх журам, дэг тодорхой байх, маргаан шийдвэрлэх чадамж, ил тод байдал, хуулийн зохицуулалт, төсвийн нөлөөлөл, хариуцлагын санкц зэргийг журамлах шаардлагатай.</p>
1.2.2	Парламентын хяналтыг Засгийн газраас хараат	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газраас санхүүгийн хувьд хараат бус байх;</li> <li>• Парламент өөрийн төсвөө батлах эрхтэй байх;</li> </ul>

	бусаар явуулах чадавх бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Хараат бус мэргэшсэн ажилтнуудтай байх (хяналтыг журмын дагуу явуулах, шаардлагын дагуу процессыг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, хуулийн төсөл бэлтгэх экспертийн түвшний мэдлэг, ур чадвартай улс төрийн нөлөөнөөс ангид төвийг сахисан үйл ажиллагаа явуулах ажилтнууд);</li> <li>Мэдээлэл авах эрхтэй байх (шаардлагатай мэдээллийг гаргуулж авах, мэдээллийн санд нэвтрэх эрх, Засгийн газрын нэгжүүдийн жилийн тайлан, мэдээ гэх мэт);</li> <li>Парламент нь мэдээлэл, судалгааны үйлчилгээгээр хангагдах, номын сан-мэдээллийн төв, судалгааны алба, төсвийн болон жендэрийн анализ хийх албатай байх.</li> </ul>
1.2.3	Парламентын гишүүд хяналтын чиглэлээр хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, чадавхтай байх, оролцоо баталгаажсан байх	<ul style="list-style-type: none"> <li>Гишүүд дотроо хяналтын үүргээ хамтран хэрэгжүүлэх;</li> <li>Гишүүд мэдээлэл авах сүлжээтэй, иргэний нийгмийн экспертүүдтэй ойр хамтран ажилладаг, хяналтыг үр ашигтай хэрэгжүүлэх арга зүй, ур чадварыг эзэмшсэн байх;</li> <li>Гишүүд аналитик дүн шинжилгээ хийх, хяналтын үүргээ хэрэгжүүлэх ур чадвараа хөгжүүлэх, сургалтад хамрагдах.</li> </ul>
1.2.4	Парламентын хяналтын соёлыг бий болгож төлөвшүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Парламентын хяналтын үр дүн, ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах;</li> <li>Хяналтын чиглэлээр хамтран ажиллаж байгаа байгууллагуудаа олон нийтэд таниулах.</li> </ul>
1.2.5	Парламентын хяналтын хэрэгжилтэд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах тогтолцоотой байх	Парламент болон Парламентын гишүүд хяналтын үүргээ хэрхэн биелүүлснээ иргэдийн өмнө тайлагнана. Парламентын хяналтын үйл ажиллагаа тасралтгүй, тууштай, ул суурьтай, баримт нотолгоонд суурилсан байдлаар явагдах шаардлагатай. Иймд парламентын хяналтын үйл ажиллагаанд дотоод мониторинг, үнэлгээ хийдэг байх.
<p><b>1.3. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх нь</b></p> <p><b>Судалгааны дүгнэлт:</b> Парламентын хороод нь парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд болон дүн шинжилгээ хийх чадавхтай байх. Ингэхдээ аль болохоор Засгийн газар болон Парламент дахь улс төрийн намын удирдлагуудаас хараат бус ажиллах боломжтой байх. Хороодын хяналтын мандатын эрх, чиг үүрэг тодорхой байх, хуулиар баталгаажсан байх, хяналт шалгалтын үр дүнг хороод болон Парламентын чуулганаар хэлэлцдэг байх соёлыг бий болгох шаардлагатай. Мөн Парламентын хянан шалгах тусгай хороо байгуулах, хүний эрхийн зөрчил, авилгал, Засгийн газрын үүргийн биелэлт зэрэг онцлох асуудлуудаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж олон нийтийн санаа бодлыг сонсох эрхтэй байх. Хороод нь хяналтыг үр нөлөөтэй явуулах чадвартай, зөвхөн баримт нотолгоо цуглуулах биш олон нийтийн дэмжлэг, оролцоог хангах, ил тод мэдээлэл, гаргасан зөвлөмжийнхөө биелэлтийг хангуулах чадавхтай байх.</p>		
1.3.1	Цөөнхөд боломж олгох (Opportunities for opposition)	<ul style="list-style-type: none"> <li>Хяналтын чиг үүрэгтэй хороог цөөнхийн төлөөллөөр удирдуулах;</li> <li>Нэгдсэн хуралдаан дээр “сөрөг хүчин”-д асуулт, хэлэлцүүлгийн тусгайлсан цаг гаргах;</li> <li>Төсвийн хэлэлцүүлэг болон сайд нарын асуулт хариултыг сонсох үед “хариулах эрх”-ийг ашиглах;</li> <li>Байнгын хороодын тайланд хавсаргах, ажлын хэсэгт оруулах гэх мэт.</li> </ul>

1.3.2	<p>Парламентын байнгын хороо (Permanent oversight committees)</p>	<p>Байнгын хороодын хяналт бол парламентын хяналтыг хэрэгжүүлэх гол арга хэлбэр. Олон улсад хороодын олон янзын хэлбэр байх ч тэдгээрээс парламентын хяналтын мандатын эрхтэй хороод нь баримтад тулгуурлан Засгийн газарт асуулга тавих, дүгнэлт зөвлөмж гаргах, Парламент болон олон нийтэд танилцуулах эрхтэй.</p> <p>Парламент болон Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд хяналт явагдах бөгөөд Засгийн газар үүргийнхээ дагуу мэдээллээр хангах, Парламентын хороод тулгамдсан асуудлыг хэлэлцэх үүрэгтэй. Батлан хамгаалах, аюулгүй байдал, бизнесийн нууц болон хувь хүний нэр төртэй холбоотой асуудлыг тусгайлсан журмаар хэлэлцэх ба хорооны гишүүд асуудлыг улс төржүүлэхгүй, баримт нотолгоонд тулгуурлан хэлэлцэх ёстой. Шаардлагатай гэж үзвэл, хорооны гишүүд цөөн хүнийг томилон хяналт шалгалт хийж болох бөгөөд өргөн хүрээтэй ярвигтай асуудлуудыг олон нийт, мэргэжлийн шинжээчид, судлаачид, ТББ-уудыг оролцуулан судлан дүгнэх, тэдний санал бодлыг сонсож хэлэлцэх боломжтой.</p> <p>Гишүүд Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг нарийвчлан хянах, асуудалд дүн шинжилгээ анализ хийх, цаашид нэгдсэн хуралдаанд асуудлыг танилцуулах, хэлэлцүүлэг хийх шаардлагатай тулгардаг учраас хяналтын хороодын гишүүд тохирсон ур чадвар, техникийг эзэмших шаардлагатай.</p> <p>Хяналт шалгалтын тайланг хороодын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын хуваарьт оруулж, хэлэлцэх тусгайлсан цаг гаргах шаардлагатай. Зарим улсад 2 долоо хоногт 1 удаа тогтоосон байдаг.</p> <p>Хяналтын байнгын хороо байгуулах замаар зарим улсад парламентын хяналтыг системтэй, тогтмол хэрэгжүүлж байна. Судалгаанд хамрагдсан орнуудын 80% нь Хяналтын байнгын хороотой байх бөгөөд үүний давуу тал нь хороодын гишүүд парламентын бүрэн эрхийн хугацаанд тогтвортой ажиллах, төлөвлөлт, зохион байгуулалт сайн, мэргэшсэн ажилтнуудтай учраас хяналтын ажлыг илүү гүнзгий, судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан явуулах, үндэслэл бүхий шийдвэр гаргах нөөц боломжтой байдаг. Үндэсний аудитын газар Засгийн газрын төсвийн зарлага, үр дүнг хянахад чухал үүрэгтэй оролцоно.</p>
	<p>Нээлттэй сонголт зохион байгуулах (Committee hearings in public)</p>	<p>Парламентаас хяналт шалгалт явуулж байгаа тодорхой асуудлыг Засгийн газрын төлөөлөл, олон нийт, экспертүүдийг оролцуулан хэлэлцэх нь баримт нотолгоо цуглуулах, мөрдөн шалгах чухал арга хэлбэр бөгөөд Хороодын санаачилгаар зохион байгуулна.</p>
	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх (Monitoring the implementation of legislation)</p>	<p>Хороод нь хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үүрэгтэй болж эхэлсэн зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх буюу ямар үр дүнд хүрэв, цаашид ямар арга хэмжээ авах вэ, хэдий хэмжээний нэмэлт эх үүсвэр шаардагдах вэ гэх мэт асуудлуудыг шийдэхэд чиглэгдэнэ. Судалгаанаас үзэхэд, хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх үйл ажиллагаа сүүлийн үед парламентын хяналтын чухал арга хэлбэр болсон бөгөөд</p>

		<p>судалгаанд хамруулсан орнуудын 54% нь ямар нэг байдлаар мониторинг хийдэг гэсэн байна.</p> <p>Жишээ нь, Их Британи 2010 оноос эхлэн хууль батлагдсанаас хойш 3-5 жилийн дараагаар холбогдох байнгын хороо нь хэрэгжилтийг хянан хэлэлцдэг, Италид Парламентын хяналтын газар хариуцан Засгийн газар болон холбогдох бусад институт, эх үүсвэрүүдээс цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн хяналт шинжилгээ хийдэг байна. Испанид, жендэрийн тэгш байдлыг хариуцсан дэд хороо жендэрийн хүчирхийллийн асуудлаарх хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг.</p>
	Тайлан, зөвлөмж гаргах (Reports and recommendations)	Хороод нэгдсэн хуралдаанд амаар болон бичгээр тайлан тавих ба судлан шалгах явцад олж илрүүлсэн зөрчил, түүнийг арилгах талаарх дүгнэлт зөвлөмж, шийдвэрийн төсөл хэлэлцүүлнэ.
	Хянан шалгах тусгай хороо байгуулах (Special committee of inquiry)	Парламентын байнгын хороодын зэрэгцээ тухайн Парламентын бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулах хянан шалгах тусгай хороог байгуулж, зарим асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно. Ийм хороод нь хянан шалгаж буй асуудалтай холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй байдгаараа онцлогтой. Тухайн асуудлыг шалгаж дуусаад тайланг Парламентад хүргүүлснээс хойш уг хороог татан буулгана. Судалгаанд авагдсан Парламентуудын 90% гаруй нь ийм төрлийн тусгай хянан шалгах хороог байгуулж болох юм гэж хариулсан. Уг хороог үндэсний хэмжээний ноцтой асуудлаар байгуулах ба 2013 онд 81, 2014 онд 84, 2015 онд 101 Хянан шалгах тусгай хороо байгуулагдаж байсан. Уг хороог Парламентын олонхын саналаар байгуулах ба хэнийг хороонд дуудаж яриулах, хэнээс мэдээлэл авах зэрэг асуудлуудад цөөнх түлхүү оролцдог туршлага Австрид байна.
	Засгийн газарт өгсөн үүргийн биелэлтэд мониторинг хийх (Monitoring government commitments)	Парламентад Засгийн газрын сайд нар үүргийн биелэлтээ тайлагнах ёстой. Уганда, Гана, Замби, Энэтхэг, Мьянмар зэрэг орнууд Засгийн газрын үүрэг даалгаврын биелэлтийг хянан Парламентын хороотой.
1.3.3	Нэгдсэн хуралдаан дахь хяналт (Oversight in the plenary)	Нэгдсэн хуралдаан бол улс төрийн хэлэлцүүлэг өрнөдөг том талбар. Парламентын гишүүд нэгдсэн хуралдаан дээр Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн талаар нээлттэй хэлэлцэж, санал шүүмж, асуулт хариулт, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар асуудлыг олон нийтийн анхаарлын төвд аваачих боломжтой байх ёстой. Чуулганы хэлэлцүүлгийн үед асуудлыг нэг бүрчлэн ярихгүй ч гэсэн хэвлэл мэдээллийг оролцуулан асуудлыг авч хэлэлцсэнээр олон нийтэд нээлттэйгээр асуудлыг том зургаар нь хэлэлцэх, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, нээлттэй байдлаа хангахад чухал ач холбогдолтой.
	Асуулга тавих, хэлэлцэх (Motions and debates)	Парламентын гишүүд Засгийн газрын сайд нарт тавьсан асуулгын хариуг сонсох, нээлттэйгээр хэлэлцэх нь тодорхой асуудлыг нарийвчлан шалгах, олон нийтэд нээлттэй ойлголт өгөх боломж юм. Энэ хэлбэр нь Засгийн газрын сайд нарт шахалт үзүүлж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах,

		Засгийн газар болон сайд нарт итгэл үзүүлэх эсэх болон бусад хариуцлагын асуудлыг ярих боломж олгоно.
	Асуулт тавих, хэлэлцэх (Questions: oral, written)	Энэ бол парламентын хяналтын үндсэн хэлбэрүүдийн нэг. Асуултыг Засгийн газрын гишүүдэд бичгээр болон амаар тавина. Бичгээр тавьж байгаа үед гишүүд холбогдох сайд нараас илүү тодорхой мэдээлэл авах боломжтой бол амаар асуух үед илүү шуурхай хариулт авах, өөрийн улс төрийн байр сууриа илэрхийлэх боломжтой. Мөн Парламентын нэгдсэн хуралдаанд “Засгийн газрын цаг” гаргаж Засгийн газар, холбогдох яамдын сайд нараас асуулт асууж, хариулт авах боломжтой байх шаардлагатай. Ялангуяа сөрөг хүчний хувьд нэгдсэн хуралдааны үйл ажиллагааг мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаа үед илүү их асуулт асууж Засгийн газрын гишүүдэд шахалт үзүүлэх сонирхолтой. Бичгээр асуулт асуусан тохиолдолд илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч тухайн сэдвийн хүрээндээ гишүүн хэд хэдэн асуулт асуух, ирүүлсэн мэдээллийг дараа дараагийн судалгаа, дүн шинжилгээнд ашиглах, бүрэн мэдээлэлтэй болох боломж бүрддэг гэж судалгаанд авагдсан орнуудын Парламентын гишүүд хариулсан.
1.3.4	Төсвийн хяналт (Oversight of the budget)	<p>Парламент нь төсвийн орлого бүрдүүлэлтээс гадна төрийн санхүү, төсвийн зарцуулалтыг хянах эрхтэй. Засгийн газраас парламентад төсвийн зарцуулалтын саналаа ирүүлэх ба Парламентаас Засгийн газар төсвийн орлогоо хэрхэн бүрдүүлж, хэрхэн зарцуулах гэж байгаа, төсөв зарцуулах тэргүүлэх салбар буюу бодлого нь юу байх, олон нийтийн эрэлт хэрэгцээнд энэ хуваарилалт нийцэж байгаа эсэхийг хянаж, төсвийг аль болох иж бүрэн, ил тод, үндэслэл тооцоотой байлгахыг хичээнэ.</p> <p>Парламентаас төсвийн хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Төсвийн шинжилгээ маш чухал. Энэхүү чадавхыг бүрдүүлснээр Парламентаас төсвийн хувилбаруудыг тооцоолох, Засгийн газраас хараат бусаар төсөв хэлэлцэх чадавх бүрддэг гэж үзэж байна. Парламентын хувьд төрийн санхүүгийн менежмент, төсвийн циклийг хянах асуудал нь мөрдөн шалгах, судалгаа дүн шинжилгээ хийх ур чадварыг шаардах тул улс орнуудын Парламент янз бүрийн түвшинд олон асуудлуудтай тулгарсаар байна.</p>
	Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх боломжууд	<p>Дэлхийн 100 Парламентын танхимууд төсвийн хяналтын дараах арга механизмуудыг ашиглаж байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• төсвийн төслийг боловсруулахаас өмнө Парламент дээр төсвийн тэргүүлэх чиглэл, бодлогын баримт бичгийг хэлэлцэж баталдаг - 40%;</li> <li>• төсвийн төслийг Парламентаар хэлэлцэн батлахаас дор хаяж 3 сарын өмнө хүлээж авдаг - 30%;</li> <li>• төсвийн төслийг 1 ба түүнээс олон хороогоор нягтлан шалгадаг - 80%;</li> <li>• төсвийн төсөлд жендэрийн нөлөөллийн анализ хийдэг - 20%;</li> <li>• Парламент өөрөө төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй - 40%;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• төсвийн жилийн туршид Парламентад төсвийн орлого, зарлагын талаарх мэдээллийг тодорхой хугацааны үечлэлээр тогтмол ирүүлдэг- 50%;</li> <li>• Үндэсний аудитын байгууллагаас Парламентад төсвийн талаарх тайлан ирүүлдэг - 90%;</li> <li>• уг тайланг Парламентаар нарийвчлан хэлэлцэх тодорхой журам тогтоодог - 60%;</li> <li>• төсвийн дүн шинжилгээ хийх чадавхтай дотоод бүтцийн нэгжтэй байх - 60%.</li> </ul>
Төсвийн дүн шинжилгээ хийх чадавх бүрдүүлэх	Төсвийн дүн шинжилгээ хийх нь мэргэшсэн ур чадвартай экспертийн ажил. Гишүүдийн хувьд төсвийн концепц болон арга зүйг ерөнхийд нь мэдэх шаардлагатай бол Парламентын ажлын албаны мэргэшсэн шинжээчид нарийвчилсан анализ хийх чадвартай байх. Бусад орнуудын туршлагаас үзвэл энэ чиглэлээр гишүүд болон ажилтнууд тусгайлсан сургалтууд авч байна.
Мэдээлэл цуглуулах, дата сан бүрдүүлэх	Төсвийн хяналт шинжилгээ хийхэд дата сан бүрдүүлэх нь асуудал чухал. Парламентаас ТХЗ-2030 зорилтуудыг хангах, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх хүрээнд ҮСХ-той хамтран ажиллаж ямар мэдээллийг, ямар аргачлалаар, ямар эх үүсвэрээс, хэрхэн бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх.
Парламентын Төсвийн шинжилгээний алба	<p>2008 оны дэлхийн хямралаас хойш ихэнх Парламентууд дүн шинжилгээний чадавхаа бэхжүүлэхэд анхаарч Төсвийн шинжилгээний алба (ТША)-ыг дотоод бүтцэдээ байгуулж эхэлсэн, хөндлөнгийн ТША-ны үйлчилгээг ч авч эхэлсэн. ТША нь олон улсын болон үндэсний зохицуулалтад нийцүүлэн төсөвт мониторинг, дүн шинжилгээ хийх, төсвийн техникийн нарийн мэдээллүүдийг хялбаршуулан танилцуулах зэрэг үүрэг хүлээнэ. Италийн туршлагаас үзэхэд, ТША нь макро-эдийн засгийн бодлого, төсвийн төсөөлөлд анализ хийх, төсвийн хэрэгжилтийг ЕХ болон үндэсний хууль тогтоомжуудад нийцүүлэн мониторинг хийх, Хороодын захиалгын дагуу төсөвтэй холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийх үүрэгтэй.</p> <p>Бусад орнуудын туршлагаас үзэхэд, хүчин чадал сайтай Парламентуудын ТША илүү мэргэшсэн, иж бүрэн төсвийн анализ хийх чадавхтай байгаа бол жижиг орнуудын хувьд санхүү, хүний нөөц хомс байх тул Үндэсний аудитын газрыг төсвийн шинжилгээний чиглэлээр Парламентад зөвлөх, хараат бус дүн шинжилгээ гаргаж өгөх хөндлөнгийн мэргэшсэн байгууллага гэж үздэг.</p>
Жендэрийн мэдрэмжтэй төсөв батлах	Ихэнх орнууд төсвийн төсөлд жендэрийн мэдрэмжийн анализ хийдэг.

#### 1.4. Парламентын хяналтын тусгайлсан салбарууд

**Судалгааны дүгнэлт:** Хяналтын зорилго, механизм нь нийтлэг байдаг боловч тодорхой сэдэвчилсэн чиглэлүүд нь ерөнхий зарчмуудыг тодорхой тайлбарлаж ашиглахыг шаарддаг. Парламент бэрхшээлээ шийдвэрлэхийн тулд хяналтын хэрэгслүүдээ хэрхэн нийцүүлэн хөгжүүлэх нь тухайн парламентаас хамаарна.

1.4.1	Аюулгүй байдлын салбарын хяналт	Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал талаас парламентын хяналтыг явуулахад тодорхой хориг саад, бэрхшээл гардаг тул аюулгүй байдлын хяналтыг тусгайлсан журмаар явуулна. Энэ хяналтыг явуулахын тулд Парламентаас аюулгүй байдлын салбарт хяналт явуулах эрх бий юу, хэрэв тийм бол аюулгүй байдлаар мэргэшсэн ажилтан, шинжээчид болон салбарын мэдээллийг авах эрх, холбогдох байгууллагаас шаардагдах мэдээлэл гаргаж өгөх боломж бий юу, энэ төрлийн хяналтыг хэрэгжүүлэхийг Парламентын гишүүд хүсч байгаа юу гэх зэрэг асуудлуудыг тодруулан судлах шаардлагатай.
1.4.2	Олон улсын хүний эрхийн хэрэгжилтийг хянах	<p>Парламент бүхэн хяналтын бүрэн эрхийнхээ хүрээнд хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Бусад орнуудын жишгээс үзэхэд, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхийн тулд Парламентууд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын хүний эрхийн зарчмуудад нийцүүлэн хүний эрхийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудаар баталгаажуулсан байх;</li> <li>• Засгийн газарт хүний эрхийг хамгаалах хангалттай төсөв, институциональ бүтэц, дүрэм журам болон техникийн хүчин чадалтай байгаа эсэхийг хянах;</li> <li>• Хүний эрхийн механизм, дүгнэлт, зөвлөмжүүдийн Засгийн газрын хэрэгжилтэд хяналт тавих;</li> <li>• НҮБ-ын Хүний эрхийн мониторингийн механизмын дагуу Засгийн газраас шаардлагатай мэдээллийг гарган өгч хамтран ажиллаж байгаа эсэхийг хянах;</li> <li>• Дээрх механизм болон холбогдох мэдээллийн өөрчлөлтийг Парламентад шинэчлэн хүргүүлдэг байх.</li> </ul>
1.4.3	Тогтвортой хөгжлийн зорилтууд-2030 ба хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих	<p><b>2015 онд батлагдсан Тогтвортой хөгжлийн зорилт-2030</b>-ийг дэлхийн бүх орнуудын Засгийн газрууд хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Парламент хүлээсэн. Иймд уг хөтөлбөрийн агуулгад нийцүүлэн үндэсний зорилтуудаа тодорхойлох, хэрэгжилтийг хянах механизмыг парламентын хяналтын бүрэн эрхэд хамааруулан зохицуулахыг ОУПХ, НҮБХХ-ээс зөвлөсөн байна. Парламентын хяналтыг хэрэгжүүлж буй бусад орнуудын туршлагаадаас үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ТХЗ-ууд, шалгуур үзүүлэлттэй уялдуулан үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөр батлах;</li> <li>• Парламентаас баталсан хууль тогтоомж, төсвийн зарцуулалт, төлөөллийн болон хяналтын эрх мэдлийг уг зорилтын хэрэгжилтийг хангахад чиглүүлэх системийг бий болгож тасралтгүй ажиллуулах.</li> </ul> <p>Тухайлбал, ҮСХ-ноос холбогдох дата мэдээллийг гаргуулах, хууль тогтоомж батлах, өөрчлөлт оруулахдаа энэ чиглэлээр өөрчлөлт оруулах иргэний нийгэмтэй зөвлөлдөх, шаардлагатай санхүүжилтийг гаргах, Парламентын хэлэлцүүлэг, асуулга, асуулт, хороодын хяналт шалгалт, хэлэлцүүлгийн явцад энэ асуудлыг хянах, тулгамдсан асуудлуудыг илрүүлж, цаашид хэрэгжилтийг идэвхжүүлэх гэх мэт.</p>
<b>1.5. Парламентын хяналтын харилцааны сүлжээ</b>		

<p><b>Судалгааны дүгнэлт:</b> Ардчилсан нийгмийн бүх гишүүд төрийн удирдлагын чанарыг сайжруулах сонирхолтой байдаг. Улс төрийн чухал үүрэг бол Парламент ба нийгэм, тэр дундаа иргэний нийгэм, олон нийт, түүнчлэн хяналт, хяналтын чиг үүрэг бүхий олон оролцогчдын хоорондын харилцан үйлчлэлийг нэмэгдүүлэх явдал юм. Ийм өргөн хүрээг хамарсан хяналтын түншүүдтэй харьцахад албан болон албан бус хандлага адил өргөн хүрээг хамардаг. Хяналтын талаарх албан бус хандлага нь албан ёсны үйл явцыг хэрхэн ашиглаж байгаагаас нь хамааран тойрч гарч, доройтуулж болзошгүй зүйлсийг нөхөж байгаа юм. Албан бус хэрэгслийг ашиглах улс төрийн сэдлийг ойлгох нь тэдгээрийг хэрхэн, яагаад ашиглаж байгааг шинжлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.</p>		
1.5.1	<p>Парламентын хяналтын албан ба албан бус аргууд</p>	<p>Парламентын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд зөвхөн Засгийн газраас албан ёсоор мэдээлэл авах нь хангалтгүй байдаг. Иймд олон улсын практикт албан бус шугамаар хөндлөнгийн мэдээлэл олж авах, тухайлбал, хөндлөнгийн хяналтын байгууллагууд, Засгийн газар, хэвлэл мэдээлэл, ТББ-ууд, мэргэжлийн бүлгүүд, нийгмийн сүлжээ эх сурвалжуудыг ашиглах зэргээр харилцаа үүсгэдэг байна. Эдгээр эх сурвалжуудаас авах мэдээлэл нь тайлан, зөвлөмж, нотлох баримт, санал шүүмж хэлбэртэй байх ба үр дүнд нь Парламентын гишүүд асуудлын талаар илүү бодитой албан болон албан бус мэдээлэлтэй болох, үзэл бодлоо хуваалцах, олон нийтийн хяналтыг бий болгох ач холбогдолтой.</p>
1.5.2	<p>Хөндлөнгийн хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<p>Ихэнх орны Парламентууд өөрийн хяналтын бүрэн эрхийн хүрээнд тодорхой салбар хариуцсан байгууллагуудтай хяналтын чиг үүргээ хуваалцана. Тухайлбал, Үндэсний аудитын байгууллага, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, төсвийн дансыг хараат бусаар хянах, Хүний эрхийн үндэсний хороо, Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон мандатын эрхийн хүрээнд хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх, Омбудсмэн- төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа, зөрчлийг хянаж нотлох баримт цуглуулах Үндсэн хуулиар эрх олгогдсон төрийн институт бөгөөд хариуцсан чиглэлийн хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцдог практик байна.</p>
1.5.3	<p>Бусад оролцогчидтой хамтран ажиллах:</p> <p>а) Засгийн газартай харилцах</p>	<p>Засгийн газрын газар, хэлтсүүдээс ирүүлж байгаа мэдээлэл, дүн шинжилгээ бол Парламентын хяналтын нэг чухал эх сурвалж мөн. Гэвч Парламент болон Засгийн газрын албан хаагчдын хооронд зарчмын хувьд ялгаа бий. Засгийн газрын зүгээс аль болохоор ажлаа сайн дүгнүүлэх, хуулийн хэрэгжилт хэвийн яваа мэтээр тайлагнах эрмэлзэлтэй байдаг бол парламентын зүгээс Засгийн газрын үүсгэж байгаа шат дамжлага, хүнд суртлыг илрүүлэн гаргах зорилготой. Ийм учраас Парламент тусгайлсан мэдлэг, дүн шинжилгээ хийх чадавхтай байхын зэрэгцээ Засгийн газартай хэл амаа ололцож, аль болохоор бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэх чиглэлд хамтран ажиллах шаардлагатай.</p>
	<p>б) Сайд нартай харилцах</p>	<p>Засгийн газрын сайд нартай “хэл амаа ололцох”. Судалгаанд хамруулсан орнуудын Парламентын гишүүдийн хариултаас үзэхэд, сайд нартай тусгайлсан асуудлаар ярилцлага өрнүүлэх явцад тодорхой мэдээлэл авч, бодлогын асуудалд нөлөөлөх боломжтой байдаг гэсэн байна. Иймээс парламентын гишүүд сайд нарт хандаж мэдээллийг шууд гаргуулан авах, шууд асуулт тавьж хариулт авах боломжтой байх нь зүйтэй гэж үзсэн. Гишүүдийн мэдээлэл авах эрхийн хувьд хэд хэдэн сөрөг зүйл ажиглагддаг:</p>

	<p>1/ <i>Мэдээлэл авах эрхийн ялгаатай байдал</i>: Парламентын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүн, сайдын хувьд бусад гишүүд болон сөрөг хүчний гишүүдээс илүү мэдээллийн давуу эрхтэй байдаг.</p> <p>2/ Парламентын гишүүн хяналтын үүргээ биелүүлэхдээ сайд нартай албан бусаар харьцаж мэдээлэл авч байгаа тохиолдолд гишүүн-сайдын хувьд парламентын хяналтын албан ёсны процедурыг үл ойшоох хандлагатай байдаг.</p> <p>3/ Хяналтын процесс ил тод биш байх нь авилгын эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг.</p>
в) Иргэний нийгэмтэй харилцах	Парламентын гишүүд иргэний нийгэмд хандан Парламентын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөхөөс гадна хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгарч байгаа асуудлаар талаар иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, үзэл бодлыг сонсох шаардлагатай. Ялангуяа Парламентын нээлттэй сонголд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн санал, байр суурийг нь сонсдог байх шаардлагатай гэж үздэг.
г) Хувийн сектортой харилцах	Хувийн секторын зүгээс эдийн засаг, мэргэжлийн ашиг сонирхол болон хөгжлийн идеологи талаасаа ЗГ-ыг дэмжиж байдаг бол төрөөс татвар, шударга өрсөлдөөн, бизнесийн эрх, эрх чөлөөг хангаж хувийн секторт дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Ихэнх орнуудын туршлагаас үзэхэд, хувийн секторынхан эдийн засгийн лобби бүлэг үүсгэн тухайлсан салбар, эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд ямар асуудал байна, яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр нөлөөлөх оролдлого хийж байдаг бол хууль тогтоогчдын хувьд энэ талаар мэдээлэлтэй байж, талуудын ялгаатай эрх ашиг, зорилгыг ойлгож, мэргэшсэн ажилтнуудынхаа дэмжлэгтэйгээр сайн, муу мэдээллийг ялгаж салган хууль тогтоох үйл ажиллагаандаа ашиглаж байдаг.
д) Хэвлэл мэдээлэлтэй харилцах	Олон нийт Засгийн газрын үйл ажиллагаа төдийгүй, Парламентаас Засгийн газарт хэрхэн хяналт тавьж байгаа талаар мэдээлэл авч байх ёстой. Иймд хэвлэл мэдээллийн байгууллагууд парламентын хяналтын талаарх мэдээллийн контент бэлтгэх чадвартай мэдлэгтэй, мэргэшсэн сэтгүүлчдийг ажиллуулах нь зүйтэй. Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүлчдийн мэдээлэл нь парламентын хяналтын нэгэн чухал эх үүсвэр болдог учраас хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Парламентын гишүүд аль аль нь олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээлэл цуглуулах, олон нийтийн санаа бодлыг тандан судлах, хамтран ажиллах нь түгээмэл байдаг.
е) Нийгмийн сүлжээг ашиглах	Парламентын хяналтыг үр нөлөөтэй болгох чухал нөхцөл бол олон нийтийн оролцоог хангах. Техник технологи өндөр хөгжсөн өнөө үед нийгмийн идэвхтэй хэсэг, тэр дундаа залуучууд нийгмийн сүлжээг өргөнөөр ашиглаж байгаа тул Парламентын зүгээс онлайн харилцааг чухалчлан үзэх нь зүйтэй хэмээн судалгаанд авагдсан орнуудын Парламентын гишүүд үзсэн байна. Нийгмийн сүлжээгээр дамжуулж Парламент үйл ажиллагаагаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхээс гадна олон нийт хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ямар санаа бодолтой байгаа, юуг яаж өөрчлөхийг хүсэж байгаа зэргийг тандан судалж гишүүдийн зүгээс input буюу хяналт шалгалтын санаа олж авдаг гэж судалгаанд оролцогсод хариулсан байна.

1.5.4	Парламент дахь намын бүлгүүд ба бусад албан бус хяналт	Парламентын гишүүд хууль ёсны хяналтын хэлбэрүүдийг ашиглахаас гадна намын бүлгүүд дангаараа, эсхүл Парламентад суудалтай намын бүлгийн гишүүд хамтрах буюу сонирхлын бүлгээрээ нэгдэж хяналтын үйл ажиллагаа явуулдаг практик байна. Тухайлбал, парламент дахь эмэгтэйчүүдийн бүлэг.
<p><b>1.6.Парламентын хяналт ба парламентын гишүүдийн оролцоо</b></p> <p><b>Судалгааны дүгнэлт:</b> Парламентад хяналтын олон арга хэрэгслийг ашиглах боломжтой. Эдгээр арга хэрэгслийг Парламентын гишүүд шаргуу ажил хэрэг болгохгүй бол үнэ цэнэгүй болно. Хяналтыг байнга, цуцалтгүй явуулж буй гишүүдэд албан тушаалаа алдах хүртэл эрсдэл тулгарч болзошгүй ч энэхүү ажилд өөрийгөө бүрэн зориулж, хичээнгүйлэн ажиллаж буй парламентын гишүүний нэр хүнд олон нийтийн дунд өсөх магадлал өндөр байдаг. Эерэг боломжууд нь мэргэжлийн хөгжил, өндөр нэр хүндийг олж авах, Засгийн газрын болон хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад шууд хувь нэмэр оруулах явдал юм.</p>		
1.6.1	Парламентын гишүүдийг хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулах хөшүүрэг	Парламентын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр нөлөөг үнэлэх хүсэл эрмэлзэл, сонирхолтой байдаг. Тухайлбал, авилгыг бууруулах, бодлогын зорилго зорилтуудыг төгөлдөржүүлэх, улс төрчийн хувьд туршлага хуримтлуулах, хууль хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах, гэх мэт Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээг дараах 5 төлөвийг хэрхэн хангаж байгаагаар үнэлдэг. Үүнд: шударга байдал, найдвартай байдал, эрх тэгш байдал, үр ашигтай байдал, үр нөлөөтэй байдал ( <i>probity, fidelity, equity, efficiency, effectiveness</i> ).
1.6.2	Хяналтыг үр ашигтай явуулах нөхцөл	<p>Парламентад хуулиар олон төрлийн хяналтын бүрэн эрхийг олгодог ч Засгийн газрын үйл ажиллагаанд үнэхээр бодитой, үр нөлөөтэй хяналт тавья гэвэл зайлшгүй шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Практикт улс төрийн нөлөө болон чадавх дутагдсанаас үүдэн хяналтын үр нөлөө төдийлөн сайнгүй байдаг нь нууц биш. Зөвхөн тайлан, зөвлөмж бичих бол хяналт биш юм. Иймд дараах нөхцөлүүдийг бүрдүүлэхээс гадна хэвлэл мэдээлэл, олон нийтийн дэмжлэгийг авч байж л парламентын хяналтын үр нөлөө дээшилнэ гэж судалгаанд оролцогчид үзсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Шүүмжлэлт мэдээллийн суваг бий болгох:</b> Нэг талаас Засгийн газар нь мэдээллийн томоохон сантай, мэдээж гишүүд яам, газруудаас мэдээлэл авах давуу эрхтэй ч энэ нь өрөөсгөл. Иймд Парламент өөрийн харьяа байгууллага, хамтрагч хөндлөнгийн субъектүүдээс мэдээллийн эх үүсвэртэй байх хэрэгтэй. Парламентын мэдээллийн эх үүсвэр бие даасан байх тусам хяналтын чадавх сайн байна.</li> <li>• <b>Санхүүгийн хангалттай нөөцтэй байх:</b> Мэдээжийн хэрэг Парламент санхүүгийн хангалттай нөөцтэй байж хяналтын үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулна. Мэргэшсэн экспертийн туслалцаа авах, ажилтнуудад зохистой цалин хөлс олгох, баталгаатай мэдээллийн эх үүсвэрийг ашиглах гэх мэт. Хяналтын үйл ажиллагаанд зарцуулах төсөв хөрөнгөнөөс хамааран улс орнуудын парламентын хяналтын чадавх янз бүр байна.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"><li>• <b>Мэдээллийн хангамж сайн байх:</b> Сайн хяналтын үндэс нь сайн мэдээлэл юм. Гэвч Парламент-Засгийн газрын мэдээллийн тэнцвэртэй байдал төдийлөн сайн биш, Парламентын цөөнх зарим тохиолдолд шаардлагатай мэдээллийг авч чаддаггүй гэх мэт асуудлууд практикт гардаг. Түүнчлэн Парламент мэдээллийн вакуум орчинд ажиллаж болохгүй, иймд хөндлөнгийн мэдээллийн эх сурвалжуудыг авах хэрэгтэй. Парламент Засгийн газраас мэдээлэл гаргуулан авах бүрэн боломжтой, давуу талтай боловч хамгийн гол нь мэдээллийг үнэлэх, шүүмжлэлт өнцгөөс мэргэшсэн дүгнэлт хийх чадавх сул байх нь хяналтын үр нөлөөг бууруулдаг. Иймд Парламентын зүгээс аль болохоор мэдээлэл сайтай, мэргэшсэн субъектүүдийн сонирхлыг татах, нээлттэй хамтран ажиллах шаардлагатай болдог.</li></ul>
--	--	---



## 2.2.Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл, зохион байгуулалт

### 2.2.1.Хяналт шалгалтын арга хэрэгсэл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
<b>6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл</b>	<b>6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл</b>
6.1.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ: 6.1.1.асуулт тавих; 6.1.2.асуулга тавих; 6.1.3.хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх; 6.1.4.мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх; 6.1.5.төсвийн хяналт; 6.1.6.хяналтын сонсгол хийх; 6.1.7.хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.	6.1.Улсын Их Хурал хяналт шалгалтын бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ: 6.1.1.асуулт; 6.1.2.асуулга; 6.1.3.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ; 6.1.4.мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх; 6.1.5.төсвийн хяналт; 6.1.6.хяналтын сонсгол; 6.1.7.хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.
	6.2.“Улсын Их Хурлын хяналт” гэж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын болон Улсын Их Хурлаас удирдлага нь сонгож, томилогддог байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд энэ хуулийн 6.1.1-6.1.6-д заасан хяналтын арга хэрэгсэлд заасны дагуу шинжлэх, дүгнэх, хянах байнгын шинжтэй үйл ажиллагааг ойлгоно.
	6.3.“Улсын Их Хурлын шалгалт” гэж хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 34.1.1-д заасан аргаар нотлох баримт цуглуулах парламентын тусгай шалгалтыг ойлгоно.
	6.4.Энэ хуулийн 6.1.1-6.1.6-д заасан Улсын Их Хурлын хяналтын дүн энэ хуулийн 6.1.7-д заасан Улсын Их Хурлын шалгалтыг тухайн асуудлаар явуулах үндэслэл байж болно.

**ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:** Олон улсад парламентын хяналтын арга хэрэгслийг зорилго, хэрэгжүүлэх хэлбэрийн онцлогоор нь ялгамжтай зохицуулдаг. Парламентын “хяналт” /oversight/ нь гүйцэтгэх эрх мэдэл, төрийн байгууллагын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт, төсөв зэрэгт байнгын шинжтэй хяналт тавих үйл ажиллагаа бол, “шалгалт/мөрдөн шалгах” /investigation/ нь тодорхой зөрчил, нийтийн ач холбогдолтой асуудал, эсхүл бодит нөхцөл байдлыг тогтоох зорилготой, ихэвчлэн нэг удаагийн, баримт нотолгоонд тулгуурласан тусгай ажиллагаа байна. Харин “үнэлгээ” /evaluation/ нь баталсан хууль тогтоомж практикт хэрхэн хэрэгжиж, зорилго, үр нөлөөгөө хангасан эсэхийг эргэн шинжлэх парламентын хяналтын тусгай хэлбэр юм.

Тухайлбал, Солонгост төрийн хяналтыг холбогдох байнгын хороо жил бүр явуулдаг бол төрийн тодорхой асуудлаарх шалгалтыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь хүсэлт гаргасан тохиолдолд тусгай хороо, эсхүл байнгын хороо явуулж, шалгалтын хүрээнд баримт бичиг цуглуулах, гэрч дуудах,

мэдүүлэг авах, шинжээчийн дүгнэлт гаргуулах, сонсгол зохион байгуулахаар зохицуулсан байна.

Олон улсын парламентуудад асуулт, асуулга тавих, сонсгол зохион байгуулах, тайлан, мэдээлэл хэлэлцэх, төсөвт хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, хянан шалгах буюу мөрдөн шалгах түр хороо байгуулах зэрэг хяналт, шалгалтын арга хэрэгслийг хууль тогтоомж, парламентын дэг болон тусгайлсан зохицуулалтын дагуу хэрэгжүүлдэг.

Эдгээр арга хэрэгсэл нь байнгын хяналт, тодорхой асуудлаарх шалгалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ гэсэн ялгаатай зорилго, ажиллагааны хэлбэртэй байна.

## 2.2.2.Хяналт шалгалтын үйл ажиллагаа

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>7 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагаа</b>	<b>7 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаа</b>
7.1.Байнгын, дэд болон хянан шалгах түр хороо, Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	7.1.Байнгын, дэд хороо, Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлж, хянан шалгах түр хороо Улсын Их Хурлын шалгалт явуулна.
7.2.Төрийн аудитын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл болон төрийн бусад байгууллага холбогдох Байнгын хорооны даалгаснаар хяналт шалгалт явуулж болно. Холбогдох Байнгын хороо эдгээр байгууллагыг хууль тогтоомжид заасан чиг үүргийнх нь хүрээнд Улсын Их Хурлын хяналт шалгалтад оролцуулахдаа тухайн байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлж үл болно.	7.2.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл Төрийн аудитын байгууллага, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад хараат бус хянан шалгах чиг үүрэгтэй байгууллагад түшиглэн явуулна. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс нөлөөлж үл болно.
7.3.Улсын Их Хурлаас хийх хяналт шалгалтыг Улсын Их Хурлын нэгдсэн удирдамжийн дагуу хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хяналт шалгалттай давхцуулахгүйгээр хэрэгжүүлнэ.	7.3.Улсын Их Хурлаас хийх хяналт шалгалтыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хяналт шалгалттай давхцуулахгүйгээр хэрэгжүүлнэ.
7.4.Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хяналт шалгалт явуулахдаа аливаа байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцохгүй.	7.4.Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хяналт шалгалт явуулахдаа аливаа байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцохгүй.
7.5.Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл, тооцоо судалгаа, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан нуун дарагдуулахыг хориглоно.	7.5.Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл, тооцоо судалгаа, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан нуун дарагдуулахыг хориглоно.
7.6.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай бол тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулж болох бөгөөд тэдгээрийн ажиллах журам, эрх, үүрэг, хариуцлагыг Тамгын газартай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.	7.6.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай бол тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулж болох бөгөөд тэдгээрийн ажиллах журам, эрх, үүрэг, хариуцлагыг Тамгын газартай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

7.7.Улсын Их Хурлын хяналт шалгалтад энэ хуулийн 7.6-д заасан этгээдийг оролцуулах бол энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөж, шаардлагатай зардлыг Улсын Их Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.	7.7.Улсын Их Хурлын хяналт шалгалтад энэ хуулийн 7.6-д заасан этгээдийг оролцуулах бол энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу төлөвлөж, шаардлагатай зардлыг Улсын Их Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.
	7.8.Хяналт шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн Улсын Их Хурлын үйл ажиллагаа, холбогдох шийдвэрийн биелэлтийг давтан хянаж болно.
	7.9.Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал хяналтын сонсгол, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлттэй холбогдуулан үр дүнгийн давтан хяналт хийнэ.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Хяналтын субъект ба шалгалтын тусгай бүтэц (§7.1).** Олон улсад парламентын байнгын хяналтыг түүний хороод, гишүүд хэрэгжүүлж, харин тодорхой асуудлаар баримт тогтоох, нотлох баримт цуглуулах шинжтэй шалгалтыг түр буюу тусгай хороо хэрэгжүүлэх нь түгээмэл байна. ХБНГУ-д Бундестаг нийт гишүүдийн 1/4-ийн саналаар мөрдөн шалгах хороо байгуулж, уг хороо нь баримт цуглуулах, гэрч байцаах зэрэг эрх хэрэгжүүлдэг. Солонгост төрийн захиргааны хяналтыг байнгын хороо жил бүр явуулдаг бол тодорхой асуудлаарх шалгалтыг нийт гишүүдийн 1/4-ээс доошгүй нь хүсэлт гаргаснаар түр хороо, эсхүл байнгын хороо тусгайлан явуулдаг. Их Британид хууль батлагдсаны дараах хяналтыг Нийтийн Танхимд байнгын хороо хэрэгжүүлдэг бол Лордын Танхимд тусгайлан байгуулагдсан түр хороо хэрэгжүүлж, тайлан гаргасны дараа татан буугддаг.

Эдгээр зохицуулалт нь парламентын байнгын хяналт болон тодорхой асуудлаарх тусгай шалгалтыг хэрэгжүүлэгч субъект, ажиллагааны шинжээр нь ялгаж буй хэлбэр юм.

**Хараат бус байгууллагад түшиглэсэн мэргэшсэн хяналтын хувьд (§7.2).** Парламент гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд дангаар дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал тул олон улсад аудит, төв банк, хүний эрхийн комисс, статистикийн байгууллага зэрэг мэргэшсэн, хараат бус байгууллагуудыг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ татан оролцуулдаг. Эдгээрээс аудитын байгууллага нь Их Британи, Шинэ Зеланд, Эстони зэрэг улсад парламентын өмнө шууд хариуцан тайлагнадаг бөгөөд түүний гаргасан дүгнэлт нь парламентын хороодын хяналт шалгалтын нэг үндэслэл болдог.

Парламентын хяналтад эдгээр байгууллагыг оролцуулах нь тухайн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг орлох бус, тэдний тайлан, мэдээлэл, дүгнэлтэд тулгуурлан хэрэгждэг байна. Энэ тохиолдолд тухайн байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх зарчим хадгалагдана.

### 2.2.3.Хяналт шалгалтын төлөвлөлт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>8 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөлт</b>	<b>8 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөлт</b>
8.1.Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй байна.	8.1.Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн хэлбэртэй байна.
8.2.Байнгын, дэд хорооноос хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг Улсын Их Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар /цаашид “цаглавар” гэх/-т тусган хэрэгжүүлнэ.	8.2.Байнгын хороод ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө дараагийн ээлжит чуулганы хугацаанд хийх хяналт шалгалтын цаглаварт тусгуулахаар хуралдаанаараа шийдвэрлэсэн саналаа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.
8.3.Байнгын, дэд хороо дараагийн ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгуулах саналаа ээлжит чуулган завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /цаашид “Төрийн байгуулалтын байнгын хороо” гэх/-нд хүргүүлнэ.	8.3.Байнгын хорооноос ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтыг энэ хуулийн 7.2-т заасан байгууллагын шалгалтын сэдвийг харгалзан, энэ хуулийн 8.2-т заасан саналыг үндэслэн боловсруулсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын цаглаварт тусган хэрэгжүүлнэ. Дэд хороо шаардлагатай гэж үзвэл цаглаварт тусгуулах саналаа холбогдох Байнгын хороонд уламжилна.
8.4.Нам, эвслийн бүлэг цаглаварт тусгуулах саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж болно.	8.4.Хяналт шалгалтын цаглаварт энэ хуулийн 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан хяналт, дараагийн ээлжит чуулганы хугацаанд үргэлжлэн ажиллах хянан шалгах түр хороо, Байнгын хорооноос байгуулах ажлын хэсэг, энэ хуулийн 13, 16 дугаар зүйлд заасан нэгдсэн дүн, тайлан, үнэлгээг тусгана.
8.5.Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 8.3, 8.4-т заасны дагуу саналаа ирүүлээгүй бол цаглаварт тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.	8.5.Байнгын хороо энэ хуулийн 8.3, 8.4-т заасны дагуу саналаа ирүүлээгүй бол хяналт шалгалтын цаглаварт тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.
8.6.Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврыг холбогдох шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж, шийдвэрлүүлнэ.	8.6.Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөгөөт цаглаврын төслийг холбогдох шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж, шийдвэрлүүлнэ.
8.7.Цаглаварт хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх,энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т зааснаас бусад тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, төсөв, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах болон хяналт шалгалтын бусад асуудлыг тусгана.	8.7.Хяналт шалгалтын цаглаварт тайлан, илтгэл, мэдээллийг тусгахдаа энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т зааснаас бусад тайлан, илтгэл, мэдээллийг тусгана.
8.8.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах тохиолдолд явуулна:	8.8.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах тохиолдолд явуулна:
8.8.1.энэ хуулийн 8.7-д заасан цаглаварт тусгагдаагүй асуудлаар хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах тухай гишүүний саналыг энэ хуулийн 9.2-т заасны дагуу Байнгын хороо хэлэлцэж, дэмжсэн;	8.8.1.энэ хуулийн 8.4-т заасан цаглаварт тусгагдаагүй асуудлаар хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах тухай гишүүний саналыг энэ хуулийн 9.2-т заасны дагуу Байнгын хороо хэлэлцэж, дэмжсэн;
8.8.2.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.4.2-т заасан хяналт шалгалт явуулах саналыг Байнгын хороо хэлэлцэж дэмжсэн.	8.8.2.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.5.2, 39.5.3-т заасан хяналт шалгалт явуулах саналыг Байнгын хороо хэлэлцэж дэмжсэн.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Хяналт шалгалтын цаглавар ба төлөвлөгөөт хяналт (§8.1-8.7).** Парламентын хяналтыг тасралтгүй, системтэй явуулах зорилгоор олон улсад хяналтын ажлыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр зохицуулдаг.

Төлөвлөгөөт хяналт нь парламентын бүрэн эрхийн хугацаа, чуулганы мөчлөг, эсхүл жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан цаглаварын дагуу хэрэгждэг. ОХУ-ын Парламентын хяналтын тухай хуульд байнгын хяналтын арга хэмжээг Төрийн Дум дахь намын бүлэг, хороо, гишүүдийн бичгээр гаргасан саналыг үндэслэн танхимын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахаар зохицуулсан. Солонгост нам, эвслийн бүлэгтэй зөвлөлдөн баталдаг Үндэсний Ассамблейн жилийн төлөвлөгөөнд төрийн захиргааны хяналт шалгалтыг тусгадаг. Шинэ Зеландад төсвийн төсөл болон жилийн гүйцэтгэлийг хянан хэлэлцэхэд зориулсан “хяналтын долоо хоног” /scrutiny weeks/-ийг парламентын цаглаварт тусгайлан тусгадаг байна.

Эдгээр зохицуулалт нь парламентын хяналтын асуудлыг чуулганы хугацаа, хороодын санал, тайлан хэлэлцэх хугацаа, төсөв болон гүйцэтгэлийн хяналтын мөчлөгтэй уялдуулан цаглаварт тусгадаг нийтлэг хэлбэрийг харуулж байна.

**Төлөвлөгөөт бус хяналт, тусгай шалгалт (§8.8).** Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал үүссэн, эсхүл тусгайлан шалгах шаардлагатай нөхцөл байдал бий болсон тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт явуулах зохицуулалт олон улсын парламентын практикт байна. Ийм хяналт нь ердийн цаглаварт урьдчилан тусгагдаагүй асуудлаар гишүүдийн санаачилга, хорооны шийдвэр, эсхүл хуульд заасан тусгай үндэслэлээр хэрэгждэг. Тухайлбал, хуульд заасан тооны гишүүдийн санал, хүсэлтээр ХБНГУ-ын Бундестагт мөрдөн шалгах хороо, Солонгосын Үндэсний Ассамблейд төрийн тодорхой асуудлаар “төрийн шалгалт” /state investigation/ явуулах хороо тухайн тохиолдолд байгуулагддаг.

Энэ нь төлөвлөгөөт хяналтын цаглавраас гадуур тодорхой асуудлаар түр буюу тусгай шалгалт явуулах эрх зүйн үндэслэлийг тусад нь тогтоодог хэлбэр юм.

### 2.2.4. Байнгын, дэд хороодоос хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>9 дүгээр зүйл. Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих</b>	<b>9 дүгээр зүйл. Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт зохион байгуулах</b>
9.3. Байнгын хороо хяналт шалгалт явуулах саналыг хэлэлцэн шийдвэрлэхийн өмнө тухайн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтны тайлбар, мэдээллийг авч, харгалзан үзнэ.	9.1. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах, эсхүл хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг дангаар болон хамтран байгуулна.
9.2. Гишүүн энэ хуулийн 9.1-д заасны дагуу хяналт шалгалт явуулах саналыг өөрийн харьяалагдах Байнгын хороонд эрхлэх асуудлынх нь хүрээнд гаргаж болох бөгөөд уг саналыг Байнгын хороо хэлэлцэж дараах шийдвэрийг гаргана: 9.2.1. тухайн асуудлаар хяналт шалгалт хийж, дүнг танилцуулахыг эрх бүхий холбогдох байгууллагад даалгах;	9.2. Гишүүн энэ хуулийн 9.1-д заасны дагуу хяналт шалгалт явуулах саналыг өөрийн харьяалагдах Байнгын хороонд эрхлэх асуудлын хүрээнд гаргаж болох бөгөөд уг саналыг Байнгын хороо хэлэлцэж дараах шийдвэрийг гаргана: 9.2.1. тухайн асуудлаар хяналт шалгалт хийж, дүнг танилцуулахыг эрх бүхий холбогдох байгууллагад даалгах; 9.2.2. Байнгын хорооны хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах;

9.2.2.Байнгын хорооны хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулах; 9.2.3.тухайн асуудлаар хяналт шалгалт явуулах шаардлагагүй гэж үзэх.	9.2.3.тухайн асуудлаар хяналт шалгалт явуулах шаардлагагүй гэж үзэх.
9.3.Байнгын хороо хяналт шалгалт явуулах саналыг хэлэлцэн шийдвэрлэхийн өмнө тухайн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтны тайлбар, мэдээллийг авч, харгалзан үзнэ.	9.3.Байнгын, дэд хороо шаардлагатай гэж үзвэл ажлын хэсэг байгуулж болно. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл тусгай мэдлэг, мэргэшил шаардагдах асуудлаар туслалцаа үзүүлэх мэргэшсэн судлаач, мэргэжилтэн, мэргэжлийн холбооны төлөөллийг оролцуулсан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулж болно.
9.4.Байнгын хороо энэ хуулийн 9.1-д заасан ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг тогтоолоор батална.	9.4.Байнгын, дэд хороо ажлын хэсэг байгуулах тогтоолын хавсралтаар ажиллах удирдамж батлах бөгөөд ажлын хэсэг уг тогтоолд заасан хугацаанд санал, дүгнэлт гаргаж Байнгын, дэд хороонд танилцуулна. Байнгын, дэд хороонд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч танилцуулна.
9.5.Хяналт шалгалтын ажлын хэсэг уг тогтоолд заасан хугацаанд санал, дүгнэлт гаргаж, ажлын хэсгийн ахлагч Байнгын хороонд танилцуулна.	9.5.Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан асуудлаар санал, дүгнэлт, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох Байнгын, дэд хороонд танилцуулж болно.
9.6.Хяналт шалгалтын ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 9.5-д заасан санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулж, холбогдох Байнгын хороонд оруулж болно.	9.6.Дэд хороо энэ хуулийн 9.5-д заасан санал, дүгнэлт, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороонд, Байнгын хороо нэгдсэн хуралдаанд тус тус танилцуулж шийдвэрлүүлнэ.
9.7.Хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын болон энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан асуудлаар тогтоол гаргана.	9.7.Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын явц, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтаан хэлэлцэж, ажлын хэсгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл дуусгавар болгох шийдвэрийг гаргана.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Ажлын хэсэг, мэргэшсэн шинжээчийн оролцоо (§9.3).** Парламентын хороод тодорхой асуудлыг судлах, хяналтын материал бэлтгэх, мэргэжлийн дүгнэлт гаргуулах зорилгоор ажлын хэсэг, дэд ажлын хэсэг байгуулах, шинжээч татан оролцуулах зохицуулалт олон улсын парламентын практикт байдаг. Тухайлбал, ОХУ-ын Төрийн Думын Регламентын дагуу хороо, комисс хэлэлцэх асуудлыг бэлтгэхээр ажлын хэсэг байгуулж, эксперт оролцуулах, бие даасан шинжилгээ хийлгэх эрхтэй. Солонгосын Үндэсний Ассамблейн тухай хуульд чухал асуудал, эсхүл нарийн мэргэжлийн мэдлэг шаардагдах асуудлыг хянан шалгахтай холбогдуулан тухайн асуудлаар мэдлэг, туршлагатай шинжээчийг хорооны шийдвэрээр ажиллуулах зохицуулалт туссан байна.

Энэ нь хорооны хяналтыг зөвхөн гишүүдийн хэлэлцүүлгээр хязгаарлахгүйгээр мэргэжлийн холбоо, судлаач, шинжээчийн мэдээлэл, арга зүйн туслалцаанд тулгуурлан хэрэгжүүлэх хэлбэр юм.

**Ажлын хэсгийн удирдамж, санал-дүгнэлт (§9.4, 5).** Олон улсад хяналтын ажлын хэсгийн үйл ажиллагааг зорилго, хамрах хүрээ, хугацаа, бүрэлдэхүүн, тайлагнах хэлбэрээр нь урьдчилан тодорхойлдог. Солонгосын Төрийн захиргааны байгууллагын хяналт, шалгалтын тухай хуульд хяналтын төлөвлөгөөнд хяналтын ажлын хэсгийн зохион байгуулалт, хуваарь, удирдамжийг, шалгалтын төлөвлөгөөнд зорилго, хамрах хүрээ, хугацаа, шаардагдах төсвийг тусгахаар зохицуулсан байна.

Мөн хяналт, шалгалтын хороо нь үр дүнгийн тайлангаа Үндэсний Ассамблейн даргад хүргүүлж, уг тайланг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг. Энэ нь хорооны ажлын хэсгийн үйл ажиллагааг тогтоосон удирдамж, хугацаа, тайлагнах хэлбэртэй холбож, хяналтын үр дүнг санал-дүгнэлт болон парламентын хэлэлцүүлэг, шийдвэрийн үндэслэл болгодог байна.

## 2.2.5.Хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ</b>
10.1.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.	10.1.Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа үр дүнг үндэслэн шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эсхүл хүчингүй болгох арга хэмжээ авна.
10.2.Улсын Их Хурлаас энэ хуулийн 10.1-д заасны дагуу Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагад үүрэг, чиглэл өгсөн тогтоолын биелэлтийн тайланг холбогдох байгууллага энэ хуулийн 14.3-т зааснаас бусад тохиолдолд ээлжит чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.	10.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх талаар тус тус Засгийн газар, холбогдох байгууллагад чиглэл өгөхтэй холбоотой асуудлаар тогтоол гаргана.
10.3.Тогтоолын биелэлтийн тайланг Улсын Их Хуралд ирүүлснээс хойш нэг сарын дотор холбогдох Байнгын хороо хэлэлцэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд оруулж болно.	10.3.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгоно.
10.4.Байнгын хороо хяналт шалгалтынхаа үр дүнд үндэслэн Засгийн газраас баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт /цаашид “Засгийн газрын шийдвэр” гэх /-ыг хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн бол Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулна.	10.4.Холбогдох байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 10.1, 10.2-т заасан Улсын Их Хурлын шийдвэрийн тайланг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулна.
	10.5.Энэ хуулийн 10.1, 10.2-т заасан Улсын Их Хурлын шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан түүний хэрэгжилтийн явц болон гүйцэтгэлийн мэдээллийг дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ: 10.5.1.байгууллагын албан ёсны цахим хуудсанд тусгайлан заасан цэсэд улирал тутам шинэчлэн байршуулах; 10.5.2.эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хавсаргана.
	10.6.Энэ хуулийн 10.5-д заасан мэдээллийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр байршуулаагүй, хугацаа хожимдуулсан, дутуу тайлагнасан бол холбогдох албан тушаалтанд Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Хяналтын үр дүнгийн эрх зүйн үр дагавар (§10.1, §10.3).** Парламентын хяналт шалгалтын үр дүн нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, практик шаардлагад нийцүүлэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эсхүл гүйцэтгэх засаглалын хууль бус шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болдог.

Их Британийн Хуулийн комисс хууль батлагдсаны дараах хяналт шинжилгээг тухайн хууль анхны зорилгынхоо дагуу хэрэгжиж байгаа эсэх, хууль болон бодлогын хэрэгжилтийг сайжруулах, дараагийн хууль тогтоомжид сургамж авах ажиллагаа гэж тодорхойлсон байна. ОХУ-ын Парламентын хяналтын тухай хуульд парламентын хяналтыг хууль ёс, дэг журмыг бэхжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт, практик үр нөлөөг сайжруулах, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгохтой холбон зохицуулдаг. Мөн хяналтын үр дүнд хууль тогтоомжийн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, холбогдох хуулийн төсөл санаачлах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандах зэрэг арга хэмжээ авч болохоор тусгасан байна.

Эдгээр зохицуулалт нь парламентын хяналт шалгалтын үр дүнг хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль зөрчсөн шийдвэр, үйл ажиллагааг засах эрх зүйн үр дагавартай.

**Чиглэл, шаардлагын биелэлт, тайлагнал (§10.2, §10.4).** Парламентын хяналт шалгалтын мөрөөр Засгийн газар, холбогдох байгууллагад тодорхой арга хэмжээ авах чиглэл өгөх, түүний биелэлтийг эргэн тайлагнуулах зохицуулалт олон улсын практикт байна. Тухайлбал, Солонгосын Үндэсний Ассамблей хяналт, шалгалтын үр дүнд хууль бус, шударга бус асуудал илэрсэн гэж үзвэл Засгийн газар, холбогдох байгууллагад зөрчил арилгах, тогтолцоо сайжруулах, төсвийн тодотгол хийх зэрэг арга хэмжээ авахыг шаардах эрхтэй бөгөөд Засгийн газар хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ үр дүнг Парламентад тайлагнах үүрэгтэй. Энэ нь парламентын хяналт шалгалтын мөрөөр өгсөн чиглэл, шаардлага, зөвлөмжийг хэрэгжилтийн тайлагналтай холбож буй хэлбэр юм.

## 2.3.Улсын Их Хурлын хяналт хэрэгжүүлэх

### 2.3.1.Асуулга тавих

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
<b>12 дугаар зүйл.Асуулга тавих</b>	<b>12 дугаар зүйл.Асуулга тавих</b>
12.1.Хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсаныг “асуулга” гэнэ.	12.1.Асуулга нь дараах хэлбэртэй байна: 12.1.1.хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт, үр дүнг тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардах зорилгоор гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсан асуулга; 12.1.2.гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийг засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад

	асуудлаар асуулт тавьж, нэгдсэн хуралдаан дээр хариулт авахыг Улсын Их Хурлын асуулга.
12.4.Гишүүний асуулгын хариуг холбогдох Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.	12.4.Гишүүний асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Асуулгын хэлбэр, хариулах субъект (§12.1).** Парламентын гишүүн хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газрын бодлого, төсөв, салбарын нөхцөл байдал, төрийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг тодруулахаар хуульд заасан албан тушаалтанд бичгээр асуулга тавих зохицуулалт олон улсад хэрэгждэг.

ХБНГУ-д Бундестагийн гишүүдийн дор хаяж таван хувь, эсхүл парламентын бүлэг тодорхой сэдвээр Холбооны Засгийн газарт бичгээр асуулга тавьж болно. ОХУ-д Төрийн Думын гишүүд Засгийн газрын Тэргүүн, гишүүд, Ерөнхий прокурор, Төв банкны дарга, Тооцооны танхимын дарга зэрэг албан тушаалтанд эрхлэх асуудлын хүрээнд асуулга тавих эрхтэй. Эстонид Рийгикогугийн гишүүд Засгийн газар, түүний гишүүдээс гадна Төв банк, Ерөнхий аудитор, Хууль зүйн канцлер зэрэг албан тушаалтанд тухайн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуулга бичгээр тавина.

Эдгээр зохицуулалт нь асуулгыг зөвхөн Засгийн газрын гишүүнд бус, хуулиар тодорхой чиг үүрэг хүлээсэн буюу парламентын өмнө тайлагнадаг байгууллага, албан тушаалтанд хандах хяналтын хэлбэр болгон хэрэглэдгийг харуулж байна.

**Асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх (§12.4).** Асуулгын хариу нь зөвхөн бичгээр ирүүлэх мэдээлэл бус, зарим улсад нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хяналтын хэлбэр байна. ХБНГУ-д тодорхой тооны гишүүн шаардсан бол асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж болно. Эстонид асуулгын хариуг 20 хоногийн дотор нэгдсэн хуралдаанд сонсож, түүнтэй холбогдуулан мэтгэлцээн явуулдаг. Францад бичгээр тавьсан асуулгыг Үндэсний Ассамблейн Ерөнхийлөгчөөр дамжуулан Засгийн газарт уламжилж, асуулга болон хариуг албан ёсоор нийтлэхээр журамласан байна. Эдгээр жишээ нь асуулгын хариуг парламентын нээлттэй хэлэлцүүлэг, мэдээллийн ил тод байдалтай холбодог хэлбэр юм.

### 2.3.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
13 дугаар зүйл.Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг сонсож, хэлэлцэх	13 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх, бусад байгууллагаас ирүүлсэн тайлан, дүнг хэлэлцэх
13.1.“Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээ” гэж хууль тогтоомжийн биелэлтийн явцад хуримтлагдсан өгөгдлүүдийг задлан шинжилж, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг	13.1.Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг /цаашид “үнэлгээ” гэх/ энэ хуулийн 8.2-т заасан цаглаварт тусгасны дагуу хийх бөгөөд үнэлгээний тайланг холбогдох Байнгын хороо тухай бүр хэлэлцэнэ.

<p>тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээг тодорхойлоход чиглэсэн цогц үйл ажиллагааг ойлгоно.</p>	
<p>13.2.Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт хийх үнэлгээг:  13.2.1.хууль тогтоомжид бүхэлд нь;  13.2.2.хууль тогтоомжийн зарим зүйл, хэсэг, заалтад;  13.2.3.тодорхой харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн зохицуулалтад хийж болно.</p>	<p>13.2.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 8.3-т заасан саналд нэгээс дээшгүй үнэлгээний ажил төлөвлөж тусгана.</p>
<p>13.3.Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээг энэ хуулийн 8.2-т заасан цаглаварт тусгасны дагуу хийнэ.</p>	<p>13.3.Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагаас үнэлгээний тайланг тухай бүр холбогдох Байнгын хороо, Тамгын газарт хүргүүлж, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээллийн нэгдсэн санд байршуулах бөгөөд Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл үнэлгээний тайланг тухай бүр хэлэлцэнэ.</p>
<p>13.4.Гишүүний хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх саналыг холбогдох Байнгын хороо дэмжсэн бол энэ хуулийн 8.3-т заасан саналд тусгуулан шийдвэрлүүлнэ.</p>	<p>13.4.Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага нь үнэлгээний ажлын нэгдсэн дүнгээ дараа жилийн төлөвлөгөөний хамт жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурал дараах журмаар дүн шинжилгээ хийж, хэлэлцэнэ:  13.4.1.Тамгын газар холбогдох тайланд үндэслэн тайланд дурдсан асуудалд шалтгаан, үр дагаврын шинжилгээ хийх;  13.4.2.Хууль зүйн байнгын хороо үнэлгээний нэгдсэн дүнг энэ хуулийн 13.4.1-д заасан шалтгаан, үр дагаврын шинжилгээний тайлангийн хамт хэлэлцэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах;  13.4.3.нэгдсэн хуралдаанаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг дараа оны хаврын ээлжит чуулган хаахаас өмнө хэлэлцэж, шаардлагатай бол Хууль тогтоомжийн тухай хуулийн 52.1-д заасан авах арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг батлах.</p>
<p>13.5.Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</p>	<p>13.5.Улсын Их Хурлаас үнэлгээ хийхтэй холбогдуулан Засгийн газар болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлан, баримт бичгийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж өгөх үүрэгтэй.</p>
<p>13.6.Холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтэд хөндлөнгийн, хараат бус байгууллага, тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, төрийн бус байгууллагаар үнэлгээг хийлгэх буюу хамтарч болно.</p>	<p>13.6.Улсын Их Хурлаас үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагаас үнэлгээний тайлан хүлээн авах, шалтгаан, үр дагаврын дүн шинжилгээ хийхтэй холбоотой журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батлах бөгөөд шаардлагатай бол уг журамд холбогдох аргачлалыг тусгана.</p>
<p>13.7.Тамгын газар Улсын Их Хурлын, Засгийн газар, төрийн бусад байгууллага хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг 10 хоногийн дотор мэдээллийн нэгдсэн санд байршуулж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.</p>	<p>13.7.Энэ зүйл нь хууль санаачлагч Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасны дагуу үнэлгээ хийлгэхэд хамаарахгүй.</p>

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Хууль батлагдсаны дараах хяналт ба парламентын хэлэлцүүлэг (§13.1).** Олон улсад батлагдсан хууль тогтоомж анхны зорилгоо хангаж буй эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа болон нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг эргэн шинжлэх үйл ажиллагааг “хууль батлагдсаны дараах хяналт” /post-legislative scrutiny/ гэж тодорхойлж, парламентын хяналтын нэг төрөл болгон хөгжүүлж байна.

Их Британид Засгийн газрын яамд хууль батлагдсанаас хойш ерөнхийдөө 3-5 жилийн дараа тухайн хуулийн хэрэгжилтийн талаарх меморандумыг Парламентад хүргүүлдэг. Энэ нь Нийтийн Танхимын холбогдох хороо болон Лордын Танхимын түр хорооноос хийх хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний суурь мэдээлэл болдог байна.

**Парламентын ажлын албаны мэргэшсэн дүн шинжилгээ (§13.2, §13.4, §13.6).** Олон улсад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд парламентын хороод дангаар бус, мэргэшсэн судалгаа, дүн шинжилгээний чадавхад тулгуурладаг. Тухайлбал, Швейцарт Парламентын хяналтын газар нь хяналтын хороодод үнэлгээ, судалгааны дэмжлэг үзүүлдэг бол Италид Танхимын захиргааны ажлын албаны хяналт, үнэлгээний нэгж гүйцэтгэх засаглал болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээлэлд шинжилгээ хийж, парламентын хяналтад дэмжлэг үзүүлдэг байна. Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ, үр дагаврын шинжилгээг парламентын ажлын албаны мэргэшсэн дүн шинжилгээтэй холбож хэрэгжүүлж байгаа хэлбэр юм.

**Үнэлгээний тайлан, мэдээллийн урсгал (§13.3, §13.5).** Олон улсын жишгээр засгийн газар болон холбогдох байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг парламентад хүргүүлж, парламентын хяналтын хүрээнд хэлэлцүүлдэг. Их Британид яамд хууль хэрэгжиж эхэлснээс хойш тодорхой хугацааны дараа хэрэгжилтийн меморандумыг Парламентад хүргүүлдэг. Шведэд Үндэсний аудитын газрын тайланд үндэслэн Парламентаас Засгийн газарт мэдэгдэл хүргүүлж, Засгийн газар авсан болон төлөвлөж буй арга хэмжээнийхээ талаар эргэн тайлагнадаг.

Эдгээр зохицуулалт нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан, мэдээллийг парламентын мэдээллийн урсгалд оруулж, холбогдох хорооны хэлэлцүүлэг, санал-дүгнэлттэй холбож байна.

### 2.3.3. Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>15 дугаар зүйл.Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх</b>	<b>15 дугаар зүйл.Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх</b>
15.1.Улсын Их Хурал дараах тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэнэ:	15.1.Улсын Их Хурал дараах тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэнэ:
15.1.1.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайланг жил бүр;	15.1.1.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайланг жил бүр;
15.1.2.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг тухай бүр;	15.1.2.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг тухай бүр;

15.1.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг жил бүр;	15.1.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг хаврын чуулганы хугацаанд;
15.1.4.Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг жил бүр, төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн биелэлт, мөнгө, зээлийн байдлын талаарх Монголбанкны мэдээллийг шаардлагатай тохиолдолд;	15.1.4.Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын тайлан болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг жил бүр, төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн биелэлт, мөнгө, зээлийн байдлын талаарх Монголбанкны мэдээллийг шаардлагатай тохиолдолд;
15.1.5.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг жил бүр, Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг хоёр жил тутам;	15.1.5.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг жил бүр, Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг хоёр жил тутам;
15.1.6.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд;	15.1.6.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд;
15.1.7.банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны тайланг жил бүр;	15.1.7.банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны тайланг жил бүр;
15.1.8.Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны тайланг жил бүр;	15.1.8.Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны тайланг жил бүр;
15.1.9.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;	15.1.9.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;
15.1.10.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;	15.1.10.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;
15.1.11.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;	15.1.11.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;
15.1.12.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн биелэлтийн тайланг гурван жил тутам, өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг жил бүр;	15.1.12.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн биелэлтийн тайланг гурван жил тутам;
15.1.13.Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг жил бүр;	15.1.13.Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг жил бүр;
15.1.14.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг жил бүр;	15.1.14.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг жил бүр;
15.1.15.Олон Улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний биелэлтийн талаарх Засгийн газрын тайланг хоёр жил тутам;	15.1.15.Олон Улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний биелэлтийн талаарх Засгийн газрын тайланг хоёр жил тутам;
15.1.16.жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн биелэлтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн биелэлт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг хоёр жил тутам;	15.1.16.жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн биелэлтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн биелэлт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг хоёр жил тутам;

15.1.17.Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн биелэлтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг тухай бүр;	15.1.17.Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн биелэлтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг тухай бүр;
15.1.18.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр.	15.1.18.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр.
15.2.Улсын Их Хуралд дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд ирүүлнэ:	15.2.Улсын Их Хурал дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд хэлэлцэнэ:
15.2.1.авлигатай тэмцэх хууль тогтоомжийн биелэлт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр;	15.2.1.авлигатай тэмцэх хууль тогтоомжийн биелэлт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр;
15.2.2.эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг жилд нэгээс доошгүй удаа.	15.2.2.эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг жилд нэгээс доошгүй удаа.
15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдээллийн нэгдсэн сан болон Улсын Их Хурлын цахим хуудсанд нийтэлж, байршуулна.	15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдээллийн нэгдсэн сан болон Улсын Их Хурлын цахим хуудсанд нийтэлж, байршуулна.
15.4.Энэ хуулийн 15.1-д заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.	15.4.Энэ хуулийн 5.1.1, 15.1.5-15.1.8, 15.1.14, 15.1.18-д заасан үйл ажиллагааны тайланд түүнийг ирүүлснээс хойш ажлын 20 өдрийн дотор Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Тайлан, илтгэл, мэдээллийг парламентын хяналтын хүрээнд хэлэлцэх (§15.1, §15.2).** ОХУ, Шинэ Зеланд, Эстони зэрэг улсад гүйцэтгэх засаглал, аудитын зэрэг байгууллагын тайлан, мэдээллийг хуульчилсан хугацаа, дэгийн дагуу парламентаар хэлэлцдэг. ОХУ-д Тооцооны танхим үйл ажиллагааны жилийн тайлангаа дараа жилийн 3 дугаар сарын 1-ний дотор Төрийн Думд хүргүүлж, Ерөнхий прокурорын жилийн тайлан, хууль хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нөхцөл байдлын мэдээллийг парламентын хяналтын хүрээнд сонсдог. Эстонид Рийгикогу Хууль зүйн канцлерын тайлантай жил бүр танилцаж, улсын төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газрын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн хамт хэлэлцдэг. Шинэ Зеландад Парламентын сонгон шалгаруулах хороо тухайн жилийн тайланг тогтоосон хугацаанд өргөн мэдүүлсний дараа уг тайланг хянан хэлэлцэх мэтгэлцээний хүрээнд авч үздэг.

Эндээс үзэхэд, дээрх жишээ нь тайлан, илтгэл, мэдээллийг парламентад зөвхөн ирүүлээд зогсохгүй, мөн хуульчилсан хугацаа, дэгийн дагуу хэлэлцэх хяналтын хэлбэр болгон ашиглаж байна.

**Тайланд хийх дүн шинжилгээ, хорооны хэлэлцүүлэг (§15.4).** Парламентын хяналтын хүрээнд ирүүлсэн тайлан, мэдээллийг хорооны түвшинд урьдчилан судалж, шаардлагатай тохиолдолд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хэлэлцэх зохицуулалт олон улсад байна. Тухайлбал, Шинэ Зеландад сонгон шалгаруулах хороо байгууллагын жилийн тайланг хэлэлцдэг бол Эстонид аудитын болон үндсэн хуулийн хяналтын байгууллагын тайланг Рийгикогугээр хэлэлцүүлдэг. Энэ нь тайлан, илтгэл, мэдээллийг парламентын хяналтын мэдээллийн эх сурвалж болгон ашиглаж, хорооны хэлэлцүүлэг болон дүн шинжилгээний шаттай холбон хэрэгжүүлж байна.

## 2.3.4. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн тайланг хэлэлцэх

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>16 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх</b>	<b>16 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэх, үүрэг амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих</b>
16.1. Улсын Их Хурлаас Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.	16.1. Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад үүрэг, чиглэл болгосон буюу хуулиар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт батлахаар заасан Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг дараа оны 03 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.
16.2. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлснээс хойш 15 хоногийн дотор Тамгын газар Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр дүн шинжилгээ хийж, танилцуулгын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.	16.2. Энэ хуулийн 16.1-д заасан тайланд Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг дүгнэх үнэн зөв, бодитой, иж бүрэн, үр дүнд суурилсан, нотлох баримт бүхий мэдээллийг тусгана.
16.3. Байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг энэ хуулийн 16.2-т заасан танилцуулгыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор хэлэлцэнэ.	16.3. Тамгын газар энэ хуулийн 16.1-д заасан тайланг энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл холбогдох байгууллагад буцаах буюу нэмэлт мэдээллийг гаргуулж болно.
16.4. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланд дүн шинжилгээ хийх журам, аргачлалыг Улсын Их Хурлын дарга батална.	16.4. Тамгын газар Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр биелэлтийн тайланд дүн шинжилгээ хийж, Байнгын хороодод хүргүүлэх бөгөөд шийдвэрийн биелэлтийн нэгдсэн дүнг Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.
	16.5. Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 16.1-д заасан тайлан, 16.4-т заасан дүн шинжилгээг хэлэлцэж, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, Улсын Их Хурлын шийдвэр, холбогдох заалтыг хяналтаас хасах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.
	16.6. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 9.1-д заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулж болно.
	16.7. Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт, санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэж, нэгдсэн хуралдаанд оруулна.
	16.8. Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг жил бүрийн 06 дугаар сарын 15-ны дотор хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл дараах шийдвэр гаргана: 16.8.1. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр даалгах; 16.8.2. Улсын Их Хурлын шийдвэр, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтыг хяналтын

	бүртгэлээс хасах талаар холбогдох Байнгын хороо, Тамгын газарт чиглэл өгөх;
	16.9.Тамгын газар Улсын Их Хурлын шийдвэрийн хяналтын бүртгэл хөтлөх, үүрэг чиглэл болгосон шийдвэрийг хяналтад авах, хяналтаас хасах санал гаргах, биелэлтийн тайланг хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх ажлыг эрхлэх бөгөөд холбогдох журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.
	16.10.Улсын Их Хурлын шийдвэрийг бүртгэх, хяналт тавих Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагаанд нэгдсэн цахим систем бүрдүүлж, ашиглаж болно.
	16.11.Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны хэлэлцүүлгийн шатанд Засгийн газрын гишүүн, бусад байгууллагын удирдлагаас өгсөн тодорхой хугацаатай, хэрэгжих боломжтой амлалт, үүрэг бүхий тайлбарыг “Амлалт” /цаашид “амлалт” гэх/ гэж үзэж, Тамгын газар бүртгэн хэрэгжилтэд хяналт тавина.
	16.12.Энэ хуулийн 16.11-д заасан амлалт, тайлбарыг холбогдох албан тушаалтан ажлын 5 өдрийн дотор Тамгын газарт ирүүлнэ.
	16.13.Амлалтын биелэлт хангалтгүй, эсхүл хугацаа хоцорсон тохиолдолд холбогдох Байнгын хороо тухайн албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай бол хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.
	16.14.Амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын дарга батална.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Парламентын шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийн тайлагнал (§16.1-16.2).** Олон улсад парламентын хяналтын мөрөөр гарсан шийдвэр, зөвлөмжийн биелэлтийг холбогдох байгууллагаас эргэн тайлагнуулахыг хууль тогтоомжоор үүрэг болгож байна. Тухайлбал, Солонгост хяналт, шалгалтын тайланг Үндэсний Ассамблейн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газар болон холбогдох байгууллагад тодорхой арга хэмжээ авахыг үүрэг болгосон бол түүний хэрэгжилтийг нь эргэн тайлагнуулах зохицуулалттай. ОХУ-д парламентын хяналтын үр дүнд гаргасан санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд авч үзэж, хэрэгжилтийн үр дүнг эргэн мэдэгдэх үүрэгтэй.

Энэ нь парламентын шийдвэр, зөвлөмжийг нэг удаагийн хэлэлцүүлгээр дуусгахгүй, хэрэгжилтийн тайлан, хариу мэдээлэлтэй холбосон парламентын хяналтын нэг хэлбэр байна

**Хэрэгжилтийг хэлэлцэх, хяналтыг дуусгавар болгох ажиллагаа (§16.3-16.5).** Их Британид Парламентын хорооны тайлан, зөвлөмжид Засгийн газраас тогтоосон хугацаанд эргүүлээд албан хариу өгдөг. Шинэ Зеландад төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн тайланг холбогдох хороогоор хэлэлцэж, дүгнэлтээ Парламентын нэгдсэн хуралдаанд танилцуулдаг.

Парламент эхлээд өөрийн шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг нэхэн авч, дараа нь мэргэжлийн хорооны болон нэгдсэн хуралдаанаар авч хэлэлцэж байгаа нь хянатын шаталсан хэлбэрээр хэрэгжүүлж байна.

**“Амлалтын бүртгэл” хэрэгжүүлэх (§16.12-16.15).** Энэтхэгийн Лок Сабха (Доод танхим) дахь Committee on Assurances нь 1953 оноос хойш Засгийн газрын амлалтуудыг хянаж байгаа туршлагатай загвар юм. Энэ загварын дагуу:

- Сайд нарын чуулганы болон хорооны хуралдаан дахь амлалт бүр бүртгэгддэг.
- 3-6 сарын дотор биелэлтийн тайлан шаардагддаг.
- Биелэгдээгүй амлалт тус бүрийн шалтгаан тайлагнуулдаг.
- Дижитал бүртгэлийн систем ашигладаг.

Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүд болон бусад этгээд янз бүрийн мэдэгдэл, хариулт, арга хэмжээний амлалт өгдөг боловч уг мэдэгдлүүдийг системтэйгээр бүртгэх нэгдсэн механизм байхгүй, биелэлтийг хянах хугацаа, хариуцах этгээд тодорхойгүй, тавьсан үүрэг, амлалтын биелэлтийг давтан шалгах, нийтэд мэдээлэх журам дутмаг байна.



## 2.4.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ</b>	<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ</b>
<b>17 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b>	<b>17 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b>
17.1.Улсын Их Хурал жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцэх бөгөөд энэ хуулийн 17.2-т заасан асуудлыг хянан хэлэлцэнэ.	17.1.Улсын Их Хурал жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө /цаашид “төлөвлөгөө” гэх/-ний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхдээ дараах хүрээнд хэлэлцэнэ: 17.1.1.төлөвлөсөн үр дүн, зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хүрээгүй шалтгаан нөхцөл; 17.1.2.төлөвлөсөн үр дүнгийн хүрсэн түвшинг тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрээр; 17.1.3.төлөвлөгөөний зорилтын хэрэгжилт нь дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн хэдэн хувьд хүрснийг; 17.1.4.цаашид авах арга хэмжээ.
17.2.Улсын Их Хуралд ирүүлэх улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгана: 17.2.1.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт нь тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр болон нэгдсэн дүнгээр, тухайн жилийг өмнөх жилтэй харьцуулан; 17.2.2.тухайн жилийн биелэлт нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг төсөл, арга хэмжээ тус бүрийн хувиар харьцуулан; 17.2.3.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан, нөхцөлд хийсэн дүн шинжилгээний үр дүн, цаашид авах арга хэмжээний тодорхой санал.	17.2.Засгийн газар улсын төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гүйцэтгэлийн тайлангийн хамт жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.
17.3.Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.	17.3.Тамгын газар хуулийн 17.2, 17.5-д заасан тайлан болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 <sup>1</sup> .5.3-т заасны дагуу хийсэн дүгнэлтийг үндэслэн төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнгийн талаарх нэгдсэн дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээний саналын хамт 04 дүгээр сарын 10-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ.
17.4.Тамгын газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор энэ хуулийн 17.2-т заасан бүрдлийг хянаж, нэмэлт	17.4.Тамгын газар энэ хуулийн 17.3-т заасан дүгнэлт, санал гаргахад нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл Засгийн газар болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс

мэдээлэл шаардлагатай гэж үзвэл үндэслэл бүхий тайлбарын хамт Засгийн газарт мэдэгдэнэ.	холбогдох мэдээллийг ажлын 5 өдрийн дотор авна.
17.5.Засгийн газар энэ хуулийн 17.2-т заасан бүрдлийн шаардлагыг хангах арга хэмжээг авч, гүйцэтгэлийн тайланг өргөн мэдүүлэхээс 20 хоногийн өмнө Тамгын газарт хүргүүлнэ.	17.5.Төрийн аудитын байгууллага төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, жил бүрийн 03 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.
17.6.Төрийн аудитын байгууллага улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлсэн байна.	17.6.Улсын Их Хурал Засгийн газраас ирүүлсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг энэ хуулийн 17.5-д заасан аудитын тайлан, 17.3-т заасан дүгнэлт, саналын хамт хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа Засгийн газрын үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт өгч, хэрэгжиж буй жилийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, эсхүл холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар Засгийн газарт тогтоолоор үүрэг, чиглэл өгнө.
<b>18 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b>	<b>18 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b>
18.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хэлэлцэнэ.	18.1.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /цаашид “үндсэн чиглэл” гэх/-ийн гүйцэтгэл, үр дүнг дуусгавар болох оны 6 дугаар сарын 20-ны дотор, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн гүйцэтгэл, үр дүнг дуусгавар болох оны 05 дугаар сарын 15-ны дотор дараах хүрээнд хэлэлцэнэ: 18.1.1.үндсэн чиглэл болон хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх; 18.1.2.үндсэн чиглэл болон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны үр дүн нь дунд хугацааны баримт бичгийн хэдэн хувьд хүрснийг; 18.1.3.хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үр дүн; 18.1.4.үндсэн чиглэл болон хөтөлбөр хоорондын төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа; 18.1.5.тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжээгүй зорилго, зорилтын шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээ.
18.2.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичиг дуусгавар болох жилийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хэлэлцэх бөгөөд энэ хуулийн 18.3-т заасан асуудлыг хянан хэлэлцэнэ.	18.2.Засгийн газар хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гүйцэтгэлийн тайлангийн хамт дуусгавар болох жилийн 04 дүгээр сарын 01-ний дотор, үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнгийн тайлан, болон холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг гүйцэтгэлийн тайлангийн хамт дуусгавар болох жилийн 04 дүгээр сарын 05-ны дотор Улсын Их Хурал, Төрийн аудитын дээд байгууллагад тус тус ирүүлнэ.
18.3.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгана: 18.3.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх	18.3.Төрийн аудитын дээд байгууллага үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайланг тухайн жилийн 05 дугаар сарын 30-ны дотор, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайланг тухайн жилийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.

<p>үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт, арга хэмжээ тус бүрээр;</p> <p>18.3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тухайн жилийн болон хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр;</p> <p>18.3.3.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5-д заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр;</p> <p>18.3.4.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тухайн жилийн болон хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр.</p>	
<p>18.4.Төрийн аудитын байгууллага Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх жилийн 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.</p>	<p>18.4.Тамгын газар үндсэн чиглэл, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд энэ хуулийн 18.1-д заасан хүрээнд дүн шинжилгээ хийх бөгөөд Засгийн газраас ирүүлсэн тайлан, холбогдох мэдээллийг хянан үзэж, нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл мэдээллийг ажлын 5 өдрийн дотор авна.</p>
<p>18.5.Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>18.5.Тамгын газар үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн дүн шинжилгээг тухайн жилийн 06 дугаар сарын 15-ны дотор, хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн шинжилгээг тухайн жилийн 05 дугаар сарын 10-ны дотор гишүүдэд хүргүүлнэ.</p>
<p>18.6.Тамгын газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор энэ хуулийн 18.3-т заасан бүрдлийг хянан үзэж, нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл үндэслэл бүхий тайлбарын хамт Засгийн газарт мэдэгдэнэ.</p>	<p>18.6.Улсын Их Хурал хөтөлбөрийн болон үндсэн чиглэлийн гүйцэтгэл, үр дүнгийн тайланг энэ хуулийн 18.3-т заасан тайлан, 18.5-д заасан дүн шинжилгээний хамт хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.</p>
<p><b>19 дүгээр зүйл.Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн биелэлтийн явцынболон гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b></p>	<p><b>19 дүгээр зүйл.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b></p>
<p>19.1.Улсын Их Хурал Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн биелэлтийн явцын тайланг таван жил тутам Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хэлэлцэнэ.</p>	<p>19.1.Улсын Их Хурал хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнг тухайн баримт бичиг дуусгавар болохоос зургаан сарын өмнө дараах хүрээнд хянан хэлэлцэнэ:</p> <p>19.1.1.хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх;</p> <p>19.1.2.хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны үр дүн;</p> <p>19.1.3.хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл нь урт хугацааны хөгжлийн бодлогын холбогдох зорилгын хэдэн хувьд хүрсэн, тэдгээрийн уялдаа;</p>
<p>19.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичиг</p>	<p>19.2.Засгийн газар хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнгийн тайлан</p>

дуусгавар болохоос нэг жилийн өмнө Улсын Их Хурал хэлэлцэх бөгөөд энэ хуулийн 19.3-т заасан асуудлыг хянан хэлэлцэнэ.	болон холбогдох хяналт-шинжилгээний тайланг Улсын Их Хурал хэлэлцэхээс гурван сарын өмнө Улсын Их Хурал, Төрийн аудитын дээд байгууллагад тус тус ирүүлнэ.
19.3.Улсын Их Хурал Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгана: 19.3.1.Хөгжлийн зорилтот хөтөлбөр нь урт хугацааны хөгжлийн бодлогын холбогдох зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг хөтөлбөр тус бүрээр; 19.3.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөр нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг зорилго, зорилт тус бүрийн нэгдсэн дүнгээр.	19.3.Тамгын газар хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд энэ хуулийн 19.1-д заасан хүрээнд дүн шинжилгээ хийж, Улсын Их Хурал хэлэлцэхээс 15 өдрийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.
19.4.Засгийн газар Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.	19.4.Тамгын газар хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан тайлан, үр дүнд дүн шинжилгээ хийхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас мэдээллийг ажлын 10 өдрийн дотор гаргуулан авна.
19.5.Тамгын газар Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 19.3-т заасан бүрдлийг хянан үзэж, нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл үндэслэл бүхий тайлбарын хамт Засгийн газарт мэдэгдэнэ.	19.5.Төрийн аудитын дээд байгууллага хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын тайланг Улсын Их Хурал хэлэлцэхээс нэг сарын өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ. Хэрэв хөгжлийн зорилтот хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг аудитын тайландаа тусгана.
19.6.Засгийн газар энэ хуулийн 19.3-т заасан бүрдлийн шаардлагыг хангах арга хэмжээ авч, гүйцэтгэлийн тайланг өргөн мэдүүлэхээс гурван сарын өмнө Тамгын газарт хүргүүлнэ.	19.6.Улсын Их Хурал хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэл, үр дүнг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.
<b>20 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b>	<b>20 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх</b>
20.1.Улсын Их Хурал Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого/цаашид “урт хугацааны хөгжлийн бодлого” гэх/-ын хэрэгжилтийн явцын тайланг 10 жил тутам Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хэлэлцэнэ.	20.1.Улсын Их Хурал Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (цаашид “урт хугацааны хөгжлийн бодлого” гэх)-ын гүйцэтгэл, үр дүнг тухайн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас хоёр жилийн өмнө хянан хэлэлцэнэ.
20.2.Урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас хоёр жилийн өмнө Улсын Их Хурал хэлэлцэх бөгөөд энэ хуулийн 20.3-т заасан асуудлыг хянан хэлэлцэнэ.	20.2.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнг зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг зорилго, зорилт бүрээр хянан хэлэлцэнэ.
20.3.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланд бодлогын зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг зорилго, зорилт тус бүрээр тусгана.	20.3.Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний хамт Улсын Их Хурал хэлэлцэхээс нэг жилийн өмнө Улсын Их Хурал болон Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлнэ.
20.4.Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан	20.4.Тамгын газар энэ хуулийн 20.3-т заасан тайланд энэ хуулийн 20.3, 20.7-д заасан тайланд тулгуурлан дүн шинжилгээ хийж,

сарын өмнө Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.	Улсын Их Хурлаар хэлэлцэхээс 45 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.
20.5.Тамгын газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 20.3-т заасан бүрдлийг хянан үзэж, нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл үндэслэл бүхий тайлбарын хамт Засгийн газарт мэдэгдэнэ.	20.5.Тамгын газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэл, үр дүнд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг Засгийн газар, түүний яам, агентлаг нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй.
20.6.Засгийн газар энэ хуулийн 20.3-т заасан бүрдлийн шаардлагыг хангаж, гүйцэтгэлийн тайланг өргөн мэдүүлэхээс гурван сарын өмнө Тамгын газарт хүргүүлнэ.	20.6.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэл, үр дүнд аудит хийж, Улсын Их Хурлаар хэлэлцэхээс гурван сарын өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.
20.7.Төрийн аудитын байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланд аудит хийж, Улсын Их Хурлаар гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхээс гурван сарын өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.	20.7.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт бүрэн хэрэгжээгүй, шалгуур үзүүлэлтээ бүрэн хангаагүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг тайландаа тусгана.
20.8.Төрийн аудитын байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгана.	20.8.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнгийн талаар тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.
20.9.Төрийн аудитын байгууллага урт хугацааны хөгжлийн бодлого бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний тодорхой саналыг дүгнэлтдээ тусгана.	20.9.Энэ хуулийн 17-20 дугаар зүйлд заасан тайланд дүн шинжилгээ хийх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг хэлэлцэх хүрээ (§17.1, §18.1, §19.1, §20.1).** Парламентуудад хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэхдээ тухайн баримт бичгийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийн явц, санхүүжилт, хариуцах байгууллага, цаашид авах арга хэмжээг хамтатган авч үздэг байна. Энэ нь жилийн төлөвлөгөө, дунд хугацааны хөтөлбөр, урт хугацааны бодлогын хэрэгжилтийг тус тусад нь салангид бус, бодлогын мөчлөг, гүйцэтгэлийн үзүүлэлттэй уялдуулан хянан хэлэлцдэг хэлбэр юм.

Тухайлбал, ХБНГУ-д Тогтвортой хөгжлийн үндэсний стратегийн хэрэгжилтийг салбарын зорилт, шалгуур үзүүлэлтээр тайлагнаж хэлэлцдэг. Казахстан, Латви зэрэг улсад хөгжлийн бодлогын хэрэгжилтийн мониторингийг тогтмол хийж, үнэлгээний тайлан, статистик мэдээлэл, хяналт шалгалтын материалд үндэслэн хэрэгжилтийн явцыг авч үздэг байна. Эдгээр жишээ нь хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зөвхөн тайлан сонсох бус, зорилт, шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийн үр дүнгээр хянан хэлэлцдэг практикийг харуулж байна.

**Тайлангийн урьдчилсан нягтлал, парламентын ажлын албаны дүн шинжилгээ (§17.3-17.5, §18.5-18.7, §19.4-19.6, §20.4-20.6).** Парламентын хэлэлцүүлгийн өмнө бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон холбогдох баримт бичгүүдийг мэргэжлийн түвшинд нягтлах, шаардлагатай нэмэлт мэдээлэл гаргуулах зохицуулалт олон улсад байна. Тухайлбал, Казахстан, Латви зэрэг улсад хөгжлийн бодлогын хэрэгжилтийн мэдээллийг мэргэжлийн байгууллага, судалгааны болон хяналтын нэгжүүд урьдчилан үзэж, парламентын хэлэлцүүлгийн мэдээллийн суурь болгодог.

Италид Парламентын Тамгын захиргааны ажлын албаны хяналт, үнэлгээний нэгж гүйцэтгэх засаглал болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээлэлд шинжилгээ хийж, парламентын хяналтад дэмжлэг үзүүлдэг. Энэ нь бодлогын хэрэгжилтийн тайланг парламентын хэлэлцүүлэгт оруулахын өмнө бүрдэл, мэдээллийн чанар, хэрэгжилтийн үндэслэлийг мэргэжлийн түвшинд нягталдаг хэлбэр юм.

**Аудитын дүгнэлт ба парламентын хэлэлцүүлэг (§17.6-17.8, §18.4, §18.8-18.10, §19.7-19.10, §20.7-20.12).** Парламентаар хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэхэд аудитын байгууллагын хараат бус дүгнэлт, баталгаажуулалтад тулгуурлах практик олон улсад байна. Казахстан, Австри зэрэг улсад үндэсний аудитын байгууллага бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үр нөлөө, төсвийн зарцуулалтад аудит хийж, дүгнэлтээ парламентад хүргүүлдэг. Шинэ Зеландад төрийн байгууллагуудын жилийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Парламентаар хэлэлцдэг бол ОХУ-д Тооцооны танхим төсвийн болон төрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргаж, парламентын хэлэлцүүлэгт мэдээлэл өгдөг.

Эдгээр зохицуулалт нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын өөрийн тайланд дангаар нь үндэслэхгүй, аудитын хараат бус дүгнэлт, хэрэгжилтийн шалтгаан-нөхцөл, цаашид авах арга хэмжээний саналтай хамтатган парламентын хэлэлцүүлэгт оруулдаг хэлбэр юм.



## 2.5.Төсвийн хяналт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
ТАВДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ХЯНАЛТ	ТАВДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ХЯНАЛТ
<b>21 дүгээр зүйл.Төсвийн хяналтын зарчим, төрөл</b>	<b>21 дүгээр зүйл.Төсвийн хяналтын зарчим, төрөл</b>
<p>21.3.1.нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт;  <a href="#">/Энэ заалтад 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a></p> <p>21.3.2.гурав дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт.  <a href="#">/Энэ заалтад 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a></p>	<p>21.3.1.нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт;            21.3.2.хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт.</p>
<b>23 дугаар зүйл.Төсвийн төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт</b> <a href="#">/Энэ зүйлийн гарчигт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a>	<b>23 дугаар зүйл.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт</b>
<p>23.1.Төсвийн төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавина:  <a href="#">/Энэ хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a></p> <p>23.1.1.төсвийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;            23.1.2.Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх;            23.1.3.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх.</p>	<p>23.1.Төсвийн төслийн нэг-дэх хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавина:            23.1.1.төсвийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;            23.1.2.Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх;            23.1.3.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх.</p>
<p>23.3.Энэ хуулийн 23.2-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал хоёр дахь хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.  <a href="#">/Энэ хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a></p>	<p>23.3.Энэ хуулийн 23.2-т заасан дүгнэлтийг харгалзан шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал нэг дэх хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана.</p>
	<p>23.6.Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлалыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.</p>
<b>24 дүгээр зүйл.Гурав дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт</b> <a href="#">/Энэ зүйлийн гарчигт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a>	<b>24 дүгээр зүйл.Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт</b>
<p>24.1.Гурав дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнд тавих хяналтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.  <a href="#">/Энэ хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</a></p>	<p>24.1.Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнд тавих хяналтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.</p>
<p>24.2.Гурав дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал</p>	<p>24.2.Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргаж олонхын</p>

<p>энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэхэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн шатанд уг дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ. <u>/Энэ хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p>	<p>дэмжлэг авсан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэхэд Тамгын газар дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, нэгдсэн хуралдааны төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд уг дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.</p>
<p>24.3.Гурав дахь хэлэлцүүлгийн үе шатанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн байнгын хороог шаардлагатай тооцоо, мэдээллээр хангаж ажиллана. <u>/Энэ хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p>	<p>24.3.Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн байнгын хороог шаардлагатай тооцоо, мэдээллээр хангаж ажиллана.</p>

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

### **Төсвийн төслийн хэлэлцүүлгийн үеийн урьдчилсан хяналт (§23.1, §23.3).**

Парламентууд төсвийн төслийг хэлэлцэхдээ Үндсэн хууль, төсвийн болон санхүүгийн тогтвортой байдлын шаардлага, хөгжлийн бодлого, төсвийн хүрээний үзүүлэлттэй нийцэж байгаа эсэхийг хянадаг. Тухайлбал, ОХУ, Итали, Швейцарт төсвийн төсөл хууль, бодлогын шаардлага хангаагүй тохиолдолд Засгийн газарт буцаах зохицуулалттай.

Энэ нь төсвийн төслийг парламентын хэлэлцүүлэгт оруулахдаа зөвхөн орлого, зарлагын тооцоогоор бус, хууль зүйн нийцэл, төсвийн тогтвортой байдал, бодлогын уялдаагаар урьдчилан хянадаг хэлбэр юм.

### **Төсвийн санал, өөрчлөлтөд хийх мэргэжлийн шинжилгээ (§24.1-24.3).**

Төсвийн төслийг хэлэлцэх явцад гишүүдээс гаргасан санал, өөрчлөлтийн төсөв, эдийн засаг, бодлогын үр дагаврыг мэргэжлийн нэгжээр шинжлүүлэх практик олон улсад байна. АНУ, Бельги, Герман, Чили, Солонгос, Эстони зэрэг улсад парламентын төсвийн хараат бус байгууллага, төсвийн шинжилгээний нэгжүүд төсвийн төсөл, санал, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, гишүүдийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангадаг байна.

Энэ нь төсвийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал, өөрчлөлтийг төсвийн тогтвортой байдал, хууль хоорондын нийцэл, бодлогын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөгөөр нь мэргэжлийн түвшинд шалгаж, парламентын шийдвэр гаргалтын үндэслэл болгож байна.



## 2.6.Нэр дэвшигчийн сонголт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТЫН СОНГОЛ	ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТЫН СОНГОЛ
<p><b>30 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонголт</b></p> <p>30.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас дараах нэр дэвшигчийн сонголт явуулна:</p> <p>30.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонголт;</p> <p>30.1.2.Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонголт явуулахаар хуульд тусгайлан заасан, эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонголт явуулахаар Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.</p>	<p><b>30 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонголт</b></p> <p>30.1.Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүн, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилохдоо нэр дэвшигчийн сонголт явуулна.</p>

**ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:** Парламентууд шүүх, аудит, хүний эрх, санхүүгийн хяналт, зохицуулалт зэрэг хараат бус болон хяналтын чиг үүрэгтэй байгууллагын удирдах албан тушаалтны томилгоонд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, туршлага, ёс зүй, хараат бус байдлыг урьдчилан хэлэлцэх хэлбэрээр хяналт тавьдаг.

Тухайлбал, Солонгост Үндэсний Ассамблейн зөвшөөрөл шаардагдах Ерөнхий сайд, Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Аудит, хяналтын зөвлөлийн дарга зэрэг албан тушаалтны томилгоонд сонголт зохион байгуулдаг. Канадад Парламентын байнгын хороо тодорхой албан тушаалд нэр дэвшигчийн мэдлэг, чадвар, мэргэшил, туршлагыг хянан хэлэлцдэг. Эстонид Рийгикогу нэр дэвшигчийн томилгоог нэг үе шат бүхий хэлэлцүүлгээр шийдвэрлэдэг. Эдгээр жишээ нь нэр дэвшигчийн сонголыг зөвхөн улс төрийн албан тушаалын томилгоогоор хязгаарлахгүй, хараат бус, хяналт-шалгалт, зохицуулалт, хүний эрх, санхүүгийн хариуцлагын чиг үүрэгтэй байгууллагын удирдах албан тушаалтны томилгоонд урьдчилсан парламентын хяналтын хэлбэрээр хэрэглэдгийг харуулж байна.

## 2.7.Улсын Их Хурлын хяналт шалгах түр хороо

### 2.7.1.Хянан шалгах түр хорооны эрх зүйн байдал

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>ДОЛДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО</b>	<b>ДОЛДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО</b>
<b>Нэгдүгээр дэд бүлэг Хянан шалгах түр хорооны эрх зүйн байдал</b>	<b>Нэгдүгээр дэд бүлэг Хянан шалгах түр хорооны эрх зүйн байдал</b>
<b>32 дугаар зүйл.Хянан шалгах түр хороог байгуулах, татан буулгах</b>	<b>32 дугаар зүйл.Хянан шалгах түр хороог байгуулах, татан буулгах</b>
32.2.Энэ хуулийн 32.1-д заасан асуудлаар Улсын Их Хуралд тогтоолын төсөл өргөн мэдүүлэх бөгөөд уг тогтоолын төсөлд хянан шалгах түр хороо /цаашид энэ бүлэгт “түр хороо” гэх/-ны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана.	32.2.Энэ хуулийн 32.1-д заасан асуудлаар гаргасан саналд Улсын Их Хурлын тогтоолын төслийг хавсаргана. Уг тогтоолын төсөлд хянан шалгах түр хороо /цаашид энэ бүлэгт “түр хороо” гэх/-ны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана.
32.3.Тогтоолын төслийг энэ хуулийн 32.2-т заасны дагуу өргөн мэдүүлсэн бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан дэгийн дагуу чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллыг харгалзахгүйгээр даруй хэлэлцэж, түр хороо байгуулах тогтоол батална.	32.3.Тогтоолын төслийг энэ хуулийн 32.2-т заасан тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллыг харгалзахгүйгээр даруй хэлэлцэж, түр хороо байгуулах тогтоол батална.
32.4.Тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар Үндсэн хуульд харшилсан эсэх талаар санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд оруулна.	32.4.Тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаар талаар санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд оруулна.
32.5.Улсын Их Хурал тогтоолын төсөлд тусгасан түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг зөвхөн дараах үндэслэлээр өөрчилж болно: 32.5.1.Үндсэн хуульд харшилсан гэж холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт гарсан; 32.5.2.санаачлагч гишүүд санал нэгдэн зөвшөөрсөн.	32.5.Улсын Их Хурал тогтоолын төслийн хэлэлцүүлгийн шатанд санаачлагч гишүүд бүгд зөвшөөрснөөр түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг нарийвчлан тодорхойлж болно.
32.6.Түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг өөрчлөхөөр бол энэ хуулийн 32.5-д заасан үндэслэлээр Улсын Их Хурлын тогтоолоор өөрчилнө.	
32.7.Түр хороог зургаан сар хүртэл хугацаагаар байгуулна. Шаардлагатай бол мөн хугацаагаар нэг удаа сунгаж болно.	32.7.Түр хороог зургаан сар хүртэл хугацаагаар байгуулна. Шаардлагатай бол мөн хугацаагаар нэг удаа сунгаж болох бөгөөд хянан шалгах түр хорооны ажиллах хугацаанд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрх дуусгавар болсон бол түр хороог татан буугдсанд тооцно.
32.8.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28.5-д заасан үндэслэлээр түр__хороог байгуулахгүй.	32.8.Түр хороог дараах тохиолдолд байгуулахгүй: 32.8.1.Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусахад зургаан сараас бага хугацаа үлдсэн бол; 32.8.2.тухайн асуудлаар хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол;

	32.8.3.яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбогдсон асуудлаар; 32.8.4.татан буугдсанд тооцсоноос хойш нэг жилийн хугацаа өнгөрөөгүй бол.
32.9.Түр хороо нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг энэ хуулийн 34.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар хянан шалгаж, дүнг тогтоосон хугацаанд Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй.	32.9.Түр хороо нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг энэ хуулийн 34.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар хянан шалгаж, дүнг тогтоосон хугацаанд Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй.
32.10.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хянан шалгах түр хороог татан буугдсанд тооцно.	32.10.Хянан шалгах түр хороо шалгалтаар цуглуулсан нотлох баримтад үндэслэсэн тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах бөгөөд тайлангаа танилцуулснаар уг хороог татан буугдсанд тооцно.
32.11.Түр хороо /цаашид энэ бүлэгт “түр хороо” гэх/-ны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах Улсын Их Хурлын эрх хэмжээний хүрээнд байна. Түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно.	32.11.Түр хорооны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах Улсын Их Хурлын эрх хэмжээний хүрээнд байна. Түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно.
	32.12.Тухайн ээлжит чуулганы хугацаанд хоёр хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах түр хороо байгуулах саналыг дараагийн ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлсэн дарааллаар хэлэлцэнэ.
	32.13.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй.
<b>33 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн</b>	<b>33 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн</b>
33.4.Гишүүн тусгай шалгалттай холбоотой асуудлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол уг гишүүнийг түр хорооны бүрэлдэхүүнд оруулахыг хориглоно.	33.4.Түр хорооны бүрэлдэхүүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчилгүй гишүүн орно.
33.5.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.1, 10.2-т заасан олонх, 10.3-т заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 33.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах, тусгай шалгалттай холбоотой асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн нэрийг өөрөө тогтоож, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүйгээр хэлэлцэнэ.	33.5.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.1, 10.2-т заасан олонх, 10.3-т заасан цөөнхийн төлөөлөл энэ хуулийн 33.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах, тусгай шалгалттай холбоотой асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийнхээ нэрийг холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.
33.8.Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.	33.8.Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг, уг гишүүн өөрөө татгалзвал түр хорооны бусад гишүүдийн дотроос хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.

<i>/Энэ хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i>	
<b>34 дүгээр зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэн эрх</b>	<b>34 дүгээр зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэн эрх</b>
<p>34.1.Түр хороо нь Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>34.1.1.нотлох баримтыг дараах аргаар цуглуулна:</p> <p>34.1.1.а.нотлох баримтыг нийтийн сонсголоор шинжлэн судалж, үнэлэх;</p> <p>34.1.1.б.төрийн байгууллагаас нотлох баримт гаргуулж авах;</p> <p>34.1.1.в.нотлох баримт гаргаж өгөх тухай хүсэлт гаргах;</p> <p>34.1.1.г.нотлох баримт гаргаж өгөхийг хүн, хуулийн этгээдээс шаардах;</p> <p>34.1.1.д.гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг авах, асуулт тавих;</p> <p>34.1.1.е.шинжээч томилох, тайлбар, мэдүүлэг авах;</p> <p>34.1.1.ё.нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэх.</p> <p>34.1.2.хянан шалгагч томилох;</p> <p>34.1.3.баримт бичигт дүн шинжилгээ хийх;</p> <p>34.1.4.тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах;</p> <p>34.1.5.энэ хуульд заасныг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдэд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд холбогдох саналаа хүргүүлэх;</p> <p>34.1.6.хуульд заасан бусад.</p>	<p>34.1.Түр хороо нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.3, 22.3.6, 22.3.8-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>34.1.1.доор дурдсан аргаар нотлох баримт цуглуулах:</p> <p>34.1.1.а.нотлох баримтыг сонсголоор шинжлэн судалж, үнэлэх;</p> <p>34.1.1.б.төрийн байгууллагаас нотлох баримт гаргуулж авах;</p> <p>34.1.1.в.нотлох баримт гаргаж өгөх тухай хүсэлт гаргах;</p> <p>34.1.1.г.нотлох баримт гаргаж өгөхийг хүн, хуулийн этгээдээс шаардах;</p> <p>34.1.1.д.гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах, асуулт тавих;</p> <p>34.1.1.ё.нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэх.</p> <p>34.1.2.хянан шалгагч шинжээч томилох, тайлбар, мэдүүлэг авах;</p> <p>34.1.3.баримт бичигт дүн шинжилгээ хийх;</p> <p>34.1.4.тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах;</p> <p>34.1.5.энэ хуульд заасныг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдэд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд холбогдох саналаа хүргүүлэх.</p>
<b>35 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт</b>	<b>35 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт</b>
<p>35.4.Түр хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Түр хороо зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой асуудлаар тогтоол батална.</p>	<p>35.4.Түр хороо нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын тов, дараалал, сэдэв, хөтөлбөр батлах, түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг батлах, түр хорооны төсөв батлах, түр хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, ажлын удирдамж батлах зэрэг зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой асуудлаар тогтоол батална.</p>
<p>35.7.Түр хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>35.7.1.түр хорооны үйл ажиллагааг зохион байгуулах, уялдуулан зохицуулах;</p> <p>35.7.2.түр хорооны хуралдаан, сонсголыг даргалах, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах;</p> <p>35.7.3.түр хорооны хуралдаан, сонсголын бэлтгэлийг хангуулах, шийдвэрийг баталгаажуулах, түүний биелэлтэд хяналт тавих;</p> <p>35.7.4.түр хорооноос эрх олгосны дагуу нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд нэмж дуудах гэрчийн нэрсийг сонсголд болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө шийдвэрлэх;</p> <p>35.7.5.түр хороог төлөөлөх;</p> <p>35.7.6.энэ хуульд заасан бусад үүрэг.</p>	<p>35.7.Түр хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>35.7.1.түр хорооны үйл ажиллагааг зохион байгуулах, уялдуулан зохицуулах;</p> <p>35.7.2.түр хорооны хуралдаан, сонсголыг даргалах, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах;</p> <p>35.7.3.түр хорооны хуралдаан, сонсголын бэлтгэлийг хангуулах, шийдвэрийг баталгаажуулах, түүний биелэлтэд хяналт тавих;</p> <p>35.7.5.түр хороог төлөөлж холбогдох байгууллага, албан тушаалтантай харилцах.</p>
	<p>35.8.Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах, шинжээч, хянан шалгагчаар томилогдсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн</p>

маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Түр хороо байгуулах, мандатыг тогтоох (§32).** Олон улсын парламентын практикт хянан шалгах, мөрдөн шалгах, эсхүл тусгай хороог парламентын шийдвэрээр байгуулж, уг шийдвэрт шалгах асуудал, хамрах хүрээ, ажиллах хугацаа, тайлагнах журмыг тусгадаг. Тухайлбал, Эстонийн Рийгикогу тусгай хороо, мөрдөн шалгах хороо, судалгааны хороог тогтоолоор байгуулж, бүрэлдэхүүн, чиг үүрэг, бүрэн эрхийн хугацааг нь тогтоож өгдөг. ХБНГУ-д Бундестаг нийт гишүүдийн 1/4-ийн саналаар мөрдөн шалгах хороо байгуулах зохицуулалттай. Энэ нь түр хороог ерөнхий хэлбэрээр бус, шалгах асуудал, хүрээ хязгаар, хугацаа, байгуулах үндэслэл бүхий тодорхой мандатаар байгуулдгийг харуулж байна.

**Түр хорооны бүрэлдэхүүн, төлөөлөл, ашиг сонирхлын зөрчил (§33, §32.13).** Хянан шалгах буюу мөрдөн шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг улс төрийн төлөөллийн тэнцвэр, сөрөг хүчний оролцоо, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагатай уялдуулан тогтоодог. Тухайлбал, Франц, Өмнөд Африк, Сингапур, Солонгост хорооны бүрэлдэхүүнд намын харьцаа, сөрөг хүчний төлөөлөл, гишүүдийн оролцооны тэнцвэрийг харгалздаг зохицуулалттай байна. Энэ нь түр хорооны шалгалтыг төлөөллийн тэнцвэр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах хэлбэр юм.

**Түр хорооны дотоод зохион байгуулалтын хүрээ (§35).** Түр буюу мөрдөн шалгах хороо нь парламентын шийдвэрээр тогтоосон мандатын хүрээнд хуралдаан, ажлын зохион байгуулалт, шинжээч, хянан шалгагчийн оролцоо, тайлагнах ажиллагаагаа тодорхой журмаар хэрэгжүүлдэг. ХБНГУ-д мөрдөн шалгах хороо хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг урьдчилан тогтоож ажилладаг бол Солонгост хяналт, шалгалтын төлөвлөгөөнд зорилго, хамрах хүрээ, хугацаа, шаардагдах төсвийг тусгадаг. Эдгээр зохицуулалт нь түр хорооны үйл ажиллагааг мандат, хугацаа, бүрэлдэхүүн, дотоод зохион байгуулалттай холбон хэрэгжүүлдэг хэлбэр юм.

### 2.7.2.Нотлох баримт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
Хоёрдугаар дэд бүлэг Нотлох баримт	Хоёрдугаар дэд бүлэг Нотлох баримт
<b>36 дугаар зүйл.Нотлох баримт</b>	<b>36 дугаар зүйл.Нотлох баримт</b>
36.2.“Баримтат мэдээлэл”-д гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, хянан шалгагчийн тайлан, дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, холбогдох байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт мэдээлэл, баримт бичиг, бичгийн хэлбэртэй бусад баримт, хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, хэрэв тухайн асуудлаар өмнө нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулсан бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, энэ хуульд заасны дагуу цуглуулсан бусад баримт хамаарна.	36.2.“Баримтат мэдээлэл”-д гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, хянан шалгагчийн тайлан, дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, холбогдох байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт мэдээлэл, цахим мэдээллийн сангийн баталгаажсан лавлагаа, баримт бичиг, бичгийн хэлбэртэй бусад баримт, хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, хэрэв тухайн асуудлаар өмнө нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулсан бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны бусад баримт хамаарна.

	тэмдэглэл, энэ хуульд заасны дагуу цуглуулсан бусад баримт хамаарна.
<b>37 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны шийдвэр</b>	<b>37 дугаар зүйл.Нотлох баримт цуглуулахтай холбоотой түр хорооны шийдвэр</b>
<b>38 дугаар зүйл.Гэрчээр дуудах</b>	<b>38 дугаар зүйл.Гэрчээр дуудах</b>
38.1.“Гэрч” гэж тусгай шалгах асуудал, үйл баримтыг нягтлан тодруулахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ.	38.1.“Гэрч” гэж тусгай шалгах асуудал, үйл баримтыг нягтлан тодруулахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ.
38.4.Түр хороо гэрчээр дуудах тухай мэдэгдэх хуудсыг гэрчид сонсгол эхлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хүргүүлэх үүрэгтэй. Гэрчээр дуудах тухай мэдэгдэлд тусгай шалгалтын сэдэв, мэдүүлэг авах асуудал, сонсгол болох он, сар, өдөр, цаг, минут, газар, эрх зүйн туслалцаа авах болон бусад эрх, үүрэг, мэдүүлэг өгөөгүй буюу зайлсхийсний улмаас үүсэх үр дагаврын талаар тусгана.	38.4.Түр хороо гэрчээр дуудах тухай мэдэгдэх хуудсыг гэрчид сонсгол эхлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хүргүүлэх үүрэгтэй. Гэрчээр дуудах тухай мэдэгдэлд тусгай шалгалтын сэдэв, тухайн гэрчид шууд холбогдох асуудал, сонсгол болох он, сар, өдөр, цаг, минут, газар, эрх зүйн туслалцаа авах болон бусад эрх, үүрэг, мэдүүлэг өгөөгүй буюу зайлсхийсний улмаас үүсэх үр дагаврын талаар тусгана.
<b>39 дүгээр зүйл.Хянан шалгагчийг томилох</b>	<b>39 дүгээр зүйл.Хянан шалгагчийг томилох</b>
39.1.Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хянан шалгагчийг томилж, ажлын даалгаврыг батална.	39.1.Түр хорооны гишүүдийн саналыг харгалзан хянан шалгагчийг нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилж, ажлын даалгаврыг батална. Хянан шалгагч түр хороо татан буугдах хүртэл ажлын даалгаварт заасан үүргээ биелүүлж ажиллана. Хянан шалгагчаар ажиллуулах саналыг энэ хуулийн 7.2-д заасан байгууллагаас авч болно.
39.2.Хянан шалгагч сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй, мэргэжлийн дүгнэлт гаргах чадвартай, гурваас доошгүй жил тухайн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан туршлагатай Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна.	39.2.Хянан шалгагч сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй, тухайн асуудлаар мэргэшсэн, мэргэжлийн дүгнэлт гаргах чадвартай, гурваас доошгүй жил тухайн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан туршлагатай Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна.
39.3.Хянан шалгагч энэ хуулийн 39.1-д заасан даалгаврын хүрээнд дараах ажиллагааг хараат бусаар явуулах бүрэн эрхтэй: 39.3.1.шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх; 39.3.2.нотлох баримт гаргаж өгөхийг шаардах; 39.3.3.тухайн асуудалд холбогдох этгээдээс тайлбар авах; 39.3.4.нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэх; 39.3.5.сонсголд оролцох гэрчийн нэрсийг шинжээчтэй хамтран гаргаж, сонсгол болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө түр хороонд танилцуулж, шийдвэрлүүлэх; 39.3.6.баримт бичигт дүн шинжилгээ хийх, тайлан гаргах.	39.3.Хянан шалгагч энэ хуулийн 39.1-д заасан даалгаврын хүрээнд дараах ажиллагааг хараат бусаар явуулах бүрэн эрхтэй: 39.3.1.шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх; 39.3.2.нотлох баримт гаргаж өгөхийг шаардах; 39.3.3.тухайн асуудалд холбогдох этгээдээс тайлбар авах; 39.3.4.нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэх; 39.3.5.сонсголд оролцох гэрчийн нэрсийг тухайн гэрчид шууд холбогдох асуудал бүрээр шинжээчтэй хамтран гаргаж, сонсгол болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө түр хороонд танилцуулж, шийдвэрлүүлэх; 39.3.6.баримт бичигт дүн шинжилгээ хийх; 39.3.7.хяналт шалгалтын дүнгийн тайлан гаргах.
39.6.Хянан шалгагч тусгай шалгалтын дүнд үндэслэн тайланг бичгээр гаргаж, сонсголд амаар танилцуулах бөгөөд уг тайлантай танилцах боломжийг түр хорооны гишүүн бүрд олгоно. Түр хорооноос авч хэрэгжүүлэх арга	39.6.Хянан шалгагч энэ хуулийн 39.3.7-д заасан тайланг бичгээр гаргаж, сонсголд биечлэн оролцож, танилцуулах бөгөөд уг тайлантай танилцах боломжийг түр хорооны гишүүн бүрд олгоно. Түр хорооноос авч хэрэгжүүлэх арга

хэмжээний талаарх зөвлөмжийг тайланд тусгаж болно.	хэмжээний талаарх зөвлөмжийг тайланд тусгаж болно.
39.7.Хянан шалгагч энэ хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бол түр хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар түүнийг огцруулна.	39.7.Хянан шалгагч энэ хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бол түр хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар түүнийг огцруулж, энэ хуулийн 7.6-д зааснаар байгуулсан гэрээний хариуцлага хүлээлгэнэ.
39.10.Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах, шинжээч, хянан шалгагчаар томилогдсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт, түүнийг бүртгэх, хянан шалгах, хадгалах, сонгох журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.	
	39.11.Хяналт шалгагч энэ хуулийн 39.3-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, нотлох баримтыг бүрүүлэх, үнэлэхэд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг жишиг болгоно.
<b>40 дүгээр зүйл.Шинжээч томилох</b>	<b>40 дүгээр зүйл.Шинжээч томилох</b>
40.1.Түр хороо тусгай шалгалтын явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлаар дүгнэлт гаргуулахаар уг асуудлаар мэргэшсэн, хувийн ашиг сонирхлын зөрчилгүй хувь хүн болон төрийн албан хаагчийг шинжээчээр томилох бөгөөд дүгнэлт гаргах хугацааг тухайн шинжээчтэй тохиролцон тогтоож, ажлын даалгаврыг батална.	40.1.Түр хороо хянан шалгагчийн санал болгосноор тусгай мэргэжлийн шинжээч томилон ажиллуулж, дүгнэлт гаргуулж болно.
40.2.Шинжээч тогтоосон хугацааны дотор тухайн асуудлыг тал бүрээс нь бүрэн, бодитой, хараат бусаар шинжилж, үнэн зөв дүгнэлтийг бичгээр гаргах бөгөөд түр хороо хүсэлт тавибал сонсголд биечлэн оролцож амаар мэдүүлэг өгнө.	40.2.Шинжээч тогтоосон хугацааны дотор тухайн асуудлыг тал бүрээс нь бүрэн, бодитой, хараат бусаар шинжилж, тавьсан асуулт нэг бүрээр үнэн зөв дүгнэлтийг бичгээр гаргах бөгөөд Түр хороо хүсэлт тавибал сонсголд биечлэн оролцож амаар мэдүүлэг өгнө.
40.3.Шинжээч энэ хуулийн 38.8-д заасан үндэслэлээр дүгнэлт гаргахаас татгалзаж болно.	
40.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол шинжээчийг дуудан ирүүлэх болон холбогдох бусад харилцаанд энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмыг баримтална.	
40.5.Шинжээч түр хорооны өмнө ажлаа хариуцах бөгөөд олон нийтэд зориулсан мэдээлэл хийхгүй. Шинжээчид энэ хуулийн 39.8, 39.9, 39.10 дахь заалт нэгэн адил хамаарна.	40.5.Шинжээч түр хорооны өмнө ажлаа хариуцах бөгөөд олон нийтэд зориулсан мэдээлэл хийхгүй. Шинжээчид энэ хуулийн 35.8, 39.8, 39.9 дахь заалт нэгэн адил хамаарна.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Нотлох баримтын хүрээ, баримтат мэдээлэл (§36).** Олон улсын парламентын практикт хянан шалгах, мөрдөн шалгах ажиллагааны нотлох баримтыг аман болон бичгээр мэдээлэл, баримт бичиг, тайлан, дүрс бичлэг, цахим мэдээлэл зэрэг ач холбогдолтой баримтат мэдээллийг өргөн хүрээнд авч үздэг. Австралийн Төлөөлөгчдийн Танхимын дэгт “нотлох баримт”-д гэрч, эсхүл асуулгад оролцогчоос танхим, хороонд өгсөн аман болон бичгийн мэдээллийг хамааруулдаг. Солонгост парламентын хяналт, шалгалтын хүрээнд тайлан, баримт бичиг, зураг, дүрс бичлэг зэргийг гаргуулах зохицуулалттай.

**Нотлох баримт гаргуулах, гэрч оролцуулах ажиллагаа (§37-§38).** Хянан шалгах буюу мөрдөн шалгах хороо нь шалгалтын хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс баримт, мэдээлэл гаргуулах, гэрч дуудах,

мэдүүлэг авах эрхтэй байдаг. Тухайлбал, Солонгост хороо нь хяналт, шалгалттай холбоотой тайлан, баримт бичиг гаргуулах, гэрч, шинжээч оролцуулах, гэрчийн мэдүүлэг авахаар зохицуулсан байна.

**Шинжээч, хянан шалгагчийн оролцоо (§39-§40).** Тусгай мэдлэг шаардсан асуудлаар хянан шалгах хороо шинжээч, мэргэжилтэн, хянан шалгагч оролцуулж, дүгнэлт, тайлан гаргуулах зохицуулалт олон улсад байдаг. Солонгост Үндэсний Ассамблейн зохицуулалтаар хороо нь шалгалтын ажиллагаанд шинжээч оролцуулах боломжтой бол АНУ-ын Конгрессын практикт хороод мэргэжлийн ажилтан, шинжээчийн туслалцаанд тулгуурлан баримт, мэдээллийг боловсруулдаг.

### 2.7.3.Хянан шалгах түр хорооны сонсгол

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
Гуравдугаар дэд бүлэг Хяналт шалгалтын түр хорооны сонсгол	Гуравдугаар дэд бүлэг Хянан шалгах түр хорооны сонсгол
<b>44 дүгээр зүйл.Нотлох баримтыг сонсох</b>	<b>44 дүгээр зүйл.Нотлох баримтыг сонсох</b>
44.3.Нотлох баримтыг сонсох ажиллагаанд энэ хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хяналтын сонсгол зохион байгуулах журмыг баримтална.	44.3.Нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол /цаашид “сонсгол” гэх/-д дараах журмыг баримтална: 44.3.1.сонсголыг дараах дарааллын дагуу явуулна: 44.3.1.а.сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах; 44.3.1.б.энэ хуулийн 39.3.6-д заасан хянан шалгагчийн дүн шинжилгээ, тайланг сонсох; 44.3.1.в.шинжээчийн дүгнэлтийг сонсох; 44.3.1.г.эрх ашиг нь хөндөгдөж буй, иргэн хуулийн этгээд, эсхүл холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны мэдээлэл сонсох; 44.3.1.д.даргалагч шаардлагатай гэж үзсэн бол хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэвтэй холбогдуулан бичгээр ирүүлсэн мэдээллийн агуулгыг уншиж танилцуулах; 44.3.1.е.даргалагч болон гишүүд сонсголд хянан шалгагч, шинжээч, гэрчээс асуулт асууж, хариулт авах. 44.3.2.Сонсголын явцад сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахыг хориглоно. 44.3.3.Энэ хуулийн 44.3.1.б, 44.3.1.в, 44.3.1.г-д заасан дүн шинжилгээ, тайлан, дүгнэлт, мэдээллийг тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд танилцуулна. 44.3.4.Гэрчээс асуулт асуух, хариулт авах хугацаа 30 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно. Гишүүний асуулт, гэрчийн хариултын хугацааг тэнцвэртэй хуваарилна. 44.3.5.Даргалагч гэрчид энэ хуульд заасан эрхийг танилцуулж, асуултад хариулах боломжоор хангана. 44.3.6.Сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулахтай холбоотой бусад харилцаанд

	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан холбогдох журмыг баримтална.
<b>47 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах, дэг сахиулах</b>	<b>47 дугаар зүйл.Сонсголд оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах, дэг сахиулах</b>
47.3.Сонсгол даргалагч сонсголын дэг сахиулах бөгөөд дэг зөрчигчид сануулах, танхимаас гаргана.	47.3.Сонсгол даргалагч сонсголын дэг сахиулах бөгөөд дэг зөрчигчид сануулах, үг, үйлдлийг таслан зогсоох, шаардлагатай гэж үзвэл танхимаас гаргана.
	47.4.Сонсголд гэрчээр дуудагдсан этгээдэд асуултад бүрэн хариулж, тайлбар өгөх эрхтэй.
<b>49 дүгээр зүйл.Гэрчийн мэдүүлэг сонсох</b>	<b>49 дүгээр зүйл.Гэрчийн мэдүүлэг сонсох</b>
	49.7.Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын үеэр гэрчийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахыг хориглоно.
49.7.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэрчээс мэдүүлэг авахтай холбогдсон бусад харилцаанд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг жишиг болгоно.	49.8.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэрчээс мэдүүлэг авахтай холбогдсон бусад харилцаанд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг жишиг болгоно.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын журам (§44.3).** Олон улсын парламентын практикт хянан шалгах буюу мөрдөн шалгах хорооны сонсгол нь баримт, мэдээлэл, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн тайлбарыг тодорхой дарааллын дагуу сонсож, шинжлэн хэлэлцэх ажиллагаа байна. Австрали, Их Британи, Норвеги зэрэг улсад парламентын хороод сонсголын өмнө хэлэлцэх асуудал, гэрч, баримт бичиг, сонсголын дарааллыг тогтоож, сонсголын явцад нотлох баримтыг танилцуулах, гэрчээс асуулт асуух, хариулт авах, шаардлагатай хэсгийг хаалттай явуулах журмыг хэрэглэдэг. Эдгээр нь сонсголыг ердийн мэдээлэл сонсох хэлбэрээр бус, нотлох баримтыг тодорхой дараалалтай шинжлэн судлах процедурын зохицуулалт юм.

**Оролцогчийн эрх, асуулт-хариултын ажиллагаа (§47.3-47.4).** Сонсголд гэрч, шинжээч, холбогдох албан тушаалтан, бусад оролцогчийг оролцуулж, хорооны гишүүдээс асуулт тавих, хариулт авах, тайлбар сонсох ажиллагааг сонсголын үндсэн хэсэг болгон хэрэглэдэг. Их Британи, Норвеги, Солонгост парламентын хорооны сонсголд гэрч, шинжээч, холбогдох этгээдээс асуулт асуух, хариулт авах, шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар авах зохицуулалттай. Энэ нь нотлох баримтыг сонсголоор шинжлэн судлах ажиллагааг оролцогчийн тайлбар, асуулт-хариулт, хариу өгөх боломжоор хангадаг процедурын хэлбэр юм.

**Гэрчийн мэдүүлэг, нэр төр, мэдээллийн хамгаалалт (§49).** Олон улсын жишгээр гэрчийн мэдүүлэг сонсохдоо мэдүүлгийн үнэн зөв байдал, мэдээллийн нууцлал, гэрчийн эрх, нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах шаардлагыг хамтатган зохицуулдаг. Норвеги, Солонгос зэрэг улсад сонсголын зарим хэсгийг хаалттай явуулах, гэрчийн мэдээллийг хамгаалах, асуулт-хариултын явцад тухайн асуудалд хамаарахгүй хувийн шинжтэй халдлагаас зайлсхийх зохицуулалттай.

Энэ нь хянан шалгах сонсголын нээлттэй байдлыг гэрч, оролцогчийн эрх, нэр төр, хамгаалагдах мэдээллийн шаардлагатай тэнцвэржүүлдэг хэлбэр юм.

## 2.7.4.Хянан шалгах түр хорооны тайлан, зардал

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗААЛТ	ТӨСЛИЙН ЗААЛТ
<b>Дөрөвдүгээр дэд бүлэг</b> <b>Хянан шалгах түр хорооны хуралдаан,</b> <b>тайлан, санал, дүгнэлт, зардал</b>	<b>Дөрөвдүгээр дэд бүлэг</b> <b>Хянан шалгах түр хорооны хуралдаан,</b> <b>тайлан, санал, дүгнэлт, зардал</b>
<b>55 дугаар зүйл.Түр хорооны тайлан</b>	<b>55 дугаар зүйл.Түр хорооны тайлан</b>
55.1.Түр хороо нь сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн гаргасан сонсголын тайлан, санал, дүгнэлт, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд танилцуулна.	55.1.Түр хороо нь сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн гаргасан сонсголын тайлан, санал, дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг боловсруулна. Хэрэв түр хороо шийдвэрийн төсөл боловсруулсан бол холбогдох Байнгын хороогоор уг Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж санал, дүгнэлт гаргуулна.
55.2.Тайланд тусгай шалгах ажиллагааны агуулга, цуглуулсан нотлох баримт, тогтоогдсон үйл баримт, тусгай шалгалтын дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл холбогдох саналыг багтаана.	55.2.Нэгдсэн хуралдаанд түр хороо энэ хуулийн 55.1-д заасан тайлан, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг, холбогдох Байнгын хороо түр хорооны тогтоолын төслийн талаарх санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна. Тайланд тусгай шалгах ажиллагааны агуулга, тогтоогдсон үйл баримт, тусгай шалгалтын дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл холбогдох тайлбар, мэдээлэл, саналыг багтаана.
55.7.Түр хорооны тайланг эцэслэснээс хойш 14 хоногийн дотор тусгай санал, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, бичмэл нотлох баримтын хамт мэдээллийн нэгдсэн санд байршуулна.	55.7.Түр хорооны тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулснаас хойш 14 хоногийн дотор мэдээллийн нэгдсэн санд байршуулна.
<b>56 дугаар зүйл.Түр хорооны зардал</b>	<b>56 дугаар зүйл.Түр хорооны зардал</b>
56.1.Түр хорооны тусгай шалгах үйл ажиллагаатай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	56.1.Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусган санхүүжүүлнэ.
56.2.Шинжээч, хянан шалгагчийн ажлын хөлс, гэрч дуудах болон тусгай шалгалттай холбоотой бусад зардлын хэмжээг батлагдсан төсөвт багтаан түр хороо тогтооно.	56.2.Түр хорооны зардлын төсвийг Улсын Их Хурлын батлагдсан төсөвт багтаан түр хороо төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.
	56.3.Улсын Их Хурлын төсвийн шууд захирагч батлагдсан төсөвтөө багтаан хянан шалгах түр хорооны даргын саналыг харгалзан хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулна.

### ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА:

**Түр хорооны тайлан, санал-дүгнэлт ба парламентын хэлэлцүүлэг (§55.1-55.3).** Олон улсад хянан шалгах буюу мөрдөн шалгах хороо цуглуулсан нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, холбогдох бусад мэдээлэлд үндэслэн тайлан гаргаж, түүнийг парламентын дарга, нэгдсэн хуралдаан, эсхүл холбогдох хороонд танилцуулдаг. Солонгост хяналт, шалгалт явуулсан хороо үр дүнгийн тайлангаа Үндэсний Ассамблейн даргад хүргүүлж, уг тайланг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг. Эстонид хянан шалгах хороо тайлангаа мөн Рийгикогууд танилцуулдаг бол ХБНГУ-д мөрдөн шалгах хороо шалгалтын явц, тогтоогдсон баримт, дүгнэлтээ тайландаа тусгадаг.

Эдгээр зохицуулалт нь түр хорооны тайланг зөвхөн мэдээллийн баримт бичиг бус, парламентын хэлэлцүүлэг, санал-дүгнэлт, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах үндэслэл болгодог.

**Цөөнхийн санал (§55.4).** Зарим пардаметад хянан шалгах хорооны тайланд цөөнхийн санал, тусгай санал, нэмэлт тайлбарыг хавсаргах зохицуулалттай. ХБНГУ-д мөрдөн шалгах хорооны тайлангийн дүгнэлттэй санал нийлээгүй цөөнх нь өөрийн байр сууриа хавсаргах боломжтой байгаа нь шалгалтын дүнг олонхын дүгнэлтээр хязгаарлахгүйг харуулж байна.

**Түр хорооны зардал (§56).** Түр хороо, мөрдөн шалгах хорооны үйл ажиллагаанд шаардагдах шинжээч, хянан шалгагч, гэрч дуудах, мэдээлэл цуглуулах, хуралдаан зохион байгуулах зэрэг зардлыг парламентын батлагдсан төсөв, дотоод журам, санхүүгийн хяналтын хүрээнд зохицуулдаг. Тухайлбал, Солонгост хяналт, шалгалтын төлөвлөгөөнд шалгалтын зорилго, хамрах хүрээ, хугацаанаас гадна шаардагдах төсвийг тусгахаар зохицуулсан нь шалгалтын ажиллагааг парламентын батлагдсан төсөв, дотоод санхүүгийн журам, зардлын хяналттай холбон хэрэгжүүлдэг хэлбэр юм.



## 2.8. Ашигласан эх сурвалж

### 1) Эрх зүйн баримт бичгүүд:

- Австрали: (2025). House of Representatives Standing and Sessional Orders, §231. Хандах: [https://www.aph.gov.au/-/media/05\\_About\\_Parliament/53\\_HoR/532\\_PPP/Standing\\_Orders/SOs\\_as\\_at\\_23\\_July\\_2025.pdf](https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf)
- Америк: (2025). Rules of the House of Representatives 119th Congress. Хандах: <https://www.govinfo.gov/content/pkg/CDOC-118hdoc187/pdf/CDOC-118hdoc187.pdf>
- Итали: (2025). Rules of Procedure of the Chamber of Deputies. Хандах: [https://en.camera.it/application/xmanager/projects/camera\\_eng/file/Regolamento\\_ENG.pdf](https://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/Regolamento_ENG.pdf)
- Их Британи: (2012). Standing Orders. Хандах: <https://publications.parliament.uk/pa/cm201213/cmstords/614/body.htm>
- Канад: (2025). Standing Orders of the House of Commons, §110, §111. Хандах: <https://www.ourcommons.ca/procedure/standing-orders/index-e.html>
- Норвег: (2024). Parliament Rules of Procedure. Хандах: [https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure\\_2024.pdf](https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf)
- Өмнөд Африк: (2016). Rules of the National Assembly (9th Edition). Хандах: [https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28\\_NA\\_RULES.pdf](https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf)
- Сингапур: (2017). Standing Order. Хандах: <https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/standing-orders-of-the-parliament-of-singapore.pdf>
- Солонгос: (2020). National Assembly Act. Хандах: [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=55306&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG)
- Солонгос: (2012). Act on the Inspection and Investigation of State Administration. Хандах: [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?lang=ENG&hseq=28070](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=28070)
- Франц: (2025). Règlement de l'Assemblée Nationale. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>
- Франц: (1958) Ordonnance n° 58-1100 du 17 novembre 1958 relative au fonctionnement des assemblées parlementaires. Хандах: <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000000705067>
- Швейцар: (2002). Federal Act on the Federal Assembly. Хандах: <https://www.parlament.ch/centers/documents/en/parlamentsgesetz-e.pdf>
- Шинэ Зеланд: (2023). Standing Order. Хандах: <https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>
- Эстони: (2003) Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act. Хандах: <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

### 2) УИХ-ын Тамгын газрын эмхэтгэл:

- УИХ-ын Тамгын газар. (2023). Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл (Герман, Франц, Солонгос, Орос, Австрали, Канад, Финланд, Швейцар, Македон, Япон).

### 3) ПСХХ-ийн судалгаанууд:

- БНСУ-ын Үндэсний Ассамблейн хяналт, шалгалт ба томилгооны сонсгол болон АНУ-ын Конгрессын нийтийн сонсголын талаарх эрх зүйн зохицуулалт (СТ-22/410).
- Гадаадын зарим орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилт, хяналтыг хангах тогтолцоо (СТ-16/205).
- Гадаадын зээл тусламжийн эрх зүйн зохицуулалт (СТ-25/261).
- Парламентаас баталсан хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт (СТ-25/229).
- Парламентаас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам ба эрх зүйн орчны харьцуулсан судалгаа (СТ-21/240).
- Парламентын төсөв санхүүгийн хяналт, олон улсын туршлага харьцуулсан судалгаа (СТ-21/246).
- Парламентын хяналт шалгалтын тогтолцоо ба эрх зүйн зохицуулалт (СТ-21/208).
- Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга бат, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах механизм: бусад орнуудын туршлага (СТ-23/404).
- Төсвийн үйл явц дахь парламентын хяналт (СТ-26/408).
- Төсвийн хяналтын талаарх олон улсын туршлага (СТ-24/217).
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан байгууллагыг үндсэн хуулиар хуульчилсан байдал (СТ-19/421).

### 4) Бусад:

- Бразил: (2006). The Brazilian Legislative Branch: Chamber of Deputies. Хандах: [https://www2.camara.leg.br/english/CD\\_English.pdf](https://www2.camara.leg.br/english/CD_English.pdf)
- German Bundestag. (n.d.). Instruments of scrutiny. Хандах: [https://www.bundestag.de/en/parliament/function/scrutiny/instruments\\_scrutiny-245710](https://www.bundestag.de/en/parliament/function/scrutiny/instruments_scrutiny-245710)

## 2.9. Парламентаас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын талаарх: бусад орнуудын туршлага

### СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Түүхэн талаас нь авч үзвэл, орчин үеийн үнэлгээний салбар шинжлэх ухаан нь аргад суурилсан нийгмийн ухааны судалгаанаас үүсэлтэй бөгөөд XVII зууны үеэс байгалийн шинжлэх ухааны хөгжил болон юмс үзэгдлийг ажиглахад онцгойлон анхаарч байсантай холбоотой гэж үздэг. Харин хууль, хөтөлбөрийн үнэлгээг 1960-аад оны эцсээр Баруун Европын олон оронд хийж эхэлсэн боловч анхны оролдлогууд нь мэдэгдэхүйц үр дүнд хүрээгүй байна.<sup>1</sup>

**Шигтгээ 1.** ХБНГУ-ын Бундестаг нийгэм, эдийн засгийн янз бүрийн хөтөлбөр, мөн татварын бодлогын хэрэгжилт, үр нөлөөний талаар тайлан гаргаж өгч байхыг Холбооны Засгийн газраас шаардаж эхэлсэн байна. Үүнд, Хөдөлмөрийн зах зээл ба хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль /1969/, Ерөнхий боловсролын тэтгэмжийн тухай хууль /1969/, Бүс нутгийн эдийн засгийн бүтцийг сайжруулах тухай Холбоо ба мужуудын хамтарсан хөтөлбөр /1970/, Эмнэлэгт хөрөнгө оруулалтын хөтөлбөр /1971/, Татаас ба татварын төрөлжсөн тайлангууд /1999/ гэх мэт.

Манай улсын хувьд 1996 оноос хойш гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлсэн бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийх асуудлыг 2015 оноос эрчимтэй ярьж, сүүлийн жилүүдэд харьцангуй хурдацтай хөгжүүлж байна. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хууль батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, процедурыг тодорхой болгосон бөгөөд хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, тухайн харилцааг заавал хуулиар зохицуулах шаардлагатай эсэхийг судлан шинжлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах үүднээс хууль хэрэгжих боломж нөхцөл, түүнтэй холбоотой гарах зардал, хуулийн хэрэгжилтээс үүдэн гарах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр нөлөөг урьдчилан сайтар судалсан байх шаардлага болон хуулийн хэрэгжилт, түүний үр дагаварт хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалтыг хуульд тодорхой тусгасан.

Энэ хууль батлагдсанаар Улсын Их Хурал, Засгийн газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 болон 6 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Одоогоор хууль тогтоомжийн хэрэгжилтэд дээрх тогтоолоор баталсан аргачлалын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байгаа ба бодлогын баримт бичиг болон хөтөлбөрийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, түүний хэрэгжилтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хэрэгжилтээс үүдэн гарч буй эерэг,

<sup>1</sup> “Үр дүнд хүрэх зам-Хөгжлийн үнэлгээг үр дүнтэй удирдан явуулах нь” Линда Г.Морра Имас, Рей С.Рист 2011 он 18 дах тал

сөрөг үр дагаврыг судлан шинжилж, үнэлгээ дүгнэлт гаргах нь парламентын хянан шалгах үйл ажиллагааны үндсэн хэлбэрүүдийн нэг болох тул энэхүү судалгааны явцад Парламентаас хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг нарийвчлан судлахаар зорьсон болно.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, парламентаас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тусгайлсан арга зүй байхгүй байгаа бөгөөд ихэнх улсын хувьд судалгааны нийтлэг арга зүй, арга, аргачлалыг ашиглан хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж байна.

Гэвч хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал хоорондын харилцааны онцлог, засаглалын тэнцвэрт байдлыг хадгалах зарчим талаас нь авч үзвэл парламентын хяналтын тогтолцоо, түүнийг хэрэгжүүлэх арга механизм Засгийн газраас хараат бус, аль болох олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналтад тулгуурлан явагдаж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Улс орон бүр өөрийн орны онцлог, төсөв санхүүгийн чадамждаа тулгуурлан парламентын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхаа сайжруулах, тухайн асуудлыг хариуцсан чиг үүргийн нэгж, албадыг байгуулах, хөндлөнгийн эх сурвалж, оролцоог бий болгох тал дээр анхаарч байгаа нь харагдаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх парламентын зорилго нь батлан гаргасан хууль тогтоомжууд нь үзэл баримтлал, зохицуулалтынхаа хүрээнд чиглэсэн зорилгодоо нийцсэн байдлаар хэрэгжиж байгаа эсэх, хэрэв хэрэгжилт нь хангалтгүй байгаа тохиолдолд яагаад гэдгийг тодруулан цаашид хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр парламентаас ямар арга хэмжээ авахыг тодорхойлох, Засгийн газарт тодорхой үүрэг, чиглэл өгч, шахаж шаардаж ажиллахад чиглэгддэг байна.<sup>2</sup>

Швейцар Улс 1999 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөрөө Үндсэн хуулийн түвшинд үнэлгээний заалтыг нэвтрүүлсэн дэлхийн анхны улс бөгөөд Франц (2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Францын Үндсэн хуулийн 24-р зүйл) болон Швед (2011 оны 01-р сарын 01-ний хүчин төгөлдөр болсон Засгийн газрын 4-р бүлгийн 8-р зүйл) тус тус тусгайлсан эрх зүйн зохицуулалтыг бий болгосон туршлага байна.

Гэвч ихэнх орнуудын парламент хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тусгайлсан эрх зүйн зохицуулалтгүй байгаагаас үзэхэд энэхүү ажил нь парламентад өдөр бүр хийгддэг ажил бус, харьцангуй сүүлийн үед анхаарал хандуулж эхэлсэн шинэлэг ажил болох нь харагдаж байна.<sup>3</sup>

Дэлхийн улс орны парламентууд хууль тогтоомж боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагаандаа хүн хүч, санхүүгийн нөөцийнхөө ихээхэн хэсгийг зориулдаг бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах асуудлыг орхигдуулсаар ирсэн нь цөөнгүй.

Хуулийн хэрэгжилт бол тухайн хуулийг хэрэглэгч болон түүний үйлчлэлд хамааралтай бусад этгээдүүдийн оролцоо, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрмэлзэл буюу эрх зүйн соёл, ухамсар, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад журмын зохицуулалт, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих байгууллагуудын хамтын ажиллагаа зэргээс шалтгаалсан нарийн төвөгтэй асуудал юм.

Сүүлийн үед дэлхийн улс орнуудын парламентууд хууль тогтоомжийн хэрэгжилтэд илүү анхаарал хандуулж, үүний тулд тусгайлсан журам боловсруулан

<sup>2</sup> [https://www.researchgate.net/publication/342737680\\_Parliaments\\_in\\_Europe\\_Engaging\\_in\\_Post-legislative\\_Scrutiny](https://www.researchgate.net/publication/342737680_Parliaments_in_Europe_Engaging_in_Post-legislative_Scrutiny)

<sup>3</sup> [https://www.researchgate.net/publication/342737680\\_Parliaments\\_in\\_Europe\\_Engaging\\_in\\_Post-legislative\\_Scrutiny](https://www.researchgate.net/publication/342737680_Parliaments_in_Europe_Engaging_in_Post-legislative_Scrutiny)

мөрдөж эхлээд байна. Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ буюу хууль батлагдсаны дараах хяналт (PLS) нь хоёр хэмжигдэхүүнээс бүрдсэн өргөн хүрээний ойлголт юм. Энэ хүрээнд:

Нэгдүгээрт, тухайн хууль тогтоомж батлагдаж, заалтууд хэрэгжиж эхэлсэн эсэх;

Хоёрдугаарт, хууль тогтоомжийн зохицуулалтын үр нөлөө бий болсон эсэх, зорилтууд нь хангагдаж байгаа эсэх, хэрэгжилтийг сайжруулах боломж байгаа эсэх, ямар сургамж авч, сайн туршлагыг тодорхойлж чадах вэ зэргийг судалдаг.

Хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх болон дараах үр нөлөөний үнэлгээ: Үндэсний засгийн газар, яам\* агентлагууд шинэ хууль тогтоомжийн төсөл боловсруулахад ихээхэн хүчин чармайлт гаргадаг. Олон оронд өмнөх зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ (RIA) нь шинэ хууль тогтоомжийн төслийг бэлтгэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Нэг талаас, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг Засгийн газрын агентлагууд эсвэл гүйцэтгэх засаглалын бусад байгууллагууд хадгалж байдаг. Хууль тогтоомжид үзүүлэх нөлөөллийн үнэлгээнд Статистикийн газар зэрэг байгууллагууд тодорхой тоо баримтыг эмпирик байдлаар олж авахад, Үндэсний аудитын газар нь гүйцэтгэлийн аудитаараа дамжуулан тусалж болдог.

Нөгөө талаас, ихэнх улсын парламентын гишүүд хууль батлагдсаны дараа юу болох талаар бага мэдээлэлтэй байдаг. Тэдний гол анхаарал нь хууль тогтоомжийг батлахад чиглэдэг бөгөөд түүний хэр сайн хэрэгжиж байгаа, эсвэл огт хэрэгжихгүй байгаа эсэхийг шалгах боломж нь хязгаарлагдмал байдаг. Гэсэн хэдий ч парламент нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

Ex-post буюу хууль тогтоомж батлагдсаны дараа хийх үнэлгээг PSL (Post-Legislative Scrutiny) буюу хууль тогтоомж батлагдсаны дараах хяналт гэж хэлдэг. Энэ нь тухайн хууль тогтоомж дэвшүүлсэн зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх, улмаар хууль санаачлагчийн анх төлөвлөж байсан үр дүнг бий болгоход чиглэсэн нөлөөтэй арга механизмыг бий болгох зорилго бүхий үйл ажиллагааны цогц юм.

Их Британийн Лордуудын танхим хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх гурван үндсэн давуу талыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Энэ нь ардчилсан засаглалыг бэхжүүлдэг: Парламентаас баталсан хууль тогтоомжийг хууль дээдлэх, хууль ёсны байх, тодорхой байх зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой.

2. Хууль тогтоомжийн шинэ зохицуулалтын болзошгүй сөрөг үр дагаврыг тодорхойлох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжийг олгодог.

3. Хууль тогтоомж нь зохицуулах гэж буй асуудалд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг тогтмол үнэлэх боломжийг олгодог. Энэ нь хууль тогтоогчид ирээдүйд илүү сайн хууль тогтоомж гаргах, засаж залруулах арга хэмжээ авах хэрэгцээг багасгах үүднээс зорилгодоо хүрэхийн тулд юу болж байгаа, юу нь болохгүй, хэрэгжилт нь хэр үр дүнтэй байгаа талаар туршлага судлах боломжийг олгодог байна.

Европын Холбооны орнуудын парламентаас хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцооны дараах хувилбаруудыг санал болгодог байна. Үүнд:

- а. Хууль батлагдсанаас хойш 3-5 жилийн дараа парламентаас тухайн хуулийн хэрэгжилтийн талаарх тайлан ирүүлэхийг холбогдох Төрийн захиргааны төв байгууллагаас хүсэх;

- b. Парламент нь хөндлөнгийн судалгааны байгууллага болон бие даасан, хараат бус хяналтын байгууллагад хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх захиалга өгч гүйцэтгүүлэх;
- c. Парламент нь хуулийн хэрэгжилтийн талаарх нийтийн сонсгол зохион байгуулах, мөн эрх зүйн дүн шинжилгээний нэгж болон судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээний нэгжээр дамжуулан хуулийн хэрэгжилтийн талаарх судалгааны мэдээлэл цуглуулах боломжтой юм.

Мөн энэхүү судалгаанд хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх сайн туршлага бүхий ХБНГУ, Швейцар зэрэг орнуудын аргачлал, Европын Холбооны орнуудын парламентаас хууль батлагдсаны дараах хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг нийтлэг аргачлал болон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хийх олон улсын нийтлэг аргачлалыг дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн болно. Түүнчлэн зарим орны хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр нэвтрүүлсэн туршлага, практик тогтолцоог энэхүү судалгаанд авч үзсэн болно.

/Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү./

### **2.9.1.Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх онол, арга зүйн асуудал**

#### **Хяналт шинжилгээ, үнэлгээний ойлголт, онол, арга зүйн асуудлууд:**

Хяналт шинжилгээ ба үнэлгээний аль аль нь тухайн нөхцөл байдлыг хэмжиж, үнэлдэг боловч өөр өөрийн гэсэн онцлог талуудтай.

**Хяналт шинжилгээ** /monitoring/ гэдэг нь аливаа үйл явцын талаар мэдээлэл цуглуулж, ажиглалт хийх замаар уг үйл явцыг цаашид зөв чиглүүлэх зорилготой үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл ажиглалтыг тасралтгүй, системтэйгээр явуулах бөгөөд түүний үр дүнд тухайн үйл явц, үйл ажиллагаа нь бодит нөөцийг ашиглаж, тогтоосон цаг хугацаанд зорилгодоо хүрсэн эсэхэд хариулт өгнө. Харин **үнэлгээ** /evaluation/ гэдэг нь хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх болон харьцуулан үнэлэх үйл ажиллагаа юм.

Ажиглаж байгаа үйл явц буюу үйл ажиллагаа нь зорилгодоо хүрэхгүй, эсхүл зорилгоосоо гажих, төлөвлөснөөр хэрэгжихгүй байх тохиолдолд түүнийг чиглүүлэх нь хяналт шинжилгээний зорилго байдаг. Харин үнэлгээ хийх нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдэнэ.

**Өөрөөр хэлбэл, хяналт шинжилгээ нь** бодлогын хэрэгжилтийн гүйцэтгэлийг төлөвлөсөн үр дүнтэй харьцуулж, мэдээллийг тогтмол цуглуулан хянаж, дүн шинжилгээ хийх, гарсан ахиц өөрчлөлт, дэвшлийг дүгнэж, шийдвэр гарагчдыг мэдээллээр хангах үйл ажиллагаа, **үнэлгээ нь** бодлогын зорилго нь хэрэгжиж дууссан, хэрэгжиж байгаа тухайн үе шатны зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон дүн шинжилгээ хийж, түүнийг боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагаа юм.

*Хүснэгт 1.Хяналт шинжилгээ, үнэлгээний ялгаатай талууд<sup>4</sup>*

	<b>Хяналт шинжилгээ</b>	<b>Үнэлгээ</b>
<b>Зорилго</b>	Тухайн эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн явцыг хэмжих	Тухайн эрх зүйн баримт бичгийн төлөвлөсөн, одоо үргэлжилж байгаа, дууссан үйл ажиллагааны зорилтод хүрэх эсэхийг хэмжих
<b>Асуулт</b>	“Юу болов?, анхны үетэй харьцуулахад ямар өөрчлөлт гарав?”	“Энэ үр дүнд яаж хүрэв?, яагаад ийм өөрчлөлт гарав?, яаж үүнийг засах вэ?”
<b>Агуулга</b>	Ямар ахиц, өөрчлөлт, дэвшил, сургамж гарсныг тодорхойлон дүгнэлт өгөх үйл ажиллагаа	Зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг үнэлж дүгнэн, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгөх үйл ажиллагаа
<b>Хамрах хүрээ</b>	Дотоод үйл ажиллагаа	Дотоод, гадаад үйл ажиллагаа болон тэдгээрийн хосолсон үйл ажиллагаа
<b>Үзүүлэлт</b>	Орц, үйл ажиллагаа, гарц	Гарц, үр дүн, үр нөлөө
<b>Мэдээлэл цуглуулалт</b>	Гарцад илүү анхаарсан ихэвчлэн тоон үзүүлэлт байх ба өдөр тутмын ажлын нэг хэсэгтэй адил амархан олдоцтой байдаг.	Зорилго, зорилтод илүү анхаарсан голдуу чанарын үзүүлэлт байх ба цуглуулахын тулд тусгайлан хүчин чармайлт хэрэгтэй болдог.
<b>Тооцоолох арга</b>	Бодит үр дүнг төлөвлөсөн болон хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж, дүн шинжилгээ хийх	Үр ашиг, үр нөлөөг зарцуулсан нөөцөд харьцуулж, дүн шинжилгээ хийх
<b>Хугацаа</b>	Тогтмол хугацаанд байнга хийдэг тасралтгүй үйл явц	Тодорхой хугацаанд урьдчилан төлөвлөж хийдэг үйл явц

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь зарчмын хувьд ялгаатай бөгөөд үнэлгээ нь тодорхой цаг хугацаанд нэг удаа хийж гүйцэтгэдэг бол хяналт шинжилгээ нь байнгын тасралтгүй үйл ажиллагаа юм.

Хяналт шинжилгээгээр цуглуулсан мэдээлэл нь үнэлгээний ажлын суурь болж, үнэлгээ хийх явцад ашиглагдана. Өөрөөр хэлбэл, хяналт шинжилгээ хийсний дараа үнэлгээ хийнэ гэсэн үг юм.

Хяналт шинжилгээ ба үнэлгээ нь үндсэн зорилго, агуулга, шалгуур үзүүлэлтийг сонгох, мэдээлэл цуглуулах арга болон хугацааны хувьд харилцан хамааралтай, эргэх холбоотой үйл ажиллагаанууд бөгөөд аливаа бодлого, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг үнэлгээ хяналт шинжилгээ үнэлгээ гэсэн логик загвараар хэрэгжүүлнэ.

Өөрөөр хэлбэл, аливаа бодлого, эрх зүйн баримт бичгийг боловсруулах шатанд тухайн бодлого, шийдвэр нь асуудлыг зөв тодорхойлж чадсан, хэрэгжих бодит боломжтой, үнэ өртөг нь хүрэлцэхүйц төсөвлөгдсөн, үйл ажиллагаа явагдах чадавх болон үр дүнг нь дүгнэх шалгуур үзүүлэлтийн мэдээлэл байгаа эсэх зэрэг асуудлуудыг шинжлэх, зардал үр ашгийн тооцоо, техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан тооцоо хийх, шалтгаан үр дагаврын уялдааг дүрслэх зэрэг аргуудаар урьдчилсан /төлөвлөлтийн/ үнэлгээ хийж байж бодлого тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөх үйл явц юм.

<sup>4</sup> Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга, аргачлал Ч.Бямбадорж, 2014 он,

## **Парламент ба Засгийн газрын түвшний хяналт шинжилгээ, үнэлгээний үялдаа холбоо, ялгаатай байдал:**

Гүйцэтгэх засаглал нь парламентын өмнө хариуцлага хүлээх, үйл ажиллагаагаа тайлагнах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ил тод байдлыг хангах нь ардчилсан төрийн тогтолцооны нэг тулгуур хэсэг юм.

Засгийн газар Парламентаас баталсан хууль тогтоомжийг хэрхэн, ямар хүрээнд хэрэгжүүлсэн, хэр амжилттай хэрэгжиж байгаад хяналт тавих нь парламентын нэг чухал үүрэг байдаг. Тийм ч учраас Парламентаас хууль баталсны дараах хяналт нь (PLS-Post Legislative Scrutiny буюу цаашид судалгаанд хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ гэх) Засгийн газарт хариуцлага тооцох, үйл ажиллагааг баталгаажуулах чухал хэрэгсэл болдог.

Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ нь дараах үндсэн хоёр хэсгээс бүрдсэн өргөн хүрээтэй ойлголт юм:

- хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад тухайн хуулиар зохицуулсан харилцаатай холбогдуулан бодлогын баримт бичиг, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт батлагдсан эсэх, хуулийн зохицуулалт нь хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа эсэх, хоёрдогч хууль тогтоомж батлагдсан бол шүүх уг хуулийг хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаа талаар;
- хууль тогтоомжийн үр нөлөөг практикт хэрхэн хэрэгжиж байгаа, ямар үр дагавар гарч байгаа болон тухайн хууль тогтоомжоор дэвшүүлсэн зорилго, зорилтуудад хүрсэн эсэх зэрэг болно.<sup>5</sup>

Хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ нь парламент өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих, өөрийгөө үнэлэх, өөрийн ардчилсан шинж чанарыг харуулах, дотоод дахь мэргэжлийн ур чадвараа харуулах боломжийг олгодог. Хууль батлагдсаны дараах хяналт шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлж эхлээд буй парламентууд нь энэхүү үйл ажиллагааг парламентын доторх тусгайлсан механизмаар зохион байгуулж байна.

Хууль батлагдсаны дараах хяналт шинжилгээ, үнэлгээ нь хоёр төрөлтэй байна. Үүнд:

1. хяналтын үүрэг: хууль тогтоомжийн хэрэглээ, ялангуяа дагалдан гарах /хоёрдугаар/ хууль тогтоомжийг батлах үйл ажиллагааг парламентаас тогтоосон хугацаанд үнэлэх;
2. үнэлгээний үүрэг: парламент нь хууль тогтоомжийн үр дүн, үр нөлөөнд бодлогын норматив зорилго тусгагдсан эсэхийг баталгаажуулах үүрэг.

Хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ нь тухайн хууль зорьсондоо хүрсэн эсэх, хүрсэн бол хэр хэмжээнд хүрсэн, хэр зэрэг нөлөө үзүүлж байгаа зэрэг хууль тогтоомжийн өргөн хүрээний хяналт шинжилгээг хамарна. Мөн тухайн хууль практикт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх нарийвчилсан үнэлгээг багтаана. Сүүлийн хувилбар нь илүү төвлөрсөн, илүү хууль эрх зүйн болон техникийн талын хяналт юм.<sup>6</sup>

Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн чанарыг сайжруулахад онцгойлон анхаарч, явц байдлыг тодорхойлохоос гадна үнэлгээ болон дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг системтэй, зохион байгуулалттай болгоход чиглэгдэж байна. Энэхүү үйл ажиллагааны явцад тухайн хууль батлагдахаас өмнөх үеийн хуулийн үр нөлөөний

<sup>5</sup> [http://164.100.47.193/Refinput/Research\\_notes/English/04122019\\_174605\\_102120495.pdf](http://164.100.47.193/Refinput/Research_notes/English/04122019_174605_102120495.pdf)

<sup>6</sup> [https://www.wfd.org/wp-content/uploads/2020/02/WFD\\_DeVrieze\\_2020\\_PLSinEurope.pdf](https://www.wfd.org/wp-content/uploads/2020/02/WFD_DeVrieze_2020_PLSinEurope.pdf)

таамаглал үнэн зөв байсан эсэхийг хууль хэрэгжсэний дараах хэрэгжилтийн явц байдлыг тодорхойлсноор хууль, түүний үр нөлөөний хамаарлын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ.

Хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ нь хууль тогтоомжийн үнэлгээний нэг хэлбэр тул хууль тогтоомжийн үр нөлөөний талаарх парламентын ойлголтыг нэмэгдүүлээд зогсохгүй тухайн хууль тогтоомж нь практикт хуулийн зохицуулалтад хамрагдаж буй талуудын хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлох үйл явц юм. Иймд хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ нь тухайн хуулийн талаарх үл ойлголцол, үл итгэлцлийг багасгах төдийгүй хууль тогтоогчдод хууль батлах явцад сургамж болдог.<sup>7</sup>

Хуулийн хэрэгжилтийн талаар төрийн байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагаас ирсэн хүсэлт, гомдол, хэвлэл мэдээллээс тухайн хуультай холбоотой асуудлуудыг дэвшүүлэх зэрэг тохиолдлуудад парламентаас хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хэзээ хийх вэ гэдэг асуудал гарч ирэх бөгөөд энэ тохиолдолд дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай болно. Үүнд:

- Парламент нь тухайн хуулийн аль эрх зүйн зохицуулалт нь асуудалтай байна, хэрэгжилт нь яагаад хангалтгүй байна гэдгийг нарийвчлан гаргаж ирэх хэрэгтэй.
- Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ерөнхий хугацааг тогтооход хэцүү ч хэтэрхий эрт хянан үзэх нь хууль тогтоомжийн нөлөөллийн талаар боловсронгуй дүгнэлт гаргах хангалттай нотолгоо байхгүй байх эрсдэлтэй байдаг. Иймд зарим хууль тогтоомжийн зохицуулалтуудын хэрэгжих хугацаа нь харилцан адилгүй, ялгаатай байж болох учир тодорхой цаг хугацаа зарцуулах, хэрэгжих нөхцөл, дэд бүтэц нь тавигдаагүй байгаа зэрэг хуулийн зохицуулалтыг харгалзан үзэх байдлаар эрэмбэлэх шаардлагатай.
- Жендэрийн тэгш байдал, эсвэл нийгмийн цөөнхийн эрх зэрэг ялгаатай асуудлуудад хууль тогтоомжийн үр нөлөөг сайжруулах боломжийг олгодог.  
Хууль тогтоомж бүр эрэгтэй, эмэгтэй хүмүүст өөр өөр байдлаар нөлөөлдөг учир эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд болон бусад холбогдох хүн ам зүйн бүлгүүдэд хэрхэн нөлөөлж байгааг үндэслэн хууль, бодлогод системтэй дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх нь тэдний үүсгэж болзошгүй аливаа сул талыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх талтай.
- Хуулийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээг аль болох үр дүнтэй болгохын тулд гүйцэтгэх засаглалын хяналтад байгаа мэдээллийг олж авах нь чухал байдаг. Гүйцэтгэх засаглал, парламент хооронд мэдээллийн тогтолцоо байхгүй тохиолдолд холбогдох мэдээллийг цуглуулах, гүйцэтгэх засаглалын мэдээлэлд нэвтрэх эрхийг хамгаалах талаар парламент өөрөө санаачилга гаргах хэрэгтэй болдог.
- Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэхэд олон нийтийн оролцоо нь нэмэлт мэдээллийн эх сурвалжид хандах боломжийг олгож, судалгааны үр дүнд итгэх итгэлийг нэмэгдүүлж, ардчилсан институцид итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг.<sup>8</sup>

Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ нь хуулийн танилцуулга, хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх гэсэн үндсэн хоёр хэмжигдэхүүнийг агуулдаг. Энэ нь Парламентын хороод болон яамд хоорондын үр дүнтэй харилцааг бий болгоход

<sup>7</sup> [https://www.wfd.org/wp-content/uploads/2020/02/WFD\\_DeVrieze\\_2020\\_PLSinEurope.pdf](https://www.wfd.org/wp-content/uploads/2020/02/WFD_DeVrieze_2020_PLSinEurope.pdf)

<sup>8</sup> [http://164.100.47.193/Refinput/Research\\_notes/English/04122019\\_174605\\_102120495.pdf](http://164.100.47.193/Refinput/Research_notes/English/04122019_174605_102120495.pdf)

чухал үүрэг гүйцэтгэдэг ч гүйцэтгэх засаглалыг парламентын өмнө хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Түүнчлэн гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдэл, иргэний нийгэм, хараат бус хяналтын байгууллагууд зэрэг бусад оролцогчид хууль тогтоомжийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжийг бүрдүүлдэг байна.

## **2.9.2.Бусад орнуудын хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж буй аргачлал, практик туршлага**

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд тухайн баримт бичгийн зорилго, хамрах хүрээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөнөөс шалтгаалан үнэлгээний арга зүй харилцан адилгүй байдаг.

Судалгааны энэхүү хэсэгт ХБНГУ, Швейцар, Чили, Мексик зэрэг орнуудын парламентаас хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж буй туршлага, аргачлал, Европын Холбооны улсуудын туршлага болон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх олон улсын нийтлэг аргачлалыг дэлгэрэнгүй байдлаар судалсан болно.

## **ХБНГУ-ЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

ХБНГУ нь Ром-Германы эрх зүйн бүлийн гол төлөөлөгч бөгөөд орчин үеийн хуулийн тогтолцоо нь 1949 онд Үндсэн хууль /Grundgesetz/-аар нь баталгаажсан байна.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн хэрэгжилтэд Үндсэн хуулийн шүүх хяналт тавьдаг бол бусад хууль тогтоомжид холбооны яамд үр дагавар, нөлөөллийн үнэлгээ хийдэг. Холбооны яамд нь хуулийг боловсруулах шатанд төслийн үе шатаас эхлэн ирээдүйд бий болох үр дагавар, дагалдах үр дагавар болон санхүүгийн нөлөөллийг судалдаг бөгөөд ямар хугацаанд үнэлж үр дагаврыг тооцохыг төлөвлөдөг. Тухайн асуудлыг эрхэлсэн Холбооны яам эрхлэх асуудлынхаа хүрээний хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхдээ муж улсууд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад боломжит цаг хугацаанд мэдэгдэж шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг гаргуулан авах эрхтэй. Сангийн яам, Дотоод хэргийн яам нь хамтран оролцож санхүүгийн тооцооллыг хийж болдог.<sup>9</sup> Холбооны яамд иргэд болон хуулийн этгээд, нийтийн захиргаанд хууль тогтоомжийг хэрэгжүүлснээс ямар зардал, ачаалал үүссэнийг тооцдог юм.

Холбооны Дотоод хэргийн яам болон Сангийн яам нь хамтран хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг баталсан бөгөөд энэхүү сайн жишиг нь Европын Холбооны улсуудад нэвтрэн хэрэгжиж байгаа төдийгүй манай улс ч гэсэн зээлдэн авч нутагшуулах оролдлогыг хийж байна. Үүний тод жишээ нь 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хууль юм.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх нь хэрэгжилтийн байдал болон түүний үр нөлөөнд ажиглалт хийдэг тогтмол үе шаттай үйл явц юм. Мөн тодорхой шалгуураар аль болох тоон үзүүлэлтийг сонгож үнэлдэг. ХБНГУ-д

<sup>9</sup> Сангийн яам нь хууль тогтоомжийн төслийн болон хэрэгжиж буй хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээг хийх явцад тухайн хууль тогтоомжийн зардал тооцоход шаардлагатай стандарт үйл ажиллагаа, зарцуулах мөнгөн дүнгийн жишиг хэмжээг баталсан.

хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах зорилгоор хийдэг:

1. тодорхой салбар дахь нөхцөл байдалд ажиглалт хийхээр (өөрчлөлтийн хамт) Жишээ нь: Байгаль орчны нөхцөл байдал ямар байгааг гаргаж ирэх зорилгоор тоо баримт гаргахаар хяналт шинжилгээ хийх, Хүнсний зүйл дэх илүүдэл буюу хорт бодисын талаар мэдээлэл, тоо баримт гаргаж ирэх зорилгоор хүнсний хяналт шинжилгээг хийх, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, холбогдох байгууллагад бодит мэдээлэл судалгаа гаргаж өгөх гэх мэт;
2. хэрэгжилтийн явцыг ажиглахад. Өөрөөр хэлбэл ажиглаж байгаа хэрэг явдал, үйл явц нь хүссэн байдлаар хэрэгжихгүй буюу тогтоосон тодорхой хэмжээнээс илүүдэх, эсхүл дутуудах тохиолдолд залж чиглүүлэхээр хийдэг.

Харин хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх нь тодорхой хугацаанд нэг удаа хийж гүйцэтгэдэг үйл ажиллагаа юм. ХБНГУ-ын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх ажлыг салбарын яам нь эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд энэ нь бодлогын хөгжүүлэлт хийх шаардлагатай эсэх, эсхүл өөрчлөх эсэхэд дүгнэлт өгдөг.

Тус улсад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дагаврын үнэлгээг дараах аргачлалаар хийдэг.

#### **А. Хуулийн үр нөлөөг үнэлэх ажиллагаа**

##### **Тодорхойлолт: Хуулийн үр нөлөөг судлах гэж юу вэ?**

Хуулийн үр нөлөөг судлах гэдэг нь боловсруулахаар төлөвлөгдөж буй буюу хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үнэлэх ажиллагаа юм.

Хуулийн үр нөлөөг судлах ажиллагаа нь

- Хуулийн төслийн боломжит хувилбарууд болон тэдгээрийн үр дагавар, үр нөлөөг харьцуулан үнэлэх замаар хамгийн боломжит хувилбаруудыг сонгон боловсруулах;
- Хуулийн төслийн заалтуудыг тодорхой шалгуурын (тухайлбал: Үр өгөөж, практикт нийцэж байгаа байдал болон зардлын тооцоо) дагуу шалгах;
- Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд бий болсон үр өгөөжийг дүгнэх явцад эсвэл тодорхой нэг цаг хугацаанд хийгдэх үнэлгээ (Шалгах үйл ажиллагаа).

##### **Хуулийн үр нөлөөг судлах ажиллагааны 3 хэлбэр:**

##### **Хуулийн үр нөлөөг хэзээ судлах вэ?**

Хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааны ялгаатай үе шатуудын болон хууль хэрэгжилтийн үйл ажиллагааны хүрээнд хуулийн үр нөлөөг тандан судлах шаардлагын үүднээс дараах 3 хэлбэрүүдээс бүрдэнэ.

1. Хуулийн төслийн хувилбаруудын үр нөлөөг урьдчилан тандан судлах гэдэг нь тухайн харилцааг зохицуулах зохицуулалтын боломжит хувилбаруудыг харьцуулан судалж, үр дагаврыг нь урьдчилан тооцох ажиллагаа юм.  
(Зохицуулах санал)

Энэхүү ажиллагааг:

- Тухайн зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлага бий эсэхийг тогтоох (бодит байдал дээр зохицуулах зайлшгүй шаардлага бий юу),
- Зохицуулалтын бүхий л боломжит хувилбаруудыг илрүүлж, тэдгээрээс хамгийн магадлал өндөртэй зохицуулалтын үр дагавруудыг нэг бүрчлэн харьцуулж, тэдгээрийн зорилгод нийцэх байдлыг үнэлж, тандан судлах (Ямар үр нөлөө хаана, хэнд, хэзээ бий болохоор байна вэ?),
- Зохицуулалтын хамгийн боломжит хувилбарыг илрүүлэхийн тулд авч хэрэгжүүлдэг.

2. Боловсруулалтын шатанд байгаа хуулийн төслийн үр нөлөөг дагалдан тандан судлах гэдэг нь тухайн харилцааг зохицуулахаар боловсруулж буй хуулийн төслийн үр дагаврыг дагалдаж тооцож, тандан судлах ажиллагаа юм.

Боловсруулалтын шатанд байгаа төслийн үр нөлөөг дагалдан судлах ажиллагааг:

- Хуулийн төслүүдэд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх (Жишээ нь: Зорилгод хүрэх байдал, зардал),
- Хуулийн төслүүдийг бүхэлд нь болон хэсэгчлэн бодит байдалд ойртуулан туршиж үзэх,
- Хуулийн төсөл дэх дутагдал, хийдэл, зөрчил болон хүсээгүй үр дагавруудыг (дагалдах үр дагаврууд) илрүүлэх, олж тогтоох,
- Хуулийн төслийн боломжит хувилбарыг тогтоохын тулд тус тус авч хэрэгжүүлдэг.

**3. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх гэдэг нь тухайн хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтуудыг хойноос /араас/ нь тандан судлах ажиллагаа юм.**

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг:

- Хэрэгжиж буй эрх зүйн зохицуулалт нь зорилгодоо хүрч байгаа эсэхийг тогтоох
- Бусад үр нөлөө болон үр өгөөж (тухайлбал Зардлын тооцоо, Зардал-үр өгөөжийн-харьцаа, хүлээн зөвшөөрч байгаа байдал, практикт нийцэж байгаа байдал) эсвэл бусад үр дагавруудыг тогтоох
- Мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тогтоох

**Б.Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үндсэн ойлголт**

Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх судлах ажиллагаа нь үндсэн 3 үе шатуудаас бүрдэнэ.

- Төлөвлөлтийн үе шат
- Хэрэгжилтийн үе шат
- Үнэлгээний үе шат

### **1. Төлөвлөлтийн үе шат**

1.1 Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх шалтгаан:

Аливаа нэг хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалтын үр өгөөж болон үр нөлөөг үнэлэхэд зайлшгүй

- Нийгмийн бүлгүүдийн зүгээс тодорхой хууль, эрх зүйн зохицуулалтад тодорхой өөрчлөлтүүд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд;
- Улс төрийн бодлого болон захиргааны байгууллагын зүгээс хууль эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд;
- Шүүх байгууллагын зүгээс эрх зүйн хэм хэмжээнүүдийн тодорхой зохицуулалтуудыг хэрэглэхэд хүндрэлтэй байгаа талаар мэдэгдсэн тохиолдолд;
- Хуулийн тодорхой заалтуудад тодорхой нэг хугацаанд шалгалт (үнэлгээ) хийх талаар хуульд заасан бол.

1.2 Шалгуур үзүүлэлтийг тодорхойлох:

Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхдээ юуны түрүүнд ямар шалгуур үзүүлэлтийг шалгах шаардлагатайг тогтооно. Төлөвлөгдсөн үнэлгээний хүрээтэй нягт уялдуулан тогтоох хэрэгтэй (1.3 –тай харьцуулахад):

Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөө бүрийн хамгийн чухал зохицуулалт нь шалгуур үзүүлэлтийг томъёолох

- Зорилгод хүрсэн төвшинг тодорхойлох  
Асуулт: Хуульд заасан зорилгодоо хүрэхийн тулд хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохицуулалтуудын хүрээнд хүрж чадах уу?

Бусад чухал шалгуур үзүүлэлтүүд

- Зардал төсвийн хувьд
- Зардал-Үр өгөөжийн–Харьцаа
- Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- Практикт нийцэж байгаа байдал
- Бусад үр дагавар

*Үр нөлөөний загварыг тодорхойлох*

Хэрэв зорилгод хүрсэн төвшинг үнэлэх гэж буй бол хуулийн ерөнхий зорилго (үндсэн зорилго)- ын зэрэгцээ өөр хэд хэдэн дэд болон дагалдах зорилт бий эсэхийг шалгах хэрэгтэй. Хуулийн зохицуулалтууд нь үр нөлөөний загварын тодорхойлох үндэс нь болдог. Зохицуулалтын зорилго болон түүнд чиглэгдсэн нарийвчилсан арга хэмжээнүүдийн хоорондын уялдааг үр нөлөөний загвараар зохицуулна. Үүнтэй уялдуулан дараах асуудлуудыг томъёолж болно.

- Энэхүү хуулийн үндсэн зорилго юу вэ?
- Ямар дэд болон дагалдах зорилтуудтай вэ?
- Энэ хуулийн зорилгод хүрэхийн тулд ямар нарийвчилсан арга хэмжээнүүдээр дэмжиж болох вэ?

1.3 Үнэлгээний хүрээг тогтоох:

Үнэлгээний хүрээг тогтоохдоо эрх зүйн зохицуулалтуудын аль хэсгийг судлах шаардлагатайг тодорхойлох хэрэгтэй. Энэ нь ямар шалгуур үзүүлэлтүүдийг тогтоохоос шалтгаална.

Хэрэв зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал болон хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргийг шалгуур үзүүлэлтээр сонгосон бол тодорхой үр өгөөж хүсэн хүлээж байгаа тухайн хуулийн заалтуудаас сонгох шаардлагатай.

1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох:

Хуулийн зохицуулалтын үр нөлөө болон зорилгод хүрсэн төвшингээр тухайн зохицуулалтыг бүрэн үнэлэх боломжгүй бөгөөд харьцуулах хэлбэрийг мөн ашиглах боломжтой. Үүний тулд харьцуулах хэлбэрийг тодорхойлох шаардлагатай.

Харьцуулах гэдэг нь Эрх зүйн хэм хэмжээ бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж байгааг “харьцуулах мэдээлэл” хооронд нь харьцуулах (Байх ёстой үнэлэмж)

Байх ёстой/ одоо байгаа

Хууль тогтоомжийн хэм хэмжээний хувьд тодорхой байх ёстой хэмжигдэхүүнийг шалгах ёстой гэж заасан тохиолдолд (Жишээ нь: машинаас ялгарч байгаа хорт утаа, онгоцны буудлын дуу чимээний хязгаарлалтын талаар) байх ёстой болон одоо байгаа байдалтай шууд харьцуулалт хийж болно.

Хууль хүчин төгөлдөр хэрэгжихээс өмнө / хүчин төгөлдөр хэрэгжсэнээс хойш

Хэрэв хуульд байх ёстой хэм хэмжээг тодорхой заагаагүй тохиолдолд хууль хүчин төгөлдөр хэрэгжихээс (үйлчихээс) өмнөх мэдээлэл хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойших байдалтай харьцуулан үзэж болно: (Жишээ нь: Орон сууц бүрт заавал галын дохиоллыг суурьлуулхаас өмнө болон суурьлуулсны дараагаар орон сууцанд гарсан галын тоог харьцуулах )

Гэхдээ хууль хүчин төгөлдөр хэрэгжихээс (үйлчлэхээс) өмнө болон хууль хүчин төгөлдөр хэрэгжсэнээс хойших олон жилийн мэдээллүүд мэдээллийн санд байгаа тохиолдолд харьцуулж үзэж болно. Үүнд: он цагийн дарааллыг судалгааны цаг хугацааны дагуу хийгдсэн судалгаанууд энэхүү харьцуулалтыг хийхэд тус дөхөм болж өгнө. (Жишээ нь: 2000 оноос эхлэн 2005 он хүртэл хуулийн хэм хэмжээ батлагдах хүртэл жил бүрийн тохиолдлын тоо, түүнчлэн дараа жилүүдийн тоон үзүүлүүлэлтүүдийг харьцуулан авч үзэх)

Ex-post- анализ (хүчин төгөлдөр үйлчилж /хэрэгжиж эхэлснээс хойш)

Хууль хүчин төгөлдөр хэрэгжихээс өмнө - хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойших харьцуулалтын зэрэгцээгээр тухайн хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойших (зөвхөн) мэдээллүүдийг харьцуулан судалж болно.

Хэрэв хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс өмнө холбогдох эсвэл тодорхой харьцуулалт хийх мэдээллүүд байхгүй тохиолдолд энэхүү харьцуулалтыг хийнэ.

Шалгах арга хэрэгслийн хувьд он цагийн дарааллыг судалгааны цаг хугацаатай харьцуулж болно. (Мэдээллийн сан болон хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойших 1,2,3 дахь жилийн өөрчлөлтүүдийг харьцуулах)

### **Ижил төстэй хэм хэмжээг судлах**

Хуулийн хэрэгжилтийг шалгах явцад нэмэгдэн орсон өөрчлөлтүүдийг холбогдох мэдээлэл болон агуулгын хувьд ижил төстэй боловч өөр хүрээнд хэрэгжиж байгаа хуулийн хэм хэмжээний өөрчлөлтүүдийг хооронд нь харьцуулж болно.

Жишээ нь: А болон Б хотуудад нийтэд нь “Хурдны хязгаар 30” гэж тогтоож өгснөөр зам тээврийн осол хэр хэмжээгээр өссөн/багассан талаар.

*Ямар харьцуулах хэлбэр тохиромжтой эсэх, эсвэл хэд хэдэн харьцуулах хэлбэрүүдийг өөр хооронд нь уялдуулах шаардлагатай эсэхийг тохиолдол бүр дээр шалгах, тогтоох хэрэгтэй.*

1.5 Шалгуур үзүүлэлтүүдийг томъёолох:

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдийг (1.2 дагуу ) хэрэгжүүлэхийн өмнө эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг томъёолох шаардлагатай.

Томъёолох гэдэг нь шалгуур үзүүлэлт бүрт (Жишээ нь: Зорилгод хүрэх түвшин) тодорхой таамаглал өөрөөр хэлбэл тодорхой нэг асуултыг дэвшүүлэх шаардлагатай.

Жишээ нь :

- Хурдны хязгаар 30 гэж нэмэлт өөрчлөлт оруулснаар зам тээврийн осол багасана/ буурна.
- Ажлын цагийг уян хатан тодорхойлж өгснөөр хөдөлмөр эрхлэх эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн.

Энэхүү таамаглалууд нь цаашид бодит нөхцөл дээр хэр нийцэж байгааг шалгах шаардлагатай.

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Одоо шаардлагатай байгаа мэдээллүүдийг ямар аргаар хэрхэн боловсруулахыг тодорхойлох шаардлагатай. Санал болгох төрөл бүрийн аргууд байна.

### **Тухайн бэлэн байгаа материалуудыг дүгнэх**

- Судлаачдын зөвлөмж болон бэлэн байгаа мэргэжлийн ном, сэтгүүлүүдийг судлан дүгнэх
- Байгаа статистикийн мэдээнүүдийг судлан дүгнэх
- Шинжлэх ухааны судалгаануудыг судлан дүгнэх

### **Холбогдох байгууллагуудаас бичгээр судалгаа болон тайлан авах**

Хуулийн хэрэгжилт эсвэл чиг үүргийн биелэлттэй холбоотой асуулгыг холбогдох байгууллагуудаас бичгээр авах нь мэдээлэл цуглуулах чухал арга хэрэгсэл юм.

Нарийвчилсан санал асуулгын тусламжтайгаар тодорхой тоо баримтууд (тоон үзүүлэлт) мөн холбогдох хуулийн хүрээнд үр нөлөө, практикт нийцэж байгаа байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал болон бусад шалгуур үзүүлэлтүүдийн хэрхэн биелэгдэж байгаа талаар тодорхой үнэлэлтийг (чанарын үзүүлэлт) мэдэх боломжтой.

Эсвэл холбогдох байгууллагуудаас тогтсон тайланг тогтмол (Жишээ нь: хагас жил, бүтэн жилийн), тодорхой мэдээллийн хүрээнд бэлтгэн ирүүлж байхаар зохицуулж болно. Иймэрхүү тогтсон тайланг бэлтгэхийн тулд хамгийн түрүүнд ЯМАР мэдээллийг, ЯАЖ, ХЭЗЭЭ мөн түүнчлэн ХЭНЭЭС авахыг тодорхойлох шаардлагатай.

**Шинжээчдийн үүлзалт, хэлэлцүүлэг**

Мэргэжилтэн, хариуцагч байгууллагуудын төлөөлөл болон бусад үүрэг хүлээгчдийг оролцуулсан Workshop-ийн гол зорилго нь өмнө нь эсвэл санал асуулгаар хүлээн авсан мэдээлэл, таамаглалуудыг тайлбарлуулан баталгаажуулахад оршино.

Иймэрхүү Workshop-ийн гол зорилго нь тухайн хуулийн хэм хэмжээг баталгаажуулах эсвэл тухайн хэм хэмжээний сул талыг буюу практикт хэрэглэх хэрэглээг тодорхойлсноор тухайн зохицуулалтын боломжит хувилбарыг боловсруулахад чиглэгдэнэ.

## **2. Хэрэгжилтийн үе шат**

Энэ үе шатанд мэдээллийг 1.6 тодорхойлсны дагуу боловсруулна.

## **3. Үнэлгээний үе шат**

Цуглуулсан мэдээллүүдийг дүгнэх ба үр дүнг харьцуулах хэлбэр бүрийн (1.4-ийг харна уу) дагуу үр дүнг үнэлнэ.

Ерөнхий асуудлуудыг томъёолбол:

- Хуулийн дагуу төлөвлөгдсөн зорилгодоо хүрч чадсан уу,
- Зардлын тооцоо (хэнд ?) болон зардал-үр өгөөжийн харьцаа эерэг гарсан уу,
- Зохицуулалтуудыг хүлээн зөвшөөрдөг үү,
- Зохицуулалтууд практикт нийцэж байна уу,
- Бусад үр дагаврыг хүлээн зөвшөөрөх уу,

Энэ аргачлал болон үнэлгээний үр дүнг баримтжуулна.

Үр дүнд нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл тухайн хэм хэмжээг хүчингүй болгох тухай саналыг боловсруулж болно. Түүнчлэн тухайн хэм хэмжээг шалгаж үзээд өөрчлөх шаардлагагүй хэвээр нь байлгах саналыг өгч болно.

*/Übersicht zur retrospektiven Gesetzesfolgenabschätzung - аргачлалыг герман хэл дээр судалгаадааны хавсралтаар оруулав./*

## **ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

Швейцарын парламентын Тамгын газрын Үнэлгээний алба нь Парламентын Хяналтын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бие даасан үнэлгээ хийх эрхтэй бөгөөд бодлогын баримт бичгийн үнэлгээг хийхдээ дараах арга зүйг ашигладаг.

### **Үнэлгээ хийх шалтгаан, хамрах хүрээг тогтоох:**

*Үнэлгээ хийх шалтгаан:* Үнэлгээ хийх шалтгаан нь төлөвлөлтийн үе шатны суурь хүчин зүйл бөгөөд гол төлөв тухайн хууль, эсхүл түүний бүлэг, зүйл, заалтын болохгүй байгаа болон болж байгаа талыг гаргаж ирэхэд оршдог. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөөнд үнэлгээ хийхэд тодорхой шалтгаан байх ёстой бөгөөд тус хууль нь тухайн харилцааг зохицуулж чадаж буй эсэх, түүний нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлсон байна.

Үнэлгээ хийх шалтгаан нь бодит байдал дээр нэгэнт үүссэн, илэрхий байхаас гадна, нуугдмал буюу нэмэлт тодруулга хийх, мэдээлэл цуглуулах замаар тогтоогдохоор байж болно.

*Үнэлгээ хийх хүрээг тогтоох:* Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэгдэнэ. Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх хэрэгтэй. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал хэт

өндөр гардаг учир тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болох хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

### Үнэлгээний асуулт, шалгуур үзүүлэлт боловсруулах:

*Үнэлгээний асуулт боловсруулах:* Үнэлгээ хийх шалтгаан, хамрах хүрээнээс шалтгаалан үнэлгээний асуулт нь үнэлгээний зорилгод чиглэгдсэн байх ёстой. Үнэлгээний асуулт нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- *Чиглэгдсэн байх.* Жишээ нь үнэлгээний судлагдахуун ямар асуудалд чиглэгдэж байгаа нь тодорхой байх;
- *Нээлттэй, тодорхой бүтэцтэй байх.* Асуулт нь ямарваа нэгэн тодорхой зүйлийг нотлох (тухайлбал тийм/үгүй гэсэн хариулт) бус, асуудлын цар хүрээ, хэлбэр зэргийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх;
- *Бодит байдалд нийцсэн байх,* тухайлбал үнэлгээний үр дүнгээс тодорхой нөхцөл байдал үүсэх боломжийг хангах (судалгааг хэрэгжүүлэх явцад);
- *Тодорхой байх.* Асуулт нь тодорхой, ойлгомжтой, ямарваа нэгэн бүрхэг, хоёрдмол утгатай нэр томъёогүй байх (шаардлагатай бол тодотгол хийх);
- *Мэдлэгт тулгуурлан хариулах боломжтой байх.* Мэдээ мэдээллийг ашиглан асуултад хариулах боломжтой, хөндсөн асуудлууд нь ойлгомжтой байх;
- Боломжит нөөц болон үнэлгээний цагийн хуваарьт *нийцсэн байх;*
- Үнэлгээний үр дүнг ашиглах хүмүүсийн сонирхолд нийцсэн мэдээ мэдээллийг хуримтлуулах *боломжтой байх.*

Үнэлгээний асуулт боловсруулахдаа дараах төрлийн асуулт байдгийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- *Тайлбар асуулт* нь судалгааны судлагдахуунд үнэлгээ өгөх бус, харин ямарваа нэгэн тайлбар, тодотгол авах зорилготой.
- *Үнэлгээний асуулт* нь өнөөгийн байдлыг хүлээгдэж буй нөхцөл байдалтай харьцуулсан байна
- *Ерөнхий асуултууд* нь тодорхой үр нөлөөг тогтооход дэмжлэг үзүүлнэ.

Асуултууд нь үнэлгээний зорилготой нийцэж байгаа эсэхийг үнэлгээний явцад тогтмол шалгаж байх нь зүйтэй.

#### Хүснэгт 2. Асуултын хувилбарууд


	Бодлого боловсруулах	Хэрэгжилт	Үр нөлөө
Үйл явцад хэрхэн дүгнэлт хийх вэ?			
Бодлогын удирдлагад хэрхэн дүгнэлт хийх вэ?			
Бүсүүдийн хооронд ялгаа байгаа юу (жишээ болгох)? Ялгаа байгаа бол үүнийг харгалзан тусгай бодлого хэрэгжүүлэх, арга хэмжээ авсан эсэх?			
Оролцогч талууд, тэдний үүрэг, үйл ажиллагаа, мэдлэг туршлагын дүгнэлт			
Харьцуулалт: харьцуулах боломжтой нэгжүүдийн удирдлагын зарчим? Төрийн захиргааны үйл ажиллагааны хэрэгжилтийг хувийн хэвшлийн салбартай хэрхэн харьцуулах вэ?			
Үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?			
Нормативын болон үзэл баримтлалын үндэс нь бодлогын зөв зохистой хэрэгжилтийг хангаж байгаа эсэх?			

Үйл явц, ажиллагааны зөв зохистой байдлыг хэрхэн дүгнэх вэ?			
Зорилт ямар хэмжээнд биелэгдсэн, янз бүрийн хэмжээнд биелэгдсэн бол шалтгааныг тодруулах.			
Бодлогын нөлөөлөлд хэрхэн дүгнэлт хийх вэ?			
Төр засаг, төрийн болон орон нутгийн захиргааны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, цар хүрээ			

### Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох:

Системчилсэн дүгнэлт хийхийн тулд тодорхой шалгуурыг тогтоох шаардлагатай. Үнэлгээний судлагдахуунд дүгнэлт хийх шалгуурыг сонгохдоо эхлээд үнэлгээний асуултуудыг үндэс болгох нь зохимжтой. Үнэлгээ хийхэд шалгуурын нэг түвшин хангалтгүй байдаг тул янз бүрийн түвшний шалгуурын зааг ялгааг тогтоох шаардлагатай. Шалгуурын нийтлэг гурван түвшин байдаг. Үүнд:

Зураг 1. Гол, дэд шалгуур, үзүүлэлтийг зургаар үзүүлбэл:



**Гол шалгуур:** Гол шалгуурыг үнэлгээний асуултуудад шууд үндэслэн тогтоож болно. Үнэлгээний төгсгөлд гол шалгуурын түвшинд эцэслэсэн дүгнэлтийг гаргах учир гол шалгуурын тоог хязгаарлах (үнэлгээний асуулт тус бүрт нэгээс хоёр байхаар) нь зүйтэй. Гол шалгуурыг дэд шалгуурт задална.

**Дэд шалгуур:** Бодит байдлын дүгнэлтийн гол түвшин нь дэд шалгуурын түвшин юм. Дэд шалгуур нь дүгнэлтийн нэн чухал чиглэлүүдэд төвлөрч, асуудлын үр дүнд нөлөөлнө. Цар хүрээнээс хамааран дэд шалгуур нь шууд хэмжигдэх, эсвэл үзүүлэлтээр задлах шаардлагатай байдаг.

**Үзүүлэлт:** Хэрэв дэд шалгуур нь дотроо хэмжигдэх боломжтой, эсвэл олон эх сурвалжийн мэдээ мэдээллийг хамарсан хэд хэдэн дэд чиглэлтэй бол дэд шалгуурыг үзүүлэлтээр задлан тодруулах нь хамгийн зохимжтой. Олон чиглэлгүй дэд шалгуурыг үзүүлэлтээр задлах шаардлагагүй, зарим зүйл тодорхой бус байхыг хүлээн зөвшөөрч болно.

Шалгуур үзүүлэлтүүд нь дараах зүйлсийг агуулсан байх ёстой.

- Тоон мэдээ баримт;
- Чанарын мэдээ баримт;
- Цаг хугацаатай холбоотой мэдээ баримт.

**Шалгуур үзүүлэлтийг томъёолох:** Шалгуур үзүүлэлтийг томъёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавихыг хэлнэ. Таамаглал дэвшүүлэх, асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томъёолж байх нь зүйтэй бөгөөд энэ нь цаашид мэдээлэл цуглуулах, үнэлж дүгнэхэд хялбар байна.

Шалгуур үзүүлэлтийг томъёолох буюу тодорхойлоход нэг утгатай, хэмжихүйц ухагдахууныг хэрэглэх бөгөөд тэдгээрийг шалгах боломжтой байх ёстой.

### **Судалгааны хэлбэр, арга зүй:**

*Тодорхой нэг асуудлын судалгаа:* Хэрэв нэг асуудлыг дагнан нарийвчилсан дүн шинжилгээ хийвэл тодорхой нэг асуудлын талаарх судалгаа байх бөгөөд бусад асуудалтай холбоогүй учир түүнд харьцуулалт хийдэггүй, түүнчлэн зөвхөн тухайн асуудалтай холбоотой дүгнэлт гаргадаг тул судалгааны үр дүнгээс ерөнхий үнэлгээ, санал гаргах зорилгогүй болно.

*Харьцуулсан судалгаа:* Харьцуулсан судалгаа нь олон асуудлыг харьцуулах зарчимд суурилсан ба үнэлгээний гол зорилго нь ерөнхий хандлагыг тогтооход оршино. Хандлагыг тогтоох дараах арга хэлбэрүүд байж болно. Үүнд:

- бүлэг хоорондын дүн шинжилгээ: хэд хэдэн асуудлыг цаг хугацааны тухайн нэг үед харьцуулах;
- хугацааны дүн шинжилгээ: нэг болон хэд хэдэн асуудлыг цаг хугацааны янз бүрийн үед харьцуулах;
- хяналтын бүлгийн судалгаа: асуудлын агуулгыг адил төстэй нэг болон олон асуудалтай харьцуулах, ингэхдээ зөвхөн нэг тусгагдахуунаар ялгагдаж байхыг харгалзах;
- асуудлын харьцуулсан судалгаа: бүхэл бүлэг асуудалд бүлэг хоорондын, эсвэл хугацааны дүн шинжилгээ хийж дүгнэлт гарган, асуудал хоорондын адил төстэй болон ялгаатай шинж байдлыг тодорхойлно.

**Мэдээлэл цуглуулах арга:** Үнэлгээ хийхдээ ямар мэдээлэл, судалгааг хэнээс, хэрхэн, ямар аргаар, хэзээ авахаа оновчтой тодорхойлно. Үүнийг зөв тодорхойлж чадвал санхүү, боловсон хүчин, цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой.

Судалгааны арга аргачлал нь мэдээ мэдээллийг цуглуулах, үнэлэх процедурыг тогтооно. Процедур нь чанарын болон тоон үзүүлэлтээр ялгагдах ба нийгмийн бодит байдлын судалгааны аргачлалтай уялдаатай байна. Доор дурдсан аргачлал нь чанарын болон тоон үзүүлэлтийг хамаарна.

*Баримт бичгийн дүн шинжилгээ:* Холбогдох баримт бичгийг нарийвчлан судлах нь үнэлгээний судлагдахуун, түүний судалгааны агуулга чиглэлийг ойлгоход тустай. Баримт бичгийн дүн шинжилгээ нь зөвхөн агуулгын талаар мэдээлэл олоход бус, ямарваа нэгэн тусгай шалгуурын талаар мэдээлэл хуримтлуулах, бодит мэдээ мэдээлэл цуглуулахад нэн чухал бөгөөд үйл явцыг тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ.

Баримт бичигт - удирдамж, үзэл баримтлал, стратегийн баримт бичиг, хуулийн заалтууд, тэмдэглэл, сонины өгүүлэл, шинжлэх ухааны хэвлэл, урьд нь хийсэн үнэлгээ зэрэг багтана.

*Ярилцлага:* Чиглүүлсэн (эсвэл хагас зохион байгуулалттай) ярилцлагыг ихэвчлэн нээлттэй харилцан ярилцлага хэлбэрээр явуулдаг ба түүний зорилго нь адил төстэй асуултаар харьцуулах боломжтой хариулт авахад бус, харин ярилцлагад оролцогсдын судлагдахууны талаарх санал бодлыг сонсоход оршино. Ярилцлагыг нээлттэй явуулах, оролцогчдод санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хариултыг ямарваа нэгэн байдлаар хязгаарлах, тулгахгүй байх нь зорилтод хүрэх гол үндэс болно. Ярилцлагыг ихэвчлэн бичлэгээр баримтжуулна.

*Судалгаа:* Хагас зохион байгуулалттай ярилцлагыг бодвол судалгаа нь стандартчилагдсан арга бөгөөд бүх оролцогчдод зөвхөн нэг асуулт тавина. Судалгааг биечлэн, утсаар, бичгээр, цахимаар явуулах нь чухал биш. Судалгааг илүү үр дүнтэй, найдвартай хийх янз бүрийн журмыг гаргасан.

*Хоёрдогч мэдээ мэдээллийн дүн шинжилгээ:* Байгаа мэдээ мэдээлэл, тухайлбал албан ёсны статистикийн мэдээлэл, эсхүл өмнөх судалгааны явцад цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх. Гэвч ихэвчлэн байгаа мэдээ мэдээлэл нь тухайн судалгаа хийхэд тохиромжгүй байдаг учир шинэ судалгаа хийх шаардлагатай тулгардаг.

*Ажиглалт:* Шинжлэх ухааны ажиглалтыг стандартчилсан, баталгаажуулсан байдлаар үйлддэг ба ажиглалтаас чанарын болон тоон мэдээ мэдээлэл гаргадаг. Чанарын ажиглалт хийхэд тодотголын арга хэлбэрийг ашиглах шаардлагатай.

*Бүлгийн хэлэлцүүлэг:* Бүлгийн хэлэлцүүлгийн зорилго нь хувь хүмүүсийн санал бодол, туршлагыг хуримтлуулах бус, нөхцөл байдлаас хамааран эдгээр санал бодол хэрхэн бүрэлдсэнийг тогтооход оршино. Ингэснээр ерөнхий хандлага, таамаглалыг тодорхойлох боломжтой.

### **Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх:**

Ашигласан арга хэлбэрээс хамааран судалгааны мэдээ мэдээллийг янз бүрээр боловсруулдаг (тухайлбал ярилцлагын бичлэг хийх, судалгааны хариултыг томъёолох) ба үүний дараа цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ерөнхий байдлыг тодорхойлно. Түүнчлэн чанарын мэдээллийн агуулгад дүн шинжилгээ хийж, чанарын мэдээллийг тоон мэдээлэлд шилжүүлж болно. Тоон мэдээлэлд шилжүүлсэн мэдээ мэдээллийг цаашид дүн шинжилгээ болон судлагдахууныг тайлбарлах, дүгнэхэд ашиглах боломжтой. Харилцан хамаарал болон эргэн харьцуулах дүн шинжилгээг ашигласнаар тоон мэдээ мэдээлэл нь уялдаа холбоо, шалтгааныг тодорхойлох боломжийг олгоно.

Үнэлгээ нь асуудалд чиглэгдсэн арга хэлбэр, олон төрлийн асуулт, хариулт шаарддаг учир янз бүрийн аргачлалын хослолыг ашигладаг. Үүнд холимог болон гурвалсан аргачлалыг ашиглаж болно:

- холимог аргачлал: тодорхой нэг асуудлын судалгаанд янз бүрийн аргачлалыг ашиглах;
- гурвалсан аргачлал: тодорхой нэг асуултад хариулт авахад хэд хэдэн өөр аргачлал ашиглах.

**Тайланг хэрхэн боловсруулах, тайлангийн загвар:** Үнэлгээний чанартай сайн тайлан нь уншихад хялбар, мөн мэргэшлийн үг хэллэг агуулаагүй байвал зохино. Хүснэгт, график болон бусад зураг дүрс нь гол үр дүнг ойлгомжтой, энгийн байдлаар онцлон харуулдаг. Хүн бүр уг тайланг бүхэлд нь сонирхохгүй тул, товч “хураангуй” байх шаардлагатай.

Үнэлгээний тайлан нь үнэлгээний үйл явцын гол гарц бүтээгдэхүүн бөгөөд үүнд дараах элементүүд агуулдаг. Үүнд:

- Тайлангийн гарчиг бүхий нүүр хуудас
- Ерөнхий хураангуй
- Гарчиг
- Танилцуулга бүлэг:
  - Үнэлгээ хийлгэж буй төсөл/ хөтөлбөр/ хуулийн тухай тайлбар
  - Зорилгын тодорхойлолт, хамрах хүрээ, үнэлгээний хязгаарлагдмал талууд
  - Үнэлгээний гол асуултууд
- Үнэлгээний аргачлал, арга зүй, мэдээллийн эх сурвалжууд
- Үр дүнгүүд (үнэлгээний асуултуудын бүтцийг дагах)
- Үр дүнгүүд ба тэдгээрийн хөрвүүлэг тайлбар (дүгнэлтэд тоймлох боломжтой)

- Дүгнэлт
- Зөвлөмжүүд ба/эсхүл сургамжууд
- Товчилсон үгсийн жагсаалт, ярилцлага хийсэн хүмүүсийн нэрсийн жагсаалт, үнэлж судалсан баримт бичгүүд.
- Хавсралтууд: тодорхой арга аргачлалын тухай дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтад тусгах

Үнэлгээний тайланд оновчтой төгс хэмжээ гэж байхгүй боловч, сайн үнэлгээний тайлан нь чухал мэдээллийг хэт нуршилгүйгээр гол асуудлуудаа хэрхэн товч тодорхой, ойлгомжтой илэрхийлэхээс хамаарна.

*Хоёр, тав, хорин-тав (2:5:25)-ын зарчим:* Тайланг боловсруулахдаа үнэлгээний үр дүнгүүдийн логик уялдааг харгалзан дараах зарчмыг баримтлан боловсруулна. Үүнд:

- Тайлангийн ерөнхий хураангуй хэсэг - 2 хуудас;
- Танилцуулга, нөхцөл байдал, гол асуултууд, арга зүйн хэсэг - 5 хуудас;
- Үр дүн ба дүгнэлт хэсэг - 25 хуудас.

## **ЕВРОПЫН ХОЛБООНЫ ОРНУУДЫН ПАРЛАМЕНТААС ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ АРГАЧЛАЛ<sup>10</sup>**

Европын Холбооны орнуудын парламентаас хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх парламентын ажлын албаныханд зориулсан нийтлэг аргачлалыг судалгааны энэхүү хэсэгт бүхэлд нь авч үзлээ. Энэ аргачлалын дагуу хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг дараах 4 үе шатаар 18 алхмын дагуу гүйцэтгэдэг байна.

### **1.Урьдчилан төлөвлөлтийн үе шат**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг төлөвлөхөөс өмнө хэд хэдэн асуудлыг тодруулах шаардлагатай байдаг. Үүнд:

- Хуулийн хэрэгжилтийг хянан шалгахад заавал биелүүлж, мөрдөх зохицуулалтыг хууль батлахаас өмнө тодорхойлоход анхаарах;
- Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалтгаан, нөхцөлийг тогтоох;
- Хүний нөөцийг бүрдүүлэх;
- Бусад санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.

***Алхам 1. Хуулийн хэрэгжилтийг хянан шалгахад заавал биелүүлж, мөрдөх зохицуулалтыг хууль батлахаас өмнө тодорхойлоход анхаарах:***

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг бэхжүүлэх хамгийн үр дүнтэй механизм бол хуулийг парламентаар батлахаас өмнө тухайн хуулийн хэрэгжилтийг хянан шалгахад заавал биелүүлж, мөрдөх шаардлагыг тодорхойлсон байх явдал юм. Энэхүү заавал биелүүлэх шаардлагыг тодорхойлох хэд хэдэн арга байдаг. Үүнд:

1. Хуулийн төслийг батлах явцад тухайн хуулийн хэрэгжилтийг хэзээ, ямар хүрээнд хянан үзэх тухай амлалтыг Засгийн газрын сайд нараас авч болно;

<sup>10</sup> POST-LEGISLATIVE SCRUTINY GUIDE FOR PARLIAMENTS [https://www.wfd.org/wp-content/uploads/2018/07/WFD\\_Manual-on-Post-Legislative-Scrutiny.pdf?fbclid=IwAR37-pesPGWx9pofQiGMVsVfVbyMZ9G1yVLPa0m4IqRjwvke4lw6-S2MZIO](https://www.wfd.org/wp-content/uploads/2018/07/WFD_Manual-on-Post-Legislative-Scrutiny.pdf?fbclid=IwAR37-pesPGWx9pofQiGMVsVfVbyMZ9G1yVLPa0m4IqRjwvke4lw6-S2MZIO)

2. Парламентаас хуулийн хэрэгжилтийг хянан шалгах зорилгоор тухайн хуульд хянан шалгах заалтыг тусган батлах. Хянан шалгах заалт нь хуулийн хэрэгжилтийн үйл явц эсхүл тухайн хуулийн зарим хэсгийг тодорхой хугацааны дараа хянан үзэх тухай зохицуулалт байдаг. Мөн хянан шалгах заалтыг ерөнхий байдлаар хуульд тусгах эсхүл хянан шалгах тодорхой заалт, түүний цаг хугацаа, хэн гүйцэтгэх тухай заалтыг тодорхой тусгаж болно.
3. Хууль батлахдаа sunset clause буюу тодорхой хугацааны дараа үйлчлэл нь дуусах нөхцөлтэй заалтыг тусгаж болно. Энэхүү заалтын давуу тал нь тухайн хуулийн үйлчлэл нь тодорхой хугацааны дараа дуусах эсхүл тухайн хууль болон заалтыг шууд хүчингүй болгох боломжийг олгодог.

Хууль батлахдаа хянан шалгах заалт эсхүл тодорхой хугацааны дараа үйлчлэл нь дуусах нөхцөлтэй заалтыг тусгах нь ихэнх тохиолдолд улс төрийн тохироог илэрхийлдэг ч парламентаас батлагдаж буй хуулийн хэрэгжилтийг заавал хянан үзэхийн тулд хуулийг хэлэлцэн батлах болон нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дээрх арга хэлбэрүүдээс сонгох боломжтой юм.

### **Алхам 2. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалтгаан, нөхцөлийг тогтоох:**

Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш тухайн хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тохиромжтой цаг хугацааг зөв тогтоох нь чухал юм. Парламент хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тохиромжтой хугацааг тогтоохдоо тухайн хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Мөн Засгийн газар аль хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хэрэгцээ, шаардлага байгааг тогтооход гол үүрэгтэй оролцдог ч парламент дахь салбар Хороо, Хяналтын хороо болон парламентын ажлын алба нь хууль болон хуулийн тодорхой заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шийдвэрийг гаргаж болно.

Түүнчлэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулийг сонгохдоо иргэд, байгууллагын өргөдөл, мэдээлэл, тухайн хуулийн хэрэгжилттэй холбоотой хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ, мэдээлэл, мөн шүүхийн шүүгч тухайн хуулийг эргэн харах шаардлагатай байгаа тухай байр сууриа илэрхийлсэн байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Тухайн улсын улс төрийн тогтолцоо болон парламентын бүтэц, зохион байгуулалтаас шалтгаалан ямар тохиолдолд хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалтгаан, нөхцөлийг тогтоосон жагсаалтыг Парламентын дарга болон Хорооны шийдвэрээр, эсхүл Хорооны ажлын албаны дагаж мөрдөх баримт бичиг болгон баталж болно.

### **Алхам 3. Хүний нөөцийг бүрдүүлэх:**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардагдах санхүү болон хүний нөөцийг бүрдүүлэх янз бүрийн арга хэлбэрүүд байдаг. Тухайлбал, Парламентын ажлын албанд тухайн хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг өгч болдог. Хэрэв Хяналтын хороо байгуулагдсан бол тухайн хорооны ажлын алба үнэлгээний ажлыг хариуцдаг.

Зарим тохиолдолд хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэгтэй Парламентын ажлын албаны тусдаа нэгж байдаг бөгөөд энэ тохиолдолд Хороодын ажлын албатай нягт холбоотой ажиллах нь чухал байдаг. Хэрэв парламентаас хяналт шинжилгээ, үнэлгээг бие даасан хөндлөнгийн судалгааны

байгууллага болон шинжээчдээр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн бол Парламентын ажлын алба нь шаардлагатай тохиолдолд зөвлөгөө өгөхөөс өөрөөр тухайн үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцохгүй.

Дээрх арга хэлбэрүүд нь тухайн парламентын соёл, дэгийн хууль, Хороодын чадавх, сонирхол, хүний нөөцийн туршлага, хүрэлцээнээс шалтгаалдаг. Мөн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүний нөөцийг аль ч хэлбэрээр бүдүүлснээс үл харгалзан хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх бүхий л ажлыг хариуцан гүйцэтгэж тайлан болон зөвлөмжийг боловсруулах нийтлэг үүргийг хүлээдэг.

Үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүн нь судалгааны болон харилцааны ур чадвартай байх, өөр өөр салбараар мэргэшсэн, мөн аль болох олон ур чадвар эзэмшсэн байх нь чанартай үнэлгээний баг бүрдүүлэхэд нөлөөлдөг. Мөн үнэлгээний багийн гишүүдийн ур чадвар, туршлагаас шалтгаалан үнэлгээний ажлыг хуваарилах нь үр дүнтэй байдаг.

#### **Алхам 4. Бусад санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх:**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг үр дүнтэй болгоход нэмэлт санхүүжилт шаардлагатай байдаг. Тухайлбал, парламентаас нийтийн сонсгол зохион байгуулах, орон нутагт ажиллах, хөндлөнгийн шинжээчдийг оролцуулах, бусад мэдээлэл цуглуулах зэрэгт нэмэлт санхүүжилт зайлшгүй шаардлагатай байдаг.

Парламентаас хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг эхлүүлэхээс өмнө тухайн үнэлгээг хэдэн үе шаттай, ямар хэлбэрээр, хэдий хугацаанд хэчнээн төсөвт өртгөөр гүйцэтгэх вэ гэсэн боломжит нөөцөд үндэслэн үнэлгээний төсвийн төлөвлөгөөг зөвшилцөн тохиролцох нь оновчтой байдаг бөгөөд энэ нь үнэлгээний үр дүнд нөлөөлдөг. Төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа хүний нөөц, орон нутагт ажиллах зардал, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах зардал, гэрчүүдийн зардал, харилцаа холбооны зардал зэргийг тусгадаг.

Мөн Хороо эсхүл үнэлгээний баг нь үнэлгээ хийх хүний нөөц болон материаллаг нөөцөд тулгуурлан хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах ёстой байдаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн хуулийн хэрэгжилттэй холбоотой төрийн байгууллагын судалгааны тайлан, статистик мэдээ, олон улсын байгууллагуудаас гаргасан судалгааны тайлан, эрдэмтэн судлаач, судалгааны төвүүдийн гаргасан санал асуулга зэрэг материалыг үндэслэн тухайн хуулийн хэрэгжилттэй холбоотой аль хэсэгт анхаарал хандуулах вэ гэдгээ шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийг батлахдаа өндөр өртөгтэй зөвлөх үйлчилгээ, томоохон хэмжээний санал асуулга, судалгаа, орон нутагт ажиллах зардал зэргийг сайн судалсны үндсэн дээр боловсруулах нь зүйтэй байдаг. Учир нь өндөр өртөгтэй эдгээр ажлуудаас болж үнэлгээний зардал нэмэгдэх, үнэлгээний ажил удаашрах эрсдэлтэй байдаг.


Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ гаднаас санхүүжилт авч болдог. Тухайлбал, олон талт хөгжлийн банкнууд, хөгжлийн хамтын ажиллагааны агентлагууд, төрийн бус байгууллагууд, буяны сангууд эсхүл хувийн хэвшлийн компаниуд, судалгааны байгууллагуудаас санхүүжилт авч болдог. Гэхдээ Парламент үнэлгээний санхүүжилтийг бүхэлд нь хариуцах нь хамгийн тохиромжтой хувилбар байдаг.

#### **2.Төлөвлөлтийн үе шат**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг төлөвлөхдөө дараах асуудлуудыг авч үздэг. Үүнд:

- Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулийг сонгох;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан нийтийн сонсгол явуулах зорилгыг тодорхойлох;
- Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүргийг тодорхойлж, хяналт тавих;
- Оролцогч талуудыг тодорхойлох;
- Суурь мэдээлэл болон шаардлагатай мэдээллийг цуглуулах;
- Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хугацааг тогтоох.

Зураг 2. Төлөвлөлтийн үе шат



#### **Алхам 5. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулийг сонгох:**

Зарчмын хувьд бүх хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж болох боловч тийм нөөц боломж болон хэрэгцээ шаардлага байдаггүй. Практикт хуулийг сонгохдоо тухайн хуулийн цар хүрээ, нарийн төвөгтэй байдал, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардагдах цаг хугацаа, гарах зардал, үүссэн хүндрэл бэрхшээлтэй асуудлууд, стратегийн болон бодлогын зорилт, хуулийг хэрэгжүүлэх явцад шинэ эрсдэл, аюул заналхийлэл үүссэн байдал гэх зэрэг хэд хэдэн шалгуур үзүүлэлтэд үндэслэн сонгодог.

Ихэвчлэн хууль батлагдсанаас хойш дор хаяж гурван жилийн дараа хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг эхлүүлэхийг зөвлөдөг бөгөөд тухайн хууль нь хангалттай хэмжээний үр нөлөөг бий болгосон үед л хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээг тодорхойлохдоо:

- Хуульд бүхэлд нь;
- Хуулийн тодорхой хэсэг, заалтад;
- Тодорхой асуудлыг зохицуулсан холбогдох хуулиудын хэсэг, заалтад;
- Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам.

Хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээг тодорхойлохдоо УИХ, Засгийн газрын тэргүүлэх чиглэл, стратегийн зорилго, зорилт, үнэлгээний зардал болон нарийн төвөгтэй байдал, хууль, эрх зүй, улс төр, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө зэргээс хамаарна. Ер нь иргэд, хүн ам, бизнест (улс төр, эдийн засаг, нийгмийн) нөлөөллийг бий болгож буй хуулийн бүх зүйл заалтыг үнэлж дүгнэх ёстой.

Хууль эрх зүй, улс төр, нийгэм, эдийн засгийн үр дагавар нь хуримтлагдаж, хэд хэдэн хууль эсхүл дагалдан гарсан хуулийг нэгэн зэрэг хэрэгжүүлсний үр дүнд бий болдог гэдгийг анхаарах нь чухал юм. Тиймээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хуулиудыг сонгохдоо хуулийн хуримтлагдсан үр дүнг анхаарч үзэх хэрэгтэй. Тухайлбал, зарим тохиолдолд Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхгүйгээр үнэлэх боломжгүй байх гэх мэт.

Ажлын алба нь хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх “project outline”-ыг бэлтгэх бөгөөд уг тоймд нөхцөл байдлын дүн шинжилгээ, хяналт шинжилгээ үнэлгээ хийх хуулийн санал, хамрах хүрээ болон зорилго зэргийг багтаасан 3-5 хуудас товч мэдээлэл байна. Саналыг холбогдох хорооны даргатай зөвшилцөж, эцэслэн баталдаг.

**Алхам 6. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан нийтийн сонсгол явуулах зорилгыг тодорхойлох:**

Зарчмын хувьд хяналт шинжилгээ, үнэлгээ нь батлагдсан хууль болон түүний үр нөлөөг аль алиныг нь хянах асуудлыг авч үздэг. Өргөн утгаараа хуулийн үр нөлөө, уг хуулийн бодлогын зорилго биелсэн эсэх, хэр үр дүнтэй байгааг судална.

Тиймээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ дараах асуудлуудыг юун түрүүнд шалгах ёстой. Үүнд:

- хуулийн үр нөлөө (эрх зүй, улс төр, нийгэм, эдийн засагт гэх мэт);
- анхдагч болон дагалдан гарсан хуулийг үр ашигтайгаар хэрэгжүүлж байгаа эсэх;
- хуулийн зорилгыг хангасан эсэх;
- хүлээгдэж буй үр дүн, зардал, үр ашгийг зөв тооцсон эсэх;
- урьдчилан тооцоолоогүй үр дагавар гарсан эсэх (эдийн засгийн, нийгмийн гэх мэт);
- хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл гарсан эсэх;
- оролцогч талууд болон ашиг хүртэгчид сайн мэддэг эсэх;
- шүүхэд гомдол гарч байгаа эсэх;
- жендэрийн тэгш бус байдалд нөлөөлсөн эсэх;
- хэрэгцээ шаардлага хэвээр байгаа эсэх.

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд нийтийн сонсгол зохион байгуулах нь ашигтай юу, энэ тохиолдолд нийтийн сонсголын зорилгыг сайтар тодорхойлох шаардлагатай болдог. Нийтийн сонсгол зохион байгуулахын тулд нийтийн сонсголыг хийхэд зарцуулах цаг хугацаа, хүн хүч, нөөц боломжоо эхний ээлжинд тодорхойлох шаардлагатай.

Нийтийн сонсголын зорилго нь хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох мэргэжилтэн, оролцогч талууд, олон нийтийн төлөөллөөс мэдээлэл, санал, зөвлөмж авах зорилготой байж болно. Өөрөөр хэлбэл, хуулийн хэрэгжилтэд хийж буй хяналт шинжилгээний талаар олон нийтэд мэдээлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой. Иймээс Хороо нь хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд нийтийн сонсгол зохион байгуулах үндсэн зорилгоо тодорхойлох ёстой. Нийтийн сонсголын зорилгыг тодорхой болгосноор Хороо олон нийтийн хүлээлтийг илүү үр дүнтэйгээр удирдах боломжтой юм.

Нийтийн сонсголын зорилго нь тодорхой хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл, санал, зөвлөмж авах зорилготой бол нийтийн сонсгол явуулахыг санал болгож буй парламентын гишүүд ямар мэдээлэл авахыг хүсэж байгаагаа, ямар хэлбэрээр нээлттэй сонсгол хийх талаар тодорхой тайлбар өгөх ёстой. Энэ нь мэдээллийг олж авах ашигтай механизм юм.

### **Алхам 7. Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүргийг тодорхойлж, хяналт тавих:**

“Бид сайн хуультай ч хэрэгжилт нь муу байна” гэж хэлэх тохиолдол олон байдаг нь хоорондоо зөрчилдөж байгаа бөгөөд өөрөө үр дүнтэй хэрэгжих боломжгүй хууль байдаг.

Хяналт шинжилгээ, үнэлгээний нэг чухал алхам бол хэрэгжүүлэгч байгууллагын тухай хуулийн заалтуудыг үнэлэх асуудал юм. Хэрэгжүүлэгч байгууллага ерөнхийдөө хуулийг хэрэгжүүлэх, зохицуулах, маргааныг шийдвэрлэх, албан тушаалтнуудын хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих гэсэн асуудлуудыг хариуцдаг.

Хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэх үүрэг, гүйцэтгэлийг үнэлэхдээ тусдаа шалгуур бүхий шалгах хуудсыг ашиглан үнэлж, хяналт шинжилгээ, үнэлгээг хийлгэж буй хороонд танилцуулах боломжтой байдаг.

### **Алхам 8. Оролцогч талуудыг тодорхойлох:**

Оролцогч талуудад тухайн хуулийн харилцаанд оролцож байгаа талууд өөрөөр хэлбэл нөлөөлөлд өртсөн болон хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх боломжтой бүх хүмүүс байж болно. Энэ хүрээнд дараах асуултуудыг үнэлж болно. Үүнд:

- Нийгмийн ямар бүлгүүд өртөж байна вэ?
- Эдгээр бүлгүүд хэр том вэ?
- Бүлэг тус бүрт ямар үр нөлөөг үзүүлж байна вэ?
- Хэр чухал нөлөө үзүүлж байна вэ?
- Эдгээр нөлөөлөл ямар хугацаанд үргэлжлэх вэ?

Оролцогч талуудад хуулийн хэрэгжилтийн талаар санал өгөх боломжтой мэргэжилтэн, шинжээч, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн хүмүүс, оролцогч талуудын төлөөлөл болон мэргэжлийн байгууллага, хувь хүмүүс, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажилд хувь нэмрээ оруулах боломжтой аливаа этгээд багтаж болно. Хороо оролцогч талуудын оруулах хувь нэмрийг нягталж сонгох бөгөөд оролцогч талуудын жагсаалтыг баталдаг байна. Мөн гэрчүүдийн жагсаалтыг бусад намуудын төлөөлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр хорооны дарга батална. Мөн сонсгол, хэлэлцүүлэгт оролцогч талууд, гэрчүүдийг сонгохдоо цөөнхийн бүлгийн саналыг тусгах нь чухал юм. Гэрчүүдийг сонгохдоо жендэрийн байдлыг анхаарч, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг аль болох тэнцвэртэй байлгах нь үзэл бодлоо илэрхийлэх, гарах дүгнэлтэд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг талтай. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад жендэрийн тэгш байдлыг ханган ажиллах нь чухал.

### **Алхам 9. Суурь мэдээлэл болон шаардлагатай мэдээллийг цуглуулах:**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд анхдагч болон хоёрдогч мэдээллийг ашигладаг. Найдвартай, баталгаатай тохиолдолд хоёрдогч мэдээллийг ашиглах нь шинээр мэдээлэл цуглуулахаас цаг хугацаа бага шаарддаг.

Мөн мэдээлэл цуглуулах нь цаг хугацаа их шаарддаг тул хоёрдогч эх сурвалжийг бүрэн ашиглаж дууссаны дараа анхдагч мэдээлэл цуглуулахыг зөвлөдөг байна. Чанарын мэдээллийг дараах эх сурвалжийн хүрээнд ашиглаж болно. Үүнд:

- Статистик мэдээ
- Судалгааны тайлан
- Санал асуулгын дүн
- төрийн байгууллагуудаас нийтэлсэн албан ёсны тайлан;
- нутгийн захиргааны байгууллагын тайлан

- ТББ-ын тайлан
- Иргэний нийгмийн байгууллагын тайлан
- ОУ-ын байгууллагуудын илтгэл, тайлан, судалгаа, дүгнэлт

Парламент дараах байдлаар мэдээллийг цуглуулах бүрэн боломжтой юм.  
Жишээ нь:

- оролцогч талуудтай хийсэн ярилцлага;
- фокус бүлэг эсвэл семинар;
- ажиглалт;
- зохион байгуулсан хэлэлцүүлэг, зөвлөгөөн;
- тоон судалгаа гэх мэт.

### **Алхам 10. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хугацааг тогтоох:**


Хяналт шинжилгээ, үнэлгээний үргэлжлэх хугацаа нь үнэлгээний хэмжээ, хамрах хүрээ, нарийн төвөгтэй байдал, ажлын төлөвлөгөө, нөөц боломж, шинжээчдийн чанар зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч янз бүр байх бөгөөд тохиромжтой хугацаа 3-6 сар байна.

#### **3.Хэрэгжүүлэх үе шат**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хэрэгжүүлэхэд дараах асуудлыг авч үздэг. Үүнд:

- Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх оролцогч талуудын зөвлөгөөн;
- Эрх шилжүүлсэн хуулийн үр нөлөөг хянах олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнд дүн шинжилгээ хийх;
- Тайлан боловсруулах.

*Зураг 3. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тойм*



### **Алхам 11. Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх оролцогч талуудын зөвлөгөөн:**


Оролцогч талуудтай зөвлөлдөх нь хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үе шатны гол хэсэг юм. Зөвлөгөөн нь парламентын гишүүдэд хуулийн хэрэгжилтийн болон Засгийн газрын ажлыг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход тусалдаг. Мөн оролцогч талуудын зөвлөгөөнөөр тухайн хууль болон холбогдох бодлогод олон нийтийн зүгээс үзүүлэх дэмжлэг ямар байгаа талаар парламентын гишүүд болон парламентад мэдээлэл өгдөг.

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ сонирхогч талууд болон хэрэгжүүлэгч агентлагуудтай зөвлөлдөх, мэдээлэл цуглуулах олон арга зам байдаг. Тухайлбал, нийтийн сонсгол, аман мэдүүлэг, уулзалт зохион байгуулах болон бичгэн

нотлох баримт цуглуулах гэх мэт аргууд байдаг. Парламент эдгээр арга хэлбэрээс аль нэгийг эсхүл хослуулан хэрэглэж болно.

Олон нийтийн сонсгол нь оролцогч талуудтай зөвлөлдөх нэг хэлбэр бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд, гэрлэлт зэрэг онцгой, эмзэг асуудлыг судлахдаа парламентын алба болон парламентын гишүүд, гэрч, сонирхогч талуудын нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний нэр төрийг хамгаалахад анхаарах ёстой. Оролцогч талуудтай харилцах харилцааг дөрвөн ерөнхий зарчмаар зохицуулдаг.

Зураг 4. Оролцогч талуудын зөвлөгөөний ерөнхий зарчим, стандарт



Хяналт шинжилгээ, үнэлгээний оролцогч талуудын хэлэлцүүлгийн үр дүн нь түүнд оролцож буй хүмүүсийн оролцоо, оруулсан хувь нэмрээс ихээхэн шалтгаална. Олон нийтийн хэлэлцүүлэгт ирсэн хүмүүс Хорооны гишүүдэд урьдчилан бичгээр нотлох баримт өгөх шаардлагатай байдаг ч зайлшгүй нөхцөлд (гамшигийн үе болон хүчирхийлэлд өртсөн хохирогчдын саналыг авах) өөр арга хэмжээ авах боломжтой.

Уулзалтын үеэр тухайн хүн мэдэгдэл хийж, түүний бичгээр ирүүлсэн нотлох баримтын талаар товч танилцуулга хийдэг. Дараа нь тухайн хүн өөр гэрч мэдүүлэг өгөхөөс өмнө хорооны гишүүдийн тавьсан асуултад хариулна. Хэлэлцүүлгийн өмнө мэдүүлгийн хэлбэр болон дарааллыг Хороо шийдвэрлэнэ.

Эрдэмтэн судлаачид, боловсролын байгууллага, аж үйлдвэр, төрийн бус байгууллага болон бусад иргэдийн мэдүүлгийн дарааллыг тогтоохдоо мэдээллийг логиктой, тууштай, дэвшилтэт байдлаар шийдвэрлэнэ. Жишээлбэл, Хороо нэг хүн нөгөө хүний мэдүүлгийг эсэргүүцэж, дэмжиж болохоор дарааллыг тогтоож болно. Яамны ажилтнуудад болон оролцогчдод урьдчилан урилга илгээдэг. Шаардлагатай бол урилгыг 5 хоногийн өмнө илгээх ёстой.

**Бичгэн нотлох баримт:** Бичгэн нотлох баримтыг 10 хоногийн өмнө ирүүлэх ёстой бөгөөд энэ нь тухайн хүн мэдүүлэг өгөхөөс өмнө Хорооны бүх гишүүд баримт бичгийг шалгаж, уншиж танилцах боломжийг олгодог. Хороо мэдүүлэг өгөх хүнийг урихдаа бичгээр мэдүүлэг өгөх эсэхийг тодруулдаг. Бичгэн нотлох баримтыг ямар форматаар авах ёстой талаар тухайлсан дүрэм байдаггүй. Бичгэн нотлох баримт нь дараах зүйлийг агуулсан байх ёстой. Үүнд:

- мэдүүлэг өгөх хүний нэр болон байгууллагын нэр, хаяг;
- тухайн хүн, байгууллагын тухай товч танилцуулга, мэргэжлийн чиглэлийг тусгасан байх;
- дүгнэлт гаргах болон хариу арга хэмжээ авах боломжтой мэдээлэл байх.

Бичгэн нотлох баримт нь Засгийн газраас авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг тусгасан байвал илүү ач холбогдолтой байдаг. Хэрэв бичгэн нотлох баримт нь маш товч бол түүнийг захидал хэлбэрээр илгээж болох боловч бусад тохиолдолд нотлох баримт хэлбэрээр байх нь ашигтай байдаг. Хэрэв тухайн бичиг

нь маш урт бол гол санааг агуулсан нэг хуудас хураангуй, шаардлагатай бол агуулгын хүснэгттэй байх ёстой.

Бичгэн нотлох баримтаас гадна оролцогч нь өөрт хэрэгтэй гэж үзсэн нэмэлт мэдээллийг авчрах ёстой. Тухайлбал: Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл, хэлэлцэж буй сэдвийн талаарх мэдээллийн бусад эх сурвалж, тэдний тавьж буй илтгэлүүдийн хуулбар гэх мэт. Боломжтой бол тухайн мэдээллийг урьдчилан ирүүлэх эсхүл Хорооны нарийн бичгийн даргад хуулбарыг өгнө. Хэрэв оролцогч цахим танилцуулга хийх бол Хорооноос шаардлагатай техникийн нөхцөлийг хангаж, урилгад танилцуулга хийх боломжтой тоног төхөөрөмжийг талаар дэлгэрэнгүй бичиж илгээнэ.

Аман нотлох баримт: Гэрчийн нэр, тэдгээрийн ажил мэргэжлийн талаар товч танилцуулах бөгөөд цаг хэмнэхийн тулд гэрч мэдүүлгээ бүхэлд нь унших шаардлагагүй байдаг. Нээлтийн мэдэгдлийн ердийн үргэлжлэх хугацаа таваас арван минут байна. Зарим тохиолдолд дарга үргэлжлэх хугацааг хязгаарлаж болно. Шаардлагатай бол энэ хугацааг сунгаж болно. Хорооноос амаар мэдүүлэг авах хугацаа хязгаарлагдмал тул бүх гэрч, тэр дундаа Хорооноос амаар мэдүүлэг өгөхийг урьсан хүмүүсийг ч бичгээр мэдүүлэг өгөхийг зөвлөдөг байна.

Гэрчээс асуулт асуух: Асуулт, хариултын цаг нь гэрч үгээ хэлж дууссаны дараа эхэлнэ. Хорооны гишүүд энэ цагийг ашиглан Хорооны үйл ажиллагаа, шийдвэрийг дэмжих асуулт асууж, нэмэлт мэдээлэл авдаг.

Хорооны гишүүд гэрч бүрээс асуулт асуух боломжтой байх ёстой. Асуултын дарааллыг парламентад суудалтай намаас хамаарч эсвэл даргын үзэмжээр тогтоож болно. Зарим улс оронд уг хэлэлцүүлгийг зохион байгуулах хорооны гишүүн биш боловч энэ асуудлыг сонирхож буй эсвэл эрх бүхий парламентын гишүүнийг гэрчээс асуулт асуухыг зөвшөөрдөг.

Хорооноос тавьсан асуултад хариулахын тулд ямар нэгэн судалгаа хийх, мэдээлэл цуглуулах шаардлагатай үед хороод гэрчүүдэд урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв тухайн хүнд асуултад хариулах мэдээлэл байхгүй бол дараа нь бичгээр ирүүлэхийг хүсэж болно.

### **Алхам 12. Эрх шилжүүлсэн хуулийн үр нөлөөг хянах:**

Парламентаас баталсан хуулиар гүйцэтгэх эрх мэдлийн сайдад хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох дүрэм, журам батлан гаргах эрхийг олгодог. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан дүрэм, журмыг олон нийтэд сайн сурталчилдаггүйгээс гадна тэдгээр дүрэм, журмын хэрэгжилтэд парламентын зүгээс тавих хяналт сул байдаг.

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь хууль болон холбогдох дүрэм, журамд зохицуулсан асуудлуудын хоорондын нийцэл, улмаар хууль санаачлагчдын тодорхойлсон асуудал болон шийдвэрлээгүй үлдээсэн асуудлуудын хооронд зөв тэнцвэр байгаа эсэхэд дүгнэлт хийдэг.

Иймд хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан дүрэм, журмуудын хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ нь:

- Тухайн хуульд холбогдох дүрэм, журам гаргахыг заасан эсэх;
- Холбогдох дүрэм, журам нь хууль зүйн зарчимд хэр нийцэж байгаа вэ гэсэн хоёр асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй.

### **Алхам 13. Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах:**

Хууль болон олон нийтийн сонирхлыг татсан асуудлаар олон нийтийг хамарсан өргөн хүрээтэй хэлэлцүүлэг хийж болно.

Хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг урих: Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтыг зарим тохиолдолд тодорхой шалтгааны улмаас олон нийтэд хаалттай эсхүл хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулж болно. Жишээ нь үндэсний аюулгүй байдал болон хувь хүний нууцад нөлөөлж болзошгүй тохиолдолд хаалттай хийнэ. Хороо нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг урихаас гадна бүрэн хэмжээний мэдээллийн кампанит ажил зохион байгуулах шийдвэр гаргаж болно.

Парламентын цахим хуудсан дахь хэлэлцүүлэг: Парламентын хороо нь олон нийтийн сонсголын хүрээнд интернэт сүлжээг янз бүрийн аргаар ашигладаг. Үүнд:

- интернэт нь уулзалтад оролцох хүсэлтэй хүмүүсийг бүртгэх үр дүнтэй хэрэгсэл болдог;
- түүнчлэн парламентын гишүүд, хорооны даргаар дамжуулан олон нийтийн зүгээс гэрчүүдэд тавих асуултыг твиттер, цахим шуудангаар санал болгох боломжтой;
- парламент нь цахи хуудас ашиглан хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг нийтлэх, мөн хяналт шалгалтын явцын талаар мэдээлэх боломжтой.

### **Алхам 14. Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнд дүн шинжилгээ хийх:**

Дүгнэлт гаргахын тулд хорооны ажлын алба мэдээлэлд дүн шинжилгээ хийж, юу ажиллаж байна, юу нь болохгүй байна вэ гэх мэт өргөн асуултуудыг тавих ёстой. Өөрчлөлтийг бий болгох албан болон албан бус эрх мэдэл хэнд байдаг вэ? Өөрчлөлтийг бий болгох эсвэл урьдчилан сэргийлэхийн тулд хэн хэнтэй хамтран ажиллаж чадах вэ? Эдгээр асуултууд нь сэдвийн ерөнхий дүн шинжилгээ хийхэд ашиглаж болно.

Хорооны ажлын алба нь мэдээллийн бүтцэд үндэслэн асуудлын шалтгааныг тайлбарлах SWOT шинжилгээ (Давуу, Сул тал, Боломж, Аюул занал) хийж болно.

Мөн Хорооны ажлын алба нь тухайн хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн яаралтай шийдвэрлэх асуудал, хуулийн хэрэгжилтийг хангах боломжит нөхцөл, хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл, түүнчлэн тухайн дүгнэлт, зөвлөмжийг Засгийн газрын аль түвшинд хүргэхээр зорьж буйгаас шалтгаалан дүгнэлт, зөвлөмжөө боловсруулах нь зүйтэй юм.

### **Алхам 15. Тайлан боловсруулах:**

Тайланд үндсэн мэдээллийн хураангуйгаас гадна парламентын гишүүд, гэрчүүдийн хооронд зохион байгуулсан хэлэлцүүлгийн танилцуулга, дүгнэлт, зөвлөмж зэргийг багтаана.

Дүгнэлт, зөвлөмжийг агуулсан хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн эцсийн хувилбарыг Хороо бэлтгэнэ. Хороо тайланд дараах баримт бичгийг хавсаргана. Хавсаргах баримт бичигт гэрчийн бичгээр өгсөн мэдүүлэг, судалгааны дүгнэлт, уулзалтад оролцох боломжгүй хүмүүсийн бичгэн мэдүүлэг, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад Хорооны гишүүдийн асуусан асуултад хариулсан хариулт зэргийг багтааж болно.

### **4. Үнэлгээний тайланг хэлэлцэх, үр дүнг үнэлэх үе шат**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дууссаны дараах үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

- Тайланг олон нийтийн хүртээл болгох;
- Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээнд үндэслэн бодлогын мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- Хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх.

**Алхам 16. Тайланг олон нийтийн хүртээл болгох:**

Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг олон нийтэд хүргэх бөгөөд тайланг парламентын цахим хаягт байршуулах, Хорооны санаачилгаар хэвлэн нийтлэх боломжтой. Мөн тодорхой тохиолдолд олон нийтийн анхаарлыг татах зорилгоор хэвлэлийн бага хурал зарлаж болно.

Хэрэв хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт зарим бичмэл нотлох баримтыг нийтлэх бол энэ талаар гэрчид мэдэгдэн, Хорооноос зөвшөөрөл авч нийтэлнэ. Түүнчлэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн хуулбарыг яам, агентлагууд, сонирхлын бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, мэргэшсэн сэтгүүлчид, олон улсын байгууллага болон хэлэлцэж буй сэдэвтэй хамаарал бүхий бусад байгууллагуудад хүргүүлж болно. Энэ нь олон нийтийг мэдээллээр хангахаас гадна парламентын үйл ажиллагааг сурталчлах ач холбогдолтой юм.

Мөн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан болон дүгнэлтийн талаар товч мэдээлэл бэлтгэн парламентын цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн байгууллагуудад хүргүүлнэ.

**Алхам 17. Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээнд үндэслэн бодлогын мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

Хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг олон нийтийн хүртээл болгосноор үнэлгээний ажил дуусахгүй бөгөөд үнэлгээний ажлын дараах хяналтын механизм чухал юм. Үнэлгээний ажлын дараах хяналтын механизмд дараах арга хэрэгслүүд орно. Үүнд:

- Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан болон зөвлөмжтэй холбогдуулан Засгийн газраас хариу мэдээлэл авах;
- Парламентын нэгдсэн хуралдааны үеэр парламентын дарга болон гишүүд үнэлгээний үр дүнг ашиглах;
- Үнэлгээний тайланг парламентын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх;
- Үнэлгээний тайланг бүхэлд нь хэлэлцэхгүйгээр тухайн тайлангаас санал нэгдэж байгаа болон санал зөрөлдөж байгаа хэсэг, эсхүл зөвхөн тайланд тусгагдсан үнэлгээний зөвлөмжийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх.

**Алхам 18. Хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх:**

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа дууссаны дараа Хороо нь тухайн үнэлгээний үйл ажиллагаа болон үр дүнг үнэлэх шаардлагатай байдаг. Гэхдээ үнэлгээ хийснээс хойш 9-12 сарын дараа энэхүү үйл ажиллагааг явуулах нь тохиромжтой юм. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Хороо нь үнэлгээний тайланд үндэслэн гаргасан зөвлөмжийн дагуу ямар ахиц дэвшил гарсан бэ гэдгийг хянан үзэх бөгөөд үүний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санаачилга гаргаж болно. Мөн үнэлгээний хийх үйл ажиллагаа нь цаг хугацаа, хүний нөөц, санхүүгийн нөөц болон хамаарал бүхий талуудын оролцоо хангагдсан эсэхийг авч үздэг. Түүнчлэн парламентаас хэрэгжүүлж буй хуулийн хэрэгжилтэд хяналт

шинжилгээ, үнэлгээ хийх эрх зүйн орчин болон процессын тогтолцоонд үнэлгээ хийнэ.

## **ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ АРГАЧЛАЛ /Ази-Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын туршлага/<sup>11</sup>**

Энэхүү аргачлал нь хяналт шинжилгээ, үнэлгээний системийн шинэчлэлийг 2009 онд хийж анхны баримт бичгийг бэлтгэснээс хойш нэвтрүүлсэн хяналт шинжилгээ, үнэлгээний шинэ нийтлэг журам, аргачлал юм. НҮБ-ын бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах энэхүү баримт бичигт тусгагдсан ҮНЭЛГЭЭНИЙ БОДЛОГО буюу үнэлгээ хийхэд ашиглагддаг арга, аргачлалын талаар энэ хэсэгт судаллаа.

**Үнэлгээний төрөл:** Үнэлгээний үйл явцыг хэн удирдаж байгаагаас хамааран гадаад болон дотоод үнэлгээ гэж хоёр үндсэн ангилалд хувааж авч үздэг.

Гадаад үнэлгээг ихэвчлэн засаглалын түвшинд хяналт тавих, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглаж байгаа бол дотоод үнэлгээг ESCAP-ээс удирдаж, хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээчид гүйцэтгэдэг байна. Дотоод үнэлгээг дотор нь Засгийн газар хоорондын, сэдэвчилсэн, дэд хөтөлбөр, төслийн гэж ангилдаг байна.

**Үнэлгээний удирдамж:** Үнэлгээний удирдамж нь үнэлгээг гүйцэтгэх үе шатны ажиллавуудыг нарийвчлан тайлбарладаг. Үнэлгээг бэлтгэх, гүйцэтгэх, үр дүнг ашиглах гэсэн гурван үе шаттайгаар хийдэг.

*Хүснэгт 3. Үнэлгээний үйл явцын үе шатууд*

<b>Бэлтгэх</b>	<b>Гүйцэтгэх</b>	<b>Үр дүнг ашиглах</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээ хийх чадварыг үнэлэх;</li> <li>• Оролцогчдын дүн шинжилгээ хийх;</li> <li>• Зорилго болон гол асуултыг тодорхойлох;</li> <li>• Шалгуур үзүүлэлтийг сонгох;</li> <li>• Аргачлалыг загварчлах;</li> <li>• Зөвлөх бүлэг байгуулах;</li> <li>• Үнэлгээний багийг сонгох;</li> <li>• Ажлын удирдамж бэлтгэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний ажлын төлөвлөгөө хийх;</li> <li>• Багийн танилцуулга бэлтгэх;</li> <li>• Баримт бичиг цуглуулах;</li> <li>• Эхлэлийн тайланг бэлтгэх;</li> <li>• Мэдээлэл цуглуулах;</li> <li>• Тайлангийн төслийн чанарын шалгалт хийх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Урьдчилсан дүгнэлтийг танилцуулах;</li> <li>• Удирдлагын хариу арга хэмжээ болон дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх;</li> <li>• Дүгнэлтийг тараах;</li> <li>• Хэрэгжилтийг хянах.</li> </ul>

**Үнэлгээнд бэлтгэх:** Бүх хөтөлбөр, төслүүдийг эхнээс нь сайн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэхээр нарийвчлан төлөвлөх шаардлагатай байдаг. Үнэлгээний менежерүүд үнэлгээнд хөндлөнгийн оролцоог хангах, хөндлөнгийн оролцоо нь тодорхой зорилготой байх, баталгаат мэдээллийг цуглуулах, жендэр болон хүний эрхийг голчлох, үнэлгээний явцад ямар нэгэн хүчин зүйл саад учруулахгүй байх зэрэг үнэлгээний анхан шатны алхмыг хангасан байна.

Үнэлгээний зорилго нь шийдвэр гаргахад найдвартай, баталгаатай, хэрэгцээт мэдээллээр цаг алдалгүй хангаж үндэслэлтэй зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

**Оролцогч талуудын дүн шинжилгээ хийх:** Үнэлгээний менежерүүд хариуцлага, үнэлгээний үр ашгийг дээшлүүлэхийн тулд оролцогч талуудын дүн

<sup>11</sup> Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын /цаашид ESCAP гэх/ хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал - ESCAP Monitoring and Evaluation Policy and Guidelines 2017

шинжилгээг хийх ёстой. Үнэлгээнд оролцох оролцогч талуудыг сонгох нь үнэлгээний зорилгоос хамаарна.

Хүснэгт 4. Оролцогч талуудын матриц

Хөдлөнгийн зорилтот бүлэг	Үнэлгээний хэрэглэгч
<b>Анхан шатны</b> <ul style="list-style-type: none"> <li>Засгийн газрын түнш</li> <li>Иргэний нийгмийн байгууллага</li> <li>Засгийн газрын бус байгууллага</li> <li>Академи</li> </ul>	<b>Анхан шатны</b> <ul style="list-style-type: none"> <li>ESCAP удирдлага, ажилтнууд</li> <li>Засгийн газрын түнш</li> </ul>
<b>Хоёрдогч</b> <ul style="list-style-type: none"> <li>Төрийн албан хаагч</li> <li>Салбарын мэргэжилтнүүд</li> </ul>	<b>Хоёрдогч</b> <ul style="list-style-type: none"> <li>Хамтран ажилладаг хандивлагчид</li> <li>Хамтран ажилладаг ТББ-ууд</li> <li>НҮБ-ын бусад байгууллага</li> <li>Бусад ТББ</li> <li>Академи болон үнэлгээний мэргэжилтнүүд</li> </ul>

**Зорилго тодорхойлох:** Үнэлгээ хийгдэж буй шалтгаан, зорилтот хэрэглэгчид, ашиглах зорилго – үнэлгээний загвар болон хийгдэх үйл ажиллагааг тодорхойлж, эцэст нь үнэлгээний үр ашгийг тодорхойлох гэсэн үйл ажиллагаа байна.

Үнэлгээний зорилгыг тодорхойлох гэдэг нь дараах асуултад хариулахад чиглэгдэнэ. Үүнд:

- Үнэлгээг яагаад хийх болов? Үнэлгээ хийхэд юу нөлөөлөв? Үнэлгээ хийх тодорхой шалтгаан байгаа эсэх?
- Хэнд зориулж үнэлгээ хийж байна вэ? Хандивлагчдад зориулсан уу?, Гишүүн орнуудад орнуудад зориулагдсан уу?, эсхүл ESCAP удирдлага, ажилтнуудад зориулагдсан уу?
- Үр дүнг яаж ашиглах вэ? Үр дүн нь танин мэдэх, хариуцлага тооцох эсвэл шийдвэр гаргахад зориулагдсан уу?

**Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон асуулт сонгох:** Төслийн зорилго, хүрсэн үр дүнг үнэлэх стандарт шалгуур үзүүлэлт болох үр дүнтэй байх, хамааралтай байх, үр ашигтай байдал, тогтвортой байдал, жөндөр, хүний эрхийг голчлон авч үзэж байна. Үнэлгээний зорилго болон шалгуур үзүүлэлтийг тогтоосны дараа үнэлгээний менежер гол асуултуудыг боловсруулж болно.

Үнэлгээнд хамаарал бүхий шалгууруудыг ашиглахдаа үнэлгээний ажлын удирдамжид аль нь нэн тэргүүнд тавигдах вэ гэдгийг тодорхойлох ёстой. Шаардлагатай бол нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг оруулж болох бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрийн дор үнэлгээний асуултуудыг оруулна. Нарийн уялдаатай асуултуудыг боловсруулснаар нь цуглуулсан бүх мэдээлэл, өгөгдөл зорилгыг бүрэн хангах боломжийг бий болгодог.

Асуултууд нь үнэлгээний сэдэв, зорилгод тохирсон байх шаардлагатайгаас гадна үнэлгээний төсөв, хамрах хүрээнээс хамаарч шалгуур үзүүлэлт тус бүрийн шалгах асуултын тоо 3-5 байх нь тохиромжтой байдаг байна.

#### Үнэлгээний стандарт шалгуур үзүүлэлт:

*Үр дүнтэй байдал:* Төсөл, хөтөлбөр нь өөрийн зорилгодоо хүрсэн байдал, зорилтот бүлгүүдийн хувьд эерэг ба сөрөг үр дагавар бий болсон, төлөвлөсөн болон

урьдчилан тооцоолоогүй өөрчлөлт, үр дагаварт хүрсэн эсэх. Энэ нь тухайн төсөл хөтөлбөрийн хүрсэн үр дүн, үйл явц, нөхцөл байдлыг судлан үзэж, хөндлөнгийн оролцооны үр дүнг тодорхойлдог. Үйл ажиллагааны үр дүн нь хүссэн зорилго эсхүл үр дүнд хүрсэн тохиолдолд хөндлөнгийн оролцоог үр дүнтэй гэж тооцдог байна.

- Тухайн үйл ажиллагааг явуулснаар ямар үр дүнд хүрсэн бэ?
- Зорилго, үр дүнд хүрсэн эсэх, эсхүл хүрэхгүй байхад нөлөөлсөн гол хүчин зүйлүүд юу байсан бэ?
- Үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахын тулд юуг илүү сайн хийж болох байсан бэ?

*Хамааралтай байдал:* Төсөл, хөтөлбөрийн зорилго, үр дүн нь зорилтот бүлгийн тэргүүлэх чиглэл, бодлогод хэр зэрэг нийцэж байгаа буюу төслийн үр дүн зорилтот бүлэгт хүрсэн эсэхийг үнэлдэг. Мөн зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, хэрэгжилтийн уялдаа холбоог үнэлдэг.

- Ямар арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүн зорилтот бүлгийн хэрэгцээг хангаж байна?
- Зорилтот бүлгийн хэрэгцээ, шаардлагыг хэрхэн үнэлж, тодорхойлсон бэ?
- Үйл ажиллагаа, үр дүн нь төлөвлөсөн зорилго/үр дагавартай нийцэж байсан уу?
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад эрэгтэй, эмэгтэй оролцогч талууд болон нийгмийн янз бүрийн бүлгүүдийн оролцогч талуудын хэрэгцээг үнэлж үзсэн үү?

*Үр ашигтай байдал:* Үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх, зорилгодоо хүрэхийн тулд хүний нөөцийн болон санхүүгийн нөөцийг аль болох оновчтой ашигласан байх. Мөн захиргааны болон үйл ажиллагааны зардлыг хүрсэн үр дүнтэй харьцуулан үнэлдэг.

- Үр дүнд хүрэхийн тулд хүний болон санхүүгийн нөөцийг үр дүнтэй ашиглаж чадсан уу?
- Хүрсэн үр дүн нь гарсан зардлаа нөхөж чадсан уу?
- Үйл ажиллагаа бүрэн хэрэгжиж, үр дүн нь тухайн цаг хугацаанд гарсан уу?
- Бусад байгууллагатай хамтран ажилласнаар хамтын ажиллагааны үр дүнд зардал хэмнэж, хэмнэлт гаргасан уу?

*Тогтвортой байдал:* Төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр ашиг ирээдүйд үргэлжлэн хэрэгжих эсэх.

- Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн оролцоогүйгээр төсөл, хөтөлбөрийн үр дүнг цаашид хэр зэрэг үргэлжлүүлэх боломжтой вэ?
- Төсөл, хөтөлбөрийн үр дүн нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ялгаатай нөлөө үзүүлж байна уу? Ямар? Энэ нь тогтвортой байдалд ямар нөлөө үзүүлэх вэ?
- Төслийн үр дүнд бусад оролцогч талууд, НҮБ-ын түншүүд, хандивлагчид болон бусад олон талт, эсвэл үндэсний түншүүдээс ямар дэмжлэг авсан бэ?

*Жендэр ба хүний эрхийн чиг хандлага:* Жендэр ба хүний эрхийг голчлон авч үзэх нь НҮБ-ын туслалцаа, дэмжлэгтэйгээр хийгдэх судалгаа шинжилгээ, төлөвлөгөөний гол стратеги бөгөөд үнэлгээнд жендэрийн тэгш байдал, хүний эрхэд суурилсан хандлагын дагуу тусгана. Энэ шалгуур үзүүлэлт нь төсөл хөтөлбөрийн

үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд жендэр, хүний эрхийн асуудлыг хэр тусгасан байдлыг үнэлдэг.

- Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон нийгмийн бусад бүлгүүд хэрэгжүүлэгч болон оролцогч талуудын хувь оролцоо хэр байсан бэ?
- Хүйсийн болон нийгмийн шаардлагатай бусад ангиллын дагуу мэдээллийг цуглуулж ашигласан уу?
- Үйл ажиллагааг тайлагнах баримт бичигт жендэр, хүний эрхийн асуудлуудыг тогтмол мэдээлж байна вэ?
- Хөтөлбөр болон төслийн үр дүнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон нийгмийн бусад бүлгүүдэд ямар нөлөө үзүүлсэн бэ?

**Үнэлгээний аргачлалыг сонгох:** Үнэлгээ нь баримт нотолгоо, шинэ мэдээллийг бий болгоход чиглэсэн системчилсэн судалгаанаас бүрэн хамаардаг. Үнэлгээ хийхээр сонгосон аргачлал нь тоон, чанарын болон холимог байж болно. Үнэлгээний менежер нь үнэлгээний зорилго, гол асуултуудад үндэслэн цаг хугацаа, нөөц бололцоог харгалзан үзсэний үндсэн дээр үнэлгээний аргачлалаа сонгодог.

Үнэлгээний арга зүй, үнэлгээний асуултууд нь хамгийн тохиромжтой мэдээллийн төрөл, эх сурвалжийг тодорхойлоход чиглэгдэх ёстой. Ихэнх тохиолдолд чанарын болон тоон мэдээллийг хослуулан ашигладаг. Жишээлбэл, үнэлгээчид эхлээд төслийн баримт бичигтэй танилцаж, төслийн талаар өргөн ойлголттой болохын тулд төслийн ажилтнуудтай ярилцлага хийх (чанарын), санхүүгийн болон бусад мэдээллийг цуглуулах (тоон), түншүүд болон зорилтот бүлгүүдийн дунд (чанарын болон тоон) судалгаа хийх болон ярилцлага хийх гэх мэт аргачиллыг ашиглаж болно.

Мэдээлэл цуглуулах аргыг сонгохдоо дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

- Төрөл бүрийн аргыг ашиглах нь хөндлөнгийн оролцооны үр дүнг ойлгоход тусалдаг.
- Тоон болон чанарын өгөгдлийн шинжилгээ нь учир шалтгааны холбоо тогтоох боломж олгодог.
- Ямар цаг хугацаа, нөөц боломж байна?
- Оролцогч талуудын оролцоог ямар арга замаар хангах вэ? зэргийг харгалзан үзэх ёстой.

Үнэлгээнд ашиглагдах мэдээллийг цуглуулахдаа доорх зүйлийг багтаах боловч үүгээр хязгаарлагдахгүй шаардлагатай нэмэлт мэдээллийг оруулна.

1. Төсөл, хөтөлбөрийн баримт бичиг, тэдгээрийн явц, явцын болон эцсийн тайлан, үйл ажиллагааны тайлан, санал асуулгын үр дүн, оролцогч талуудтай холбогдох албан ёсны захидал, төсөл/хөтөлбөртэй холбоотой аливаа стратегийн баримт бичиг гэх мэт холбогдох баримт бичгүүдэд шинжилгээ хийх;
2. Эрэгтэй, эмэгтэй оролцогч талуудтай нүүр тулсан ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг явуулах;
3. Оролцогч талууд болон бусад холбогдох бүлгүүдээс онлайнгаар санал асуулга авах;
4. Онлайн асуулгад өгсөн хариултыг тодруулах шаардлагатай бол утсаар ярилцлага хийх;

5. Төсөв хөрөнгө хүрэлцэхүйц байгаа тохиолдолд төсөл/хөтөлбөрийн үр шимийг хүртэгч, талуудтай уулзалт, ярилцлага хийх, зөвлөлдөх замаар мэдээлэл цуглуулах зорилгоор оролцогч орнуудад очиж ажиллах зэрэг болно.

**Зөвлөх бүлэг байгуулах:** Үнэлгээ хийхээс өмнө үнэлгээний үр дүнгийн хамаарал, найдвартай байдал, үнэлгээний оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд үнэлгээний зөвлөх бүлгийг байгуулна. Зөвлөх бүлэгт хөндлөнгийн оролцогч талуудыг урьж болох бөгөөд үүнд төсөл болон үнэлгээний оролцогч тал, эсвэл холбогдох шинжээч багтаж болно. Гишүүдийг сонгохдоо хүйсийн тэнцвэртэй байдал, мэдлэг, ур чадвар зэргийг харгалзан сонгоно.

Тус бүлэг нь:

- үнэлгээний үйл явцыг техник, арга зүйн удирдамжаар хангах;
- зөвлөхийн сонгон шалгаруулалт, ажлын даалгавар боловсруулах;
- урьдчилсан тайланг хянан батлах;
- үнэлгээний тайлангийн чанарын хяналт, зөвлөмжийг баталгаажуулах;
- дараагийн шатны төлөвлөгөөг боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**Үнэлгээний баг байгуулах:** Үнэлгээний менежер нь зөвлөх бүлгийн гишүүдэд үнэлгээ хийх үнэлгээний багийг бүрдүүлэхийг санал болгож, эцсийн сонгон шалгаруулалтад лавлах бүлгийн зөвшөөрлийн дагуу үнэлгээний багийг бүрдүүлдэг. Үнэлгээчинд байх шаардлагатай мэдлэг, ур чадвар нь оролцооноос хамаарч өөр өөр байх боловч бүх үнэлгээчид дараах нийтлэг шаардлагыг хангасан байх ёстой.

- Мэргэжлийн болон техникийн туршлага;
- Үнэлгээ хийгдэж буй сэдвээр мэргэжлийн болон техникийн туршлага;
- НҮБ-ын тогтолцооны талаарх мэдлэг; хүний эрх, жендэрийн тэгш байдал, соёлын үнэт зүйлс, тогтвортой хөгжлийн зорилтууд, үр дүнд суурилсан менежмент, зарчим, үнэт зүйл, зорилго, арга барил гэх мэт.

**Үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулах /үйл ажиллагааны хүрээ/:**

Ажлын даалгаврыг үнэлгээний төлөвлөгөөг албан ёсны болгох, гаднын зөвлөхүүдтэй хийх гэрээний үндэс суурийг бүрдүүлэхэд ашигладаг. Ажлын даалгавар нь нь дараах зүйлийг агуулсан байна. Үүнд:

- холбогдох норм, стандарт, конвенцын суурь мэдээлэл, лавлагаа;
- үнэлгээний зорилго, зорилт, хамрах хүрээ;
- арга зүй;
- жендэр, хүний эрхийн хэтийн төлөвийг үнэлгээнд хэрхэн тусгах

талаар;

- үүрэг, хариуцлага;
- гарц;
- ажлын төлөвлөгөө;
- стандарт хавсралтууд, /тухайлбал: эхлэлийн тайлан, үнэлгээний тайлангийн агуулга, үнэлгээний тайланг хянахад ашигласан чанарын шалгуурууд, үнэлгээний зөвлөхүүдийн гэрээний маягт/

*Хүснэгт 5. Үнэлгээний төлөвлөгөө, ажлын удирдамж бэлтгэх:*

<b>Үүрэг даалгавар</b>	<b>Хариуцах эзэн</b>	<b>Хугацаа</b>
Үндсэн баримт бичгүүдийг цуглуулж, үнэлгээний багтай хуваалцах	Үнэлгээний менежер	Удирдамж батлагдаж, сонгогдсон үнэлгээний баг гэрээ байгуулсны дараа
Үнэлгээний багийн танилцуулга	Үнэлгээний менежер/зөвлөх бүлэг	
Урьдчилсан тайланг бэлтгэх, эцсийн болгох	Үнэлгээний баг/ үнэлгээний менежер/ зөвлөх бүлэг	Үнэлгээ хийхээс өмнө
Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Үнэлгээний баг/ үнэлгээний менежер/ зөвлөх бүлэг	1 сарын дотор
Үнэлгээний менежерт зориулан үнэлгээний тайлангийн эхний төслийг бэлтгэх	Үнэлгээний баг	Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа дууссанаас хойш 1 сарын дотор
Үнэлгээний тайлангийн төсөлд санал өгөх	Үнэлгээний менежер/лавлах бүлэг	Үнэлгээний тайлангийн төслийг хүлээн авснаас хойш 2 долоо хоногийн дотор
Урьдчилсан дүгнэлт, зөвлөмжийг танилцуулах	Үнэлгээний баг/ үнэлгээний менежер/лавлах бүлэг	Саналыг хүлээн авснаас 2 долоо хоногийн дотор
Үнэлгээний тайлангийн төсөлд эцсийн санал өгөх	Үнэлгээний менежер/лавлах бүлэг	Үнэлгээний тайлангийн эцсийн төслийг хүлээн авснаас хойш 1 долоо хоногийн дотор
Саналыг тусгаж, эцсийн үнэлгээний тайлангийн төслийг үнэлгээний менежерт хүргүүлэх	Үнэлгээний баг	Танилцуулснаас хойш 1 долоо хоногийн дотор
Үнэлгээний тайланг дуусгаж, тайланд гарын үсэг зурах	Үнэлгээний баг	Эцсийн саналыг хүлээн авснаас хойш нэг долоо хоногийн дотор
Удирдлагын хариуг эцсийн үнэлгээний тайланд хавсралт болгон оруулах	Үнэлгээний менежер/лавлах бүлэг	Үнэлгээний эцсийн тайланг хүлээн авснаас хойш хоёр сарын дотор
Удирдлагын хариунд гарын үсэг зурах	ESCAP-ын удирдлага	
Үнэлгээний тайланг дуусгаж, үнэлгээний дүгнэлтийг хуваалцах	Үнэлгээний баг/ үнэлгээний менежер/ ESCAP-ын удирдлага	

**Баримт бичиг цуглуулах, танилцуулах:** Үнэлгээ хийхэд шаардлагатай баримт бичгийн төрөл нь үнэлгээний төрөл, сэдвээс хамаарч өөр өөр байдаг.

**Үнэлгээний эхлэлийн тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх:** Ажлын даалгавар, зөвлөх бүлэг болон бусад оролцогч талуудтай хийсэн анхны хэлэлцүүлэг, баримт бичгүүдийн анхны үзлэгт үндэслэн үнэлгээний баг эхлэлийн тайлангаа бэлтгэдэг. Үнэлгээний үзэл баримтлалын хүрээг дараах зүйлсийг харгалзан тогтооно.

- Нарийвчлан тодорхойлсон үнэлгээний аргачлал;
- Шалгуур үзүүлэлт болон асуулт;
- Үзүүлэлт;
- Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх;
- Жөндөр болон хүний эрхийн хандлага;
- Эрсдэл ба хязгаарлалт.

Энэ нь үнэлгээний багт юу, яагаад үнэлэгдэж байгаа талаарх ойлголтоо тодорхой болгож, баримт бичгийг анхан шатны түвшинд хянан үзэж, үнэлгээний зөвлөх бүлэг болон бусад оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр урьдчилсан дүгнэлтээ танилцуулах боломжийг олгодог.

**Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах:** Үнэлгээний менежерүүд оролцогч талуудын оролцоог дэмжиж, үнэлгээний энэ үе шатыг жөндөрийн тэгш байдлыг хангасан эсэхийг баталгаажуулан гүйцэтгэдэг.

- Мэдээлэл цуглуулах хуваарийн талаар оролцогч талуудтай зөвлөлдөх;
- Үндсэн судалгааны талаар мэдээлэл цуглуулах ажлыг эцэслэхийн өмнө үнэлгээний үр дүн болон дутагдалтай талын талаар үнэлгээчидтэй уулзалт ярилцлага хийх;
- Оролцогч талуудын шинжилгээнд хамрагдсан оролцогч талуудыг оруулах.

**Үнэлгээний тайлангийн төсөлд чанарын хяналт тавих:** Мэдээлэл цуглуулснаас хойш 1 сарын дотор үнэлгээний баг тайлангийн төслийг үнэлгээний менежерт санал авахаар хүргүүлдэг. Үнэлгээний менежер болон зөвлөх бүлэг тайлангийн төслийн чанарыг хянана. Үнэлгээний зөвлөмжид шүүмж өгөх нь удирдлага хариу арга хэмжээ авч, дараагийн арга хэмжээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

Үнэлгээний зөвлөмжүүд нь нотлох баримт, дүгнэлтэд тулгуурласан, тодорхой, хамааралтай, бодитой, хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Үнэлгээний менежер нь зөвлөмжийн чанарын талаар үнэлгээний багт санал өгөх шаардлагатай.

Чанарын хяналтыг хийж дууссаны дараа үнэлгээний менежер хүлээн авсан бүх саналыг нэгтгэж, тайлангийн төсөлд нэгтгэсэн саналуудыг үнэлгээний багт хүргүүлнэ. Эдгээр саналд үндэслэн үнэлгээний баг тайлангийн төслийг шинэчлэн боловсруулж, хоёр дахь төслийг үнэлгээний менежерт хянуулахаар хүргүүлнэ.

### **Үнэлгээний дүгнэлтийг ашиглах:**

*Үнэлгээний урьдчилсан дүгнэлтийг танилцуулах ажлыг зохион байгуулах:* Үнэлгээний менежер нь ESCAP-ын холбогдох ажилтнууд болон гаднын оролцогч талуудыг оролцуулан урьдчилсан дүгнэлтийг танилцуулах ажлыг зохион байгуулна. Оролцогчдод тайлантай танилцах боломжийг олгох үүднээс илтгэл тавихаас өмнө илтгэлийн төслийг тараана. Хурлыг хоёр хэсэг болгон зохион байгуулна.

1. Үнэлгээний багийн үнэлгээний үр дүнгийн танилцуулга, асуулт хариулт.
2. Удирдлагын хариу арга хэмжээ болон дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх дотоод хэлэлцүүлэг. Энэ хэсэгт үнэлгээний менежер, зөвлөх бүлэг болон бусад холбогдох ажилтнуудыг оролцуулан зөвхөн ESCAP-ын холбогдох ажилтнуудыг хамруулна.

Энэхүү танилцуулга нь үнэлгээний урьдчилсан үр дүн, дүгнэлтийг оролцогч талуудад илүү өргөн хүрээнд ойлгуулж, сайжруулах талаар санал, зөвлөмж өгөх боломжийг олгодог.

*Удирдлагын хариу арга хэмжээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бэлтгэх:* Удирдлагын хариу арга хэмжээ болон дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь ESCAP-ийн удирдлага үнэлгээний зөвлөмжид хариу өгөхийг баталгаажуулах албан ёсны механизм юм. Удирдлагын хариуг үнэлгээний тайланг эцэслэн гаргаснаас хойш хоёр сарын дотор

холбогдох ахлах менежерүүд болон ESCAP-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргад танилцуулж, гарын үсэг зуруулна.

**Үнэлгээний дүгнэлтийг түгээх /хуваалцах/:** Үнэлгээний менежер нь тайланг хэвлэхэд бэлтгэх, үнэлгээний тайланд удирдлагын эцсийн хариуг нэгтгэх, тайлангийн PDF файлыг бэлтгэх, шаардлагатай бол цаасан дээрх тайланг хэвлэх, гүйцэтгэлийн хураангуй орчуулгыг бэлтгэх ажлыг хариуцна. Удирдлагын хариу арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаасан эцсийн үнэлгээний тайланг дараах байдлаар түгээнэ.

- Дотооддоо: iseeк болон IMDIS дээр
- Гаднаас ESCAP-ын цахим хуудас дээр
- Гишүүн орнууд болон хандивлагчид зэрэг гаднын оролцогчдод;

Үнэлгээний алба нь дараах зорилгоор бүх ажилчдад нээлттэй семинар зохион байгуулдаг. Үүнд:

- Үнэлгээг удирдах, явуулах туршлагаа хуваалцах;
- Үнэлгээнээс олж авсан янз бүрийн сургамжийг дүгнэж, тодорхойлох;
- Үнэлгээний үр дүнд бий болсон үндсэн бодлого, байгууллагын өөрчлөлт, нөлөөллийг онцлон харуулах.
- Үнэлгээний алба нь ESCAP-ийн удирдлага, ажилтнуудад илүү өргөн хүрээний зөвлөмжийг өгөх үүднээс үнэлгээний үр дүнг илтгэсэн цаг үеийн болон сэдэвчилсэн нэгдсэн тайланг бэлтгэдэг байна.

**Мөрдөн хэрэгжүүлэх:** Үнэлгээний алба нь дагаж мөрдөх арга хэмжээний хяналтын хуудсыг хөтөлж, хэлтэс, алба тус бүрийн дагаж мөрдөх арга хэмжээ тус бүрийн талаар Гүйцэтгэх нарийн бичгийн даргад хоёр жилд нэг удаа тайлагнах замаар үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

### ***Үнэлгээний тайланг хянахад ашигладаг чанарын шалгуур үзүүлэлтүүд***

Үнэлгээний тайлангийн төсөл болон үнэлгээний эцсийн тайланг дор дурдсан чанарын хяналтын хуудсаар үнэлнэ.

*Хүснэгт 6. Үнэлгээний тайлангийн чанарын хяналтын хуудас*

<b>Үнэлгээний тайлангийн гарчиг</b>	
<b>Агуулга</b>	Тайлан нь логик бүтэцтэй, шаардлага хангахуйц бичигдсэн.
	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний тайлан нь ажлын удирдамжаар тодорхойлсон агуулгын дагуу хийгдсэн, холбогдох хавсралтыг багтаасан байна</li> <li>• Товч дүгнэлт нь 1-2 хуудас байх бөгөөд гол дүгнэлт, зөвлөмжүүдийг онцолсон байх.</li> <li>• Тайлан нь НҮБ-ын дүрэмд нийцсэн, зөв бичгийн дүрмийн дагуу бичигдсэн, алдаагүй бичигдсэн байх бөгөөд уншихад хялбар, ойлгогдохуйц байх</li> <li>• Үндсэн мессежүүд нь текстээс тодорхой ялгаатай байх.</li> </ul>
<b>Зорилго, зорилт,</b>	Үнэлгээний тайлан нь ажлын даалгаварт заасан үнэлгээний зорилго, зорилт болон хамрах хүрээг хангасан байх.

<b>хамрах хүрээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Тайлан нь үнэлгээний объектын талаар тодорхой тайлбарыг өгч, хүлээгдэж буй үр дүнг тодорхой тусгасан байна. Үнэлгээний гол оролцогч талуудыг жагсаасан байх.</li> <li>• Тайлан нь үнэлгээний зорилго, зорилт, хамрах хүрээ, үнэлгээний үндсэн асуултууд болон хязгаарлалтуудыг тодорхой тайлбарласан байна.</li> <li>• Тайлан нь сонгосон үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлж тайлбарласан байх.</li> <li>• Үнэлгээний зорилго болон хамрах хүрээ нь жендэрийн тэгш байдал, хүний эрхийн асуудлыг хөндсөн байх.</li> </ul>
<b>Үнэлгээний арга зүй</b>	<p>Үнэлгээний арга зүй, түүний программыг тодорхой тайлбарласан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний аргачлалыг тодорхой тайлбарласан байх бөгөөд үнэлгээний явцад ашигласан байх.</li> <li>• Тайлан нь мэдээлэл цуглуулах арга болон судалгаа шинжилгээг тодорхой тусгасан байх.</li> <li>• Тайлан оролцогч талуудтай зөвлөлдөх үйл явцыг тодорхойлсон байх.</li> <li>• Жендэрийн болон хүний эрхийн талаар үр дүнтэй судалгаа шинжилгээ хийхэд тохиромжтой аргыг ашиглах.</li> <li>• Аргачлалын талаар орсон нэмэлт, өөрчлөлтийг тайлбарлах.</li> <li>• Үнэлгээний арга зүйн хязгаарлагдмал байдал болон судалгааны явцад олж мэдсэн үр дүн, бодит байдал дээр тэдгээр нь хэрхэн хэрэгжиж байгааг тодорхой тайлбарласан байх.</li> </ul>
<b>Үнэлгээний үр дүн</b>	<p>Үнэлгээний үр дүн болон дүгнэлтүүд найдвартай байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний үр дүн нь тайлангийн хамрах хүрээ, зорилтын хэсэгт нарийвчлан тусгагдсан үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүний асуултуудад хариулсан байх.</li> <li>• Үнэлгээний үр дүн нь тайланд дурдсан аргачлалыг ашиглан цуглуулсан нотлох баримтад үндэслэсэн байх.</li> <li>• Үр дүн нь судалгаа шинжилгээнд үндэслэсэн, нотолгоонд суурилсан, бодитой байх.</li> <li>• Дүгнэлт нь хангалттай үндэслэлтэй, тэнцвэртэй, найдвартай байх.</li> <li>• Оролцогч талуудын оруулсан хувь нэмрийг дурдсан байх.</li> </ul>
<b>Дүгнэлт</b>	<p>Дүгнэлт нь нотлох баримтад тулгуурласан, ойлгомжтой байх.</p>
	<ul style="list-style-type: none"> <li>• Дүгнэлт нь үнэлгээний үр дүнгээс гарсан байх бөгөөд нотлох баримтад үндэслэсэн байх.</li> <li>• Дүгнэлт нь үнэлгээний зорилго, гол асуултуудтай холбоотой байх.</li> <li>• Дүгнэлт нь үнэлгээний үр дүнтэй логик холбоотой байх.</li> </ul>
<b>Зөвлөмж</b>	<p>Зөвлөмжүүд нь хэрэгцээтэй байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөмжүүд нь тодорхой байх бөгөөд нотлох баримт, үнэлгээний үр дүн, дүгнэлтээс хийгдсэн байна.</li> <li>• Зөвлөмжүүд нь бодитой, тодорхой, хэрэгжүүлэх боломжтой байх.</li> </ul>
<b>Жендэр, хүний эрх</b>	<p>Жендэр, хүний эрхийн зарчмуудыг голчлон баримтлах.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээчин нь хүйс болон нийгмийн бусад бүлгүүдээр ангилсан өгөгдлийг цуглуулж, дүн шинжилгээ хийх.</li> <li>• Үнэлгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмж, сургамж нь жендэрийн тэгш байдал, хүний эрхийн талаарх мэдээллээр хангах.</li> <li>• Үнэлгээний тайланд жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан үг хэллэг ашигласан байх.</li> </ul>

## ЧИЛИ УЛСЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АХИЦ ДЭВШИЛ БА СОРИЛТУУД<sup>12</sup>

Зохиогч: *Констанза Торо, Чилийн Конгрессын зөвлөх*<sup>13</sup>

Судалгааны энэ хэсэгт Чили улсад хууль батлагдсаны дараах хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон хууль тогтоомжийн үр нөлөө, үр дагаврыг шалгаж үнэлэхтэй холбоотой үйл ажиллагааны стандарт мөн хяналт тавих тогтолцооны хувьд олон жилийн турш гаргасан ахиц дэвшил, ололттой тал хийгээд энэ тогтолцоог сайжруулахад тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох арга замыг авч үзсэн болно.<sup>14</sup>

Аливаа хууль тогтоомжийн эцсийн зорилго нь түүнийг хэрэгжүүлэх боломжтой, санал болгож, батлах үед хүссэн үр дүн, зорилгодоо хүрч чаддаг байх ёстой. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон хүчин зүйл нөлөөлж болно. Мөн хуулийг хэрэгжүүлэх Засгийн газар, хууль тогтоох байгууллага, шүүх гэх мэт тодорхой үүрэг гүйцэтгэдэг олон оролцогч талууд байдаг.

**Хуулийн хэрэгжилтийн хяналтын тухай ерөнхий ойлголт:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх олон арга бий.

Нэгдүгээрт, Засгийн газар, парламент, хараат бус агентлаг, шинжээчдийн баг эсхүл өөр боломжит оролцогч талууд эсэхээс үл хамааран үнэлгээг хэн хийх вэ гэдэг чухал.

Хоёрдугаарт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг батлагдахаас нь өмнө үнэлэх, батлагдсаны дараа үнэлэх, энэ тохиолдолд ямар цаг хугацаанд хийх зэргийг сонгоно.

Хэдийгээр хууль хэрэгжсэний дараа үнэлгээ дүгнэлт хийх арга зам бий боловч тэдгээрийг ижил утгатай гэж үзэж болохгүй. Энэ утгаараа хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх гэдэг нь зохицуулалтыг системтэй үнэлэхэд хэрэглэгддэг хамгийн ерөнхий нэр томъёо юм. Нөгөө талаас хуулийн хэрэгжилтийн үнэлгээний зорилго нь өмнөх үнэлгээг тусгайлан нөхөх явдал бөгөөд үр нөлөөний үнэлгээний хүрээнд хийгддэг. Иймээс нөлөөллийн үнэлгээний "шинэчилсэн хувилбар" бөгөөд хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ нь хууль тогтоомж практикт хэрхэн хэрэгжиж байгааг шалгахыг эрмэлздэг.

Британийн BIS4 агентлагийн мэдээлснээр, хууль тогтоомжийн хэрэгжилтийн дараах хяналт шалгалтын үеэр "үндсэн сонсогч" нь Парламент юм; үүнд гол хууль тогтоомж, түүнийг дэмжсэн хоёрдогч зохицуулалт буюу бусад дэд актууд яаж үйлчилж буйг тодорхойлох хяналт багтана. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээнээс ялгаатай тал нь энэ юм.

<sup>12</sup> \*Article written based on a previous publication by the same author, available at <http://lals.uai.cl/index.php/rld/article/view/41>

<sup>13</sup> Lawyer from the University of Chile, Master of Public Administration specialising in Public and Economic Policies, London School of Economics (LSE) and Master of the Joint Master Program in Parliamentary Procedures and Legislative Drafting (EUPADRA), LUISS Guido Carli University (Italy), Complutense University (Spain) and University of London (UK). Lawyer of the Bureau of the Chamber of Deputies, Valparaíso, Chile.

<sup>14</sup> HOUSE OF LORDS (2004), Par. 165

Учир нь хууль тогтоомж, түүнийг дэмжсэн хоёрдогч зохицуулалт практикт хэр зэрэг хэрэгжиж байгааг нягталж үздэг учраас. Иймд хууль баталсны дараах хяналтын үнэлгээг хийхэд эрх шилжүүлсэн бусад зохицуулалтыг бүхэлд нь буюу ихээхэн хэсгийг нь авч үзэх шаардлагатай юм."



Хууль тогтоох хяналтын янз бүрийн аргачлалын хооронд нягт уялдаа холбоо байдаг. Нэг талаас парламентаас хийж байгаа үнэлгээ нь төрийн болон бусад байгууллагуудын үнэлгээтэй нягт холбоотой; нөгөө талаас өмнөх үнэлгээг одоогийн үнэлгээтэй холбож байдаг.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх дараах шалтгаан байна. Үүнд:

- Урьдчилсан үнэлгээ нь хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад тусалдаг. Хууль батлагдсаны дараах үнэлгээ нь зохицуулалтын үр нөлөөг илүү их нотлох баримтаар шинжлэх боломжийг олгож, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад байгаа дутагдлуудыг илрүүлэх, улмаар дээрх дутагдлыг арилгахад туслах механизмыг боловсруулахад тусалдаг. Үүний зэрэгцээ бусад хуулиудад мөрдөж болох сайн туршлагыг тодорхойлох боломжтой болдог.
- Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэр, харилцан хяналттай байх зарчмыг хэрэгжүүлэхэд тустай. Энэ утгаараа хууль баталсны дараах хяналт нь парламентын төлөөллийн болон хяналтын үүргийг бэхжүүлэхээс гадна дотоод чадамжийг хөгжүүлэхэд тустай.
- Ардчилсан засаглалыг бэхжүүлж хөгжүүлэхийн тулд хууль тогтоомжийг хууль ёсны болон эрх зүйн тодорхой байдлын зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатайг онцлон, парламентаас явуулж буй PLS-ийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ерөнхий шалтгаан байна. Иймээс хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээ ялангуяа хууль тогтоомжийг баталсны дараах үнэлгээг эрх зүйд захирагдах хэм хэмжээний өргөн хүрээний стандарттай холбодог юм.

#### **Чили Улсын хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуурууд:**

Хууль батлагдсаны дараах хэрэгжилтийн хяналтын тогтолцоог үнэлэх шалгуурууд нь Мадераас тогтоосон үр нөлөөтэй байдал, үр дүн, үр ашиг гэсэн гурван стандартад үндэслэгддэг.

*Үр нөлөөтэй байдал:* Энэхүү шалгуураар хууль тогтоомж, дүрэм журам практикт хэрэгжиж байгаа эсэхийг шалгахыг шаарддаг.

*Үр дүн:* хууль тогтоомжийн заалтууд зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлно. Мадерын тайлбарласнаар хэрэгжилт үр дүнтэй байх зайлшгүй шаардлагатай боловч хуулийн зорилгыг анхнаасаа буруу тодорхойлсон байж болох талтай. Иймээс үр нөлөө нь түүний үр дүнтэй байдлын нотолгоо биш юм.

*Үр ашиг:* Хууль хэрэгжсэнээс үүссэн зардал, ашиг тусыг анхаарч үздэг. Энэхүү дүн шинжилгээ нь шууд санхүүгийн болон мөнгөн үр ашиг, зардлыг авч үзнэ. Захиргааны ачаалал, дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө, тэр байтугай иргэдэд үзүүлэх сэтгэл зүйн нөлөөлөл зэрэг бусад төрлийн гаднын хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой.

Эдгээр стандартууд нь хууль тогтоомжийн бүх боломжит үр нөлөөг тайлбарлаж чадахгүй бөгөөд үүнийг ерөнхийд нь хууль тогтоох үйл ажиллагааны "нөлөөлөл" гэж тодорхойлж болно.

### **Чилийн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ:**

Чили улсад хууль тогтоосны дараах хяналтыг сонирхож, хөгжүүлэх нь харьцангуй саяхан болсон. Иймд Гүйцэтгэх засаглалд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, байгууллагын үнэлгээний хөтөлбөр зэрэг төсвийн удирдлагатай голчлон холбогдсон өмнөх үнэлгээний механизмууд байдаг. Гүйцэтгэх засаглал нь урьдчилсан үнэлгээний аргыг ашигладаг.

Конгрессын хувьд хууль тогтоосны дараах хяналт шалгалтыг хийх хүчин чармайлт нь Төлөөлөгчдийн танхимд төвлөрч байна. Уламжлал ёсоор, тодорхой хэмжээгээр хууль тогтоомжийн дараах хяналт шалгалтыг хийдэг сэдэвчилсэн хэлэлцүүлгүүд болдог боловч энэ нь хяналт шалгалтын зорилго биш. Зарим судлаачид Мөрдөн шалгах түр хороог хууль тогтоосны дараах шалгалтын нэг хэлбэр гэж дурддаг боловч эдгээр хороод бие даасан хэлбэрээр энэ зорилгыг хэрэгжүүлдэггүй.

Энэ хүрээнд 2011 онд хамгийн чухал үйл явдал болсон нь 2011 онд Төлөөлөгчдийн Танхимын Хууль зүйн үнэлгээний хэлтэс байгуулагдсан явдал бөгөөд тус хэлтэс нь:

- Конгрессоор батлагдсан хуулиудын үр нөлөө, нийгэмд үзүүлж буй нөлөөлөлтэй нь уялдуулан үнэлгээ өгөх;
- хуулийг зөв хэрэглэхэд шаардлагатай бол засаж залруулах арга хэмжээг санал болгох;
- үнэлгээнд оролцох сонирхолтой нийгмийн байгууллагуудын сүлжээг бий болгож, удирдах. Түүнчлэн улс төрийн янз бүрийн бүлэгт харьяалагддаг гишүүдээс бүрдсэн Хууль зүйн үнэлгээний хороо байдаг бөгөөд тус газрын үйл ажиллагаанд хамтран ажиллах чиг үүрэгтэй.

Энэхүү хэлтэс нь хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, зорилгодоо хүрч байгаа эсэхийг тодорхойлох, тэдгээрийн нөлөөлөл, гадаад хүчин зүйлсийг тодорхойлох, сайн туршлага, олон нийтийн ойлголтыг харгалзан үзэж, засаж залруулах арга хэмжээг санал болгодог.

Тус хэлтэс нь тайлангаа хууль зүйн техникийн судалгаа, олон нийтийн ойлголт, эцсийн тайлан гэсэн гурван үе шаттайгаар боловсруулдаг.

Үнэлгээнд хамрагдах хуулиудыг улс төрөөс ангид байх, нийтлэг хэрэглэгдэх боломжтой, болзошгүй нөхцөл байдал, арга зүй, цаг хугацаа, техникийн боломжийн шалгуур үзүүлэлтийг харгалзан Хууль зүйн үнэлгээний хэлтсээс боловсруулсан саналыг үндэслэн хороо жил бүр шалгаруулдаг.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг дор хаяж нэг жилийн дараа үнэлдэг. Тус газар байгуулагдсан цагаасаа хойш арван хоёр хуульд үнэлгээ хийжээ.

**Үр дүнтэй байдал:** Чилийн систем нь үр дүнтэй байдлыг хууль тогтоомжийн дараах хяналтад авч үзэх гол шалгуур гэж үздэг. Тэгэхээр хуулийг хоёроос доошгүй жил мөрдөж байгаа эсэхийг нь дүгнэх шаардлагатай.

Үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур нь хууль практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар тул хамгийн сайн мэдээллээр хангаж чадах Засгийн газар, мөн хэрэгжилтийг хариуцдаг бусад байгууллагуудтай хамтран ажиллах явдал юм. Чилийн хувьд Хууль зүйн үнэлгээний газар нь мэргэжилтнүүд болон хэрэгжүүлэгч байгууллагуудын дүгнэлтийг багтаасан техникийн шинжилгээ хийх үүрэгтэй байгууллага юм.

Гэсэн хэдий ч мэдээллийг хүлээн авах тусгайлсан суваг байхгүй, түүнийг өгөх үүрэг ч байхгүй тул хуулийг хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагуудаас гаргаж буй мэдээлэл нь нэг тайлангаас нөгөөд өөр байх хандлагатай байдаг. Гэхдээ ерөнхийдөө өргөдлийн дүн шинжилгээ, олон нийтийн саналд /тэдэнд түшиглэсэн судалгаанд/ анхаарлаа хандуулдаг.

Өөр нэг чухал зүйл бол нь эрх шилжүүлсэн зохицуулалт байна уу эсвэл тодорхой хуультай холбоотой эсэхийг тодруулах ёстой. Учир нь "хоёрдогч хууль тогтоомжид олон нарийн зүйл, утга санаа агуулагддаг" бөгөөд "олон тооны хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл бий болгосон" байдаг. Энэ хүрээнд Чилид хууль тогтоомжийн дараах хяналтыг өмнөх хууль тогтоомж, хоёрдогч хууль тогтоомж, тэр ч байтугай холбогдох хууль тогтоомжийг багтаахыг зорьдог.

**Үр ашиг:** Үр дүнтэй болохыг батлахын тулд хуулиар зорьж буй зорилгыг тодорхойлсон шалгуур буюу лавлах асуултыг томъёолох нь маш чухал юм.

Чилийн тухайд Хууль зүйн үнэлгээний газрын тайланд ихэвчлэн нэг хуульд аль хэдийн тогтоосон зорилтуудыг дурддаг бөгөөд энэ нь нэг догол мөрөөс бүрдэх нь ховор. Харамсалтай нь, Чилид хууль гаргасны дараах хяналт шалгалтын үндэс болох хууль батлахын өмнөх үр нөлөөний үнэлгээ хийгддэггүй бөгөөд энэ хоёр төрлийн үнэлгээ ялгаатай боловч бие биенээ нөхөх механизм гэдгийг хараахан ойлгоогүйг харуулж байна.

Хуульд заасан зорилгын биелэлтийг аль агентууд үнэлдэг вэ гэдэг нь бас нэг анхаарах зүйл юм. Чилийн хувьд үнэлгээг техникийн багаас бүрдсэн Хууль зүйн үнэлгээний хэлтэс гүйцэтгэдэг.

Хууль баталсны дараах шалгалт нь хуулийг дахин хэлэлцэх шалтгаан болохгүй байсан ч энэ нь улс төрийн зорилгод нийцэж байгаа эсэхийг парламентын гишүүд илүү сайн дүгнэж чадах эсэхийг эргэцүүлэн бодох нь зүйтэй. Энэ утгаараа тэд хуулийн хэлэлцүүлэгт оролцож байсан бол нарийн ширийн зүйл, тулгамдаж буй бэрхшээлийг илүү сайн мэдэж болох байсан.

Эцэст нь Хууль зүйн үнэлгээний газраас сонгосон аргачлал нь үнэлгээнд хамрагдаж буй хуультай холбоотой иргэний нийгмийн бүлгүүд болон хувь хүмүүсийн оролцоонд онцгой ач холбогдол өгдөг бөгөөд тэдгээр нь шууд нөлөөлөлд өртөж байна гэсэн ойлголттойгоор үнэлгээний судлагдахуун, оролцогч болдог.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн гэнэтийн болон хүсээгүй үр дагаврыг төсөөлөхөд хувь нэмэр оруулахад тэдгээрийн оролцоо чухал бөгөөд хууль тогтоох үйл явцын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой. Энэ логикийн дагуу Хууль зүйн үнэлгээний хэлтэс нь хууль тогтоомжид үнэлэлт дүгнэлт өгөхдөө иргэдийн форумыг зохион байгуулж, тэдэнд санал, хүсэлтээ илэрхийлэх боломжийг олгодог.

"ухаалаг зохицуулалт" олон улсын хөдөлгөөн 2000-аад оны эхэн үеэс эхэлсэн бөгөөд хууль тогтоомжийн чанарт онцгой ач холбогдол өгч, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг дэмжих үндсэн хэрэгсэл гэж үздэг байв. Түүнээс хойш эдийн засгийн шинжилгээ нь ерөнхийдөө хууль тогтоох, тэр дундаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний чухал хэсэг байсаар ирсэн.

Үр ашгийн стандарт нь хуулийн дагуу эдийн засгийн зардал, үр өгөөжийн үнэлгээтэй нягт тодорхойлогддог бөгөөд ийм учраас ихэвчлэн зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ (RIA) эсвэл зардал, үр ашгийн (C&B) шинжилгээ зэрэг баримт бичигт үндэслэдэг.

Чилид "хуулийн үр нөлөөг, тухайлбал зардал, ашиг тусын хувьд хэмжих тусгай тоон арга зүйн арга байдаггүй". Цаашилбал, арга зүйн тайлбартаа зохицуулалтын зардал, үр ашиг, түүний үр ашгийн үнэлгээг дурдаагүй болно. Хэдийгээр энэ үнэлгээ нь өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийн оролцоог шаарддаг боловч хуулийн хэрэгжилтийн иж бүрэн хяналт, үнэлгээний явцад тоон үзүүлэлтийг оруулах нь маш чухал байгаа.

*Хүснэгт 7. Чилийн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ*

<b>Шалгуур</b>	<b>Хамрах хүрээ</b>	<b>Сул тал</b>
<b>Үр нөлөөтэй байдал</b>	- Хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дараа - Энэ нь эрх шилжүүлсэн, өмнөх болон холбогдох хууль тогтоомжийн дүн шинжилгээг хамарна.	Засгийн газраас санал авах институцичлагдсан арга байхгүй. -Хугацаа дуусах заалтыг хязгаарлагдмал байдлаар ашигладаг.
<b>Үр дүн</b>	- Зорилго заасан зохицуулалт дээр үндэслэсэн. - Иргэдээс ирүүлсэн хүчтэй санал хүсэлт	Үүнд хууль батлахаас өмнөх үнэлгээ дутмаг байна. -Оролцогчдын хувь нэмрийг жигд оруулах зохион байгуулалттай суваг байхгүй.
<b>Үр ашиг</b>	Үр нөлөөг өргөн утгаар нь авч үзэх.	Хууль тогтоомжийн зардал, үр ашгийн тоон шинжилгээг үнэлгээний иж бүрдэлд оруулаагүй. - Энэ төрлийн шинжилгээг хийхэд бэлтгэгдсэн боловсон хүчин, тусгай дэмжлэг байхгүй.

## МЕКСИК: КОНГРЕСС ДАХЬ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, АРГА ЗҮЙ, ТУРШЛАГА

*Зохиогч: Мариа Фернанда Аррегуин Гамез, Олон улсын хүний эрхийн эрх зүйн магистр (Ливерпүүлийн их сургууль). Гуанахуато мужийн Конгрессын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтын зохицуулагч.*

Даяаршлын нөлөөгөөр дэлхий ертөнц янз бүрийн өөрчлөлтүүдтэй нүүр тулгарч байна. Эдгээр өөрчлөлтүүд дэлхийн парламентуудын чиг үүрэгт ч бас нөлөөгөө үзүүлсэн юм. Парламент хууль санаачлан боловсруулж батлаад хэрэглэх, үйлчлэх, зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулахыг нь бусад эрх мэдэлд даатгадаг байсан бол одоо больсон.

Батлагдсан хуулиудаа зорилгодоо хүрч байгааг парламентууд анхаарах ёстой. Энэ цаг үе бол Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний эрин үе юм. Мексикийн хувьд Гуанахуато мужийн Конгресс нь хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хууль тогтоох үйл ажиллагааныхаа нэг хэсэг болгон тусгай нэгж байгуулсан Мексикийн улсын анхны парламент юм. Энэхүү хэсэгт Гуанахуато мужийн Конгресст хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг бий болгосон болон түүний хууль эрх зүйн зохицуулалт, хяналт, үнэлгээ хийх арга зүй, хүрсэн үр дүн, Мексикийн бусад конгрессын хүрээнд бий болох тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийсэн болно.

Дэлхий олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүдэд эдийн засаг, улс төрийн аль алинд нь өөр өөр сорилтуудыг авчирсан. Шийдвэр гаргах үйл явцад олон нийтийг татан оролцуулах замаар ардчилсан засаглалыг бий болгох, тэр тусмаа үйл ажиллагааныхаа үр дүнд олон нийтээс сайшаал хүлээх замаар ардчилсан засаглалыг бий болгоход түлхэц болж байгаа нь хөгжиж буй орнуудын жишээ юм. Энэ утгаараа засгийн газрын хийж буй үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь ардчиллыг бэхжүүлэх, авлигыг бууруулах, засгийн газрын хууль ёсны байдлыг нэмэгдүүлэх хэрэгсэл болж байгааг баталж байна.

Оксфордын толь бичгийн дагуу үнэлгээ гэдэг нь “ямар нэг зүйлийн хэмжээ, тоо, үнэ цэнийн талаар дүгнэлт гаргах; үнэлгээ.” хийх юм. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Засгийн газрын үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдэх эрхийг хангаж шаардлагатай мэдээллийг өгнө.
2. Засгийн газрын үйл ажиллагаанд шаардлагатай байгаа шинэ өгөгдөл бий болгодог.
3. Агентлагуудын дүн шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлж, суралцах соёл руу чиглүүлдэг.
4. Засгийн газрыг шударга байлгахад тусалдаг.

Тиймээс ардчилсан засгийн газрын амжилтыг тодорхойлоход үнэлгээ гол үүрэг гүйцэтгэнэ. Холбооны дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхийн тулд засаглалын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваагддаг. Холбооны Үндсэн хуулиар Мексик бол Ардчилсан Бүгд Найрамдах Улс гэдгийг тогтоосон ч; саяхныг хүртэл энэ санааг төрийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх замаар бэхжүүлэх сонирхол байгаагүй. Дал гаруй жилийн турш нэг улс төрийн нам ноёрхсон эрх мэдлийн улмаас (Байгууллын Хувьсгалт нам "Partido Revolucionario Institucional": PRI) цорын ганц сонирхол нь ерөнхийлөгчийн хэлэлцэх асуудлын нэг хэсэг байсан хөтөлбөрүүдийг ээлжлэн хэрэгжүүлэх явдал байв.

Хэдийгээр эдийн засгийн хямралаас болж Мексикийн хөрөнгийн ашиглалтыг үнэлэх шаардлага гарч ирсэн ч ийм үнэлгээний үр дүнг төрийн бодлого боловсруулах, шинэ хууль тогтоомжийг боловсруулахад анхаарч үзээгүй. Харин Мексикийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг Үндэсний үйл ажиллагааны намд (PAN) алдсанаас хойш л энэ үнэлгээг нухацтай авч үзэж эхэлсэн.

PAN (2000-2006) тэргүүтэй дараагийн удирдлага нь төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг тодорхойлох зорилгоор Гүйцэтгэлийн үнэлгээний систем гэж нэрлэгддэг илүү өргөн хүрээтэй үнэлгээний хөтөлбөрийг байгуулсан. Энэ тогтолцоог хэрэгжүүлсэн нь ардчиллыг бэхжүүлэх, үнэлж дүгнэх тал дээр хамгийн том ололттой байсан ч нэг зүйлийг орхигдуулсан юм.

Гүйцэтгэх эрх мэдэл, төрийн бодлогод онцгой анхаарал хандуулсан боловч хууль тогтоох, шүүх эрх мэдлийн үнэлгээнд хэн ч анхаарлаа хандуулаагүй. Хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын үнэлгээг 2016 он хүртэл Мексикт огт авч үздэггүй байсан. Харин Мексикт хамгийн анх Гуанахуато мужийн Конгресс л хууль тогтоох эрх мэдлийн нэгэн чиг үүрэг болгож хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлэхээр шийдсэн нь байна.

### **Нэгдүгээр хэсэг: Гуанахуато муж улсын Конгрессын тухай**

Конгресс нь гурван жил тутамд сонгогддог 36 хууль тогтоогчоос бүрддэг. Энэ нь бие даасан эрх мэдэл бөгөөд өөрийн нөөц баялгаа ашиглах, дотоод зохион байгуулалтаа хэрэгжүүлэх бие даасан эрх мэдэлтэй.

Ээлжит чуулганы хугацааг Гуанахуато мужийн улс төрийн Үндсэн хуулиар тогтоосон байдаг. 51-р зүйлд зааснаар Конгресс жил бүр хоёр ээлжит хуралдаантай байх ёстой. Эхний үе 9-р сарын 25-нд эхэлж, арванхоёрдугаар сарын 31-нд дуусна. Хоёр дахь үе нь 2-р сарын 15-нд эхэлж, 6-р сарын 30-нд дуусна.

Конгрессын ерөнхий шинж чанарыг тодорхойлсны дараа энэхүү нийтлэл нь PLS-ийн практикт анхаарлаа хандуулах болно. Дараагийн хэсэгт хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг Гуанахуатод саяхан хэрэглэх явцад гаргасан хамрах хүрээ, хэрэглээ, үр дүнг авч үзэх болно.

**Хоёрдугаар хэсэг:** Гуанахуато дахь хуулийн хэрэгжилтийн хяналт: үзэл баримтлал, арга, үр дүн.

а) Гуанахуато дахь хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний эрх зүйн үндэс:

Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэхийн тулд Конгресс 2016 оны 12-р сарын 27-нд шинэ хууль баталсан. Энэ хуулиар Конгресс нь хуулийн үр нөлөөллийг хянах, үнэлэх хэлтэстэй байх ёстой гэдгийг баталгаажуулсан. Unidad de Seguimiento y Analisis de Impacto Legislativo (Unidad de Seguimiento y Analisis de Impacto Legislativo) гэж нэрлэдэг. Usail, Испани хэлээр). Хууль тогтоомжийн органик хуулийн 282-р зүйлд зааснаар Usail-ийн ерөнхий бүрэн эрх нь:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөө, үр дүн, үр ашигтай байдал болон хууль тогтоох, хэрэгжүүлэх байгууллагуудаас Гуанахуатогийн хүн амд ямар нөлөө

үзүүлснийг шалгахын тулд байгуулагдсан хууль тогтоох эрх мэдлийн нэг хэсэг юм.

- Төрийн засаглалын (гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх) бие даасан байгууллага, хотын захиргаанаас хууль тогтоомжийн биелэлтийг бүрэн эрхийнхээ хүрээнд шаардах эрхтэй;
- Хууль тогтоомжийн үр нөлөөллийг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулах;
- Хууль тогтоомжийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг үнэлэх, хэмжих судалгаа хийх;
- Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлсэн тайланг жил бүр мэдээлэх;
- Хууль тогтоомж батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага, боломжид дүн шинжилгээ хийх.

Гуанахуато дахь хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ нь илүү хатуу бөгөөд өргөн ойлголтыг багтаадаг.

а) Usail нь эрх шилжүүлсэн зохицуулалтаар үүрэг хүлээсэн субъектүүд хууль хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай бусад шийдвэрийг гаргасан эсэхийг шалгах ёстой;

б) Usail нь хуулийн эдийн засаг, нийгэмд үзүүлсэн нөлөөллийг үнэлэх ёстой. Тиймээс Usail-ийн зорилтууд нь Вестминстерийн ардчиллын сангаас хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зорилтыг тодорхойлсонтой нийцэж байна гэж хэлж болно.

Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хугацааг хууль бүрт тусгаж баталдаггүй тийм шаардлагагүй гэж үздэг. Гэсэн хэдий ч зарим хуулийн заасан бөгөөд ерөнхийдөө хэрэгжсэнээс хойш таван жилийн дараа үнэлгээг хийдэг. Тодруулбал, ийм заалт агуулсан гурван хууль байдаг: 1) Гуанахуато муж болон хотын захиргааны тухай хууль, 2) Гуанахуато муж улсын малын тухай хууль, 3) Ил тод байдал, хүртээмжтэй байдлын тухай хууль

Хэдийгээр олон улсын зарим байгууллага хууль болгоныг үнэлэх шаардлагагүй гэж үздэг ч Конгрессоос баталсан бүх органик хууль тогтоомж, тогтоолуудад хяналт шинжилгээ, үнэлгээний хийх ёстой гэж заасан байдаг. Гэсэн ч Usail олон улсын стандартын дагуу аль хуулийг үнэлэх ёстой, үгүйг заасан аргачлалыг боловсруулсан. Дараагийн дэд хэсэгт аргачлалын талаар авч үзнэ.

**Арга зүй:** Гуанахуато муж улсын Конгресс нь хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний практикийг хөгжүүлж буй бусад олон улсуудтай байнгын холбоо тогтоосон. Тэдний нэг бол Чилийн конгресс бөгөөд тэд хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний туршилтын төслийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан.

Гуанахуато мужийн Конгрессын хэрэгцээнд зориулан тусгайлан боловсруулсан аргачлал байх бөгөөд энэ нь дараах 5 үе шаттай. Үүнд:

- а) хууль эрх зүйн судалгаа,
- б) иргэдийн ойлголт, үүрэг хүлээсэн субъектын хэтийн төлөвийг хэмжих,
- в) үр нөлөө, үр ашгийг хэмжих,
- г) нөлөөллийн үнэлгээ;
- д) үр дүнг түгээх.

*Хуулийн эрх зүйн судалгаа:* Эхний үе шат нь Холбооны Үндсэн хууль, түүний зорилго, зорилтот хүн ам, үндэсний эрх зүйн тогтолцооны харилцан уялдааг мэдэх

шаардлагатай. Энэ хэсэг нь хяналт шинжилгээ, үнэлгээний үндэс суурь юм.

*Иргэдийн ойлголт:* Үүний гол зорилго нь тухайн хуулийн үйлчлэлд өртөж буй хүн ам, үүрэг хүлээсэн субъект, болон мэргэжилтнүүдийн хэтийн санаа бодлыг олж мэдэх явдал юм. Энэ үе шатанд "оролцооны аргууд"-ыг ашигладаг. Ийм техник нь практик шинж чанартай бөгөөд санал, туршлага солилцохыг шаарддаг.

Хэрэглэж болох зарим арга техникийн хувьд: дугуй ширээний ярилцлага, хагас бүтэцтэй ярилцлага, самбар, фокус групп. Эдгээр аргыг ашиглахдаа Usail нь Вестминстерийн Ардчиллын сангаас Франклин Де Вриезийн боловсруулсан "Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний сонсгол, зөвлөгөөнд оролцож буй гэрчүүдэд зориулсан заавар"-д үндэслэсэн болно. Ойлголтыг тодорхой болгох бусад оролцогчид:

- а) Үйлчилгээний байгууллагууд
- б) Үүрэг хүлээсэн субъект
- в) Нийгмийн байгууллагууд
- г) Лобби бүлэг
- д) Академи

*Үр ашиг, үр ашгийг хэмжих:* Энэ үе шатанд тухайн хуулийг чанартай хууль гэж ангилж болох уу, үгүй юу гэдгийг тодорхойлдог. Энэхүү үр дүн нь хүрсэн зорилго, эдийн засгийн нөөцийн ашиглалтын дүн шинжилгээнээс гардаг. Үр ашиг гэдэг нь хуульд заасан зорилтыг хэрэгжүүлэхэд зориулж хуваарилсан хөрөнгийг харгалзахгүйгээр ямар ахиц дэвшил гарсныг тодорхойлно.

Энэ үе шатанд дараах асуултуудад хариулах ёстой.

- а) Хуулийн зорилтыг тухайн зохицуулалттай нь харьцуулахад чанар, тоо хэмжээ, цаг хугацааны хувьд биелсэн үү?
- б) Хэрэгжихгүй байсан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хууль хэрхэн хувь нэмэр оруулсан бэ?
- в) Хэрэгжилтэд гаднын хүчин зүйлс нөлөөлсөн үү?
- г) Нэмэлт үр нөлөө гарсан уу?

Нөгөөтэйгүүр, үр ашиг гэдэг нь эдийн засгийн нөөцийг ашиглан зорилгоо биелүүлэх түвшин юм. Энэ нь нөөцийн хэрэглээний чанарыг үнэлдэг.

Ерөнхийдөө үр ашгийн үнэлгээ нь дараах асуултуудад хариулах болно.

- а) Зорилгодоо хүрэхийн тулд хөндлөнгийн оролцоо бага өртөгтэй хувилбарыг ашиглан хийгдсэн үү?
- б) Нөөц алдагдуулах үйл ажиллагаа байна уу?
- в) Захиргааны зардал хамгийн оновчтой байсан уу?
- г) Хуулийг хэрэгжүүлэх нөөцийн бүтээмжийн түвшин зөвшөөрөгдөхүйц байна уу?
- д) Хэрэгжилт нь болзошгүй нөхцөл байдлыг бий болгодог уу?

*Нөлөөллийн үнэлгээ:* Энэ үе шат нь өөрчлөлтийн онол, үзүүлэлт, мэдээллийн сан, үр дүнтэй холбоотой. Өөрчлөлтийн онол нь хуулийн хэрэгжилт ба үр дүнгийн хоорондын хамаарлыг харуулахад тусалдаг. Энэ нь хангамж, үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүнг харгалзан хөтөлбөрийн загварт дүн шинжилгээ хийх замаар олж авдаг.

Нөлөөллийн үнэлгээг хэрэглэх үндэс нь контрафакт, өөрөөр хэлбэл объектив

хүн амтай харьцуулж болох бүлэг юм. Хуулиар хөндлөнгөөс оролцдоггүй учраас ийм бүлэглэл тодорхойлогддог. Хэрэглэж болох аргуудын зарим жишээ нь: санамсаргүй хуваарилалт эсвэл санамсаргүй байршуулалт, ялгааны зөрүү (DID), багажийн хувьсагчид, регрессийн тасалдал дизайн болон бусад.

*Үр дүнг түгээх:* Хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг танилцуулахдаа ангилах ёстой мэдээллийг үүсгэдэг. Ийм учраас үнэлгээ нь гурван төрлийн баримт бичгийг бүрдүүлэхийг санал болгодог:

- а) техникийн тайлан,
- б) хууль тогтоомжийн тайлан,
- в) иргэдэд зориулсан тайлан.

*Үнэлгээ хийх хууль тогтоомжийг сонгох:* Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас тогтоосон шалгуурт үндэслэн Usail-аас хууль нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хамаарах эсэхийг тодорхойлох зургаан элементийг ашигладаг. Ийм шалгуурууд нь:

- а) Улс төрийн төвийг сахих
- б) Ерөнхийдөө хэрэгжиж буй хуулиуд
- в) Болзошгүй байдлын хууль
- д) Арга зүйн хувьд хэрэгжиж буй
- е) Түр зуур хэрэгжих
- ф) Техникийн хувьд хэрэгжиж буй

### **Мексикийн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний сорилт ба ирээдүй:**

Мексикийн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг ашигладаг цорын ганц Usail нь хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг хөгжүүлэх сонирхолтой ч хэд хэдэн өөр сорилтуудтай тулгарсан. Жишээ нь: Ажилтнаа чадавхжуулах гэж оролдоход Мексикт хяналт шинжилгээ, үнэлгээ гэж юу болох, түүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг заадаг хөтөлбөр байдаггүй нь тогтоогджээ.

Түүнчлэн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний талаар Мексикт орон нутгийн конгресст ч туршлага байхгүй. Хоёр дахь сорилт нь улс төрийн хүсэл зориг дутмаг байна. Дэлхийн парламентын тайланд дурдсанчлан конгресс эсвэл парламентууд нь Гүйцэтгэх засаглалыг хянахгүй байх хандлагатай байв.

Тиймээс ажилгүйдэл, авлига гэх мэт нийгэмд чухал ач холбогдолтой асуудлыг хэлэлцсэнгүй. Уг тайланд "Дэлхийн бараг бүх парламентад гүйцэтгэх засаглалд хариуцлага тооцох ёстой парламентын эрх мэдэл, улстөрчид үүнийг ашиглах хүсэлгүй эсвэл чадварын хооронд ялгаа байдгийг" хүлээн зөвшөөрдөг. Эндээс харахад парламент Засгийн газарт хариуцлага тооцохын тулд хууль тогтоомжийг нягталж шалгах ёстой гэсэн байр суурин дээр улстөрчид нэгдэхгүй байна.

Мексикийн хувьд Конгресс нь Гүйцэтгэх засаглалын шийдвэрээс, ялангуяа Холбооны түвшинд хамааралтай байв. Гүйцэтгэх засаглалаас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг депутатууд хэлэлцсэнгүй, эсэргүүцсэнгүй. Мексикт 1928-2000 он хүртэл ерөнхийлөгч нь үндэстний дээд эрх мэдэл байсан "Ерөнхийлөгчийн засаглал" гэж нэрлэгддэг үе шаттай байв. Энэ үеийг PRI (улс төрийн нам) ноёрхогч эрх мэдэлд захирч байсан. Холбооны түвшний нэгэн адил орон нутгийн конгрессууд Засаг даргадаа үнэнч байв. Ийм учраас төрийн бодлого, хуулийн үнэлгээ, хяналтыг

бий болгохын төлөө хэн ч тэмцээгүй.

Гуанахуатод хуулийн үнэлгээ, гүйцэтгэх засаглалын хариуцлагын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн тул Конгресст энэ үүрэг өөрчлөгдсөн. Үнэлгээнд тулгарч болох өөр нэг сорилт бол авлига юм. Дэлхийн авлигын Барометрийн судалгаагаар Латин Америкийн улс төрчид хамгийн их авлигад идэгдсэн гэж үздэг.

Авлига нь хөгжлийн саад тотгор болж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, төрийн хууль ёсны байдал, тогтвортой байдал, тэр байтугай хүрээлэн буй орчинд ч нөлөөлдөг. Олкен, Панде нар авлига нь "пүүсүүдийн ахиу татварын хувь хэмжээг нэмэгдүүлж, бизнесийн үйл ажиллагааг бууруулж, төсвийн хөрөнгийн ахиу зардлыг өсгөж, засгийн газрын зарим төслийг эдийн засгийн хувьд үр ашиггүй болгож, засгийн газрын гадаад хүчин зүйлийг засах чадамжийг үгүй болгодог" учир хөгжиж буй орнуудад өндөр өртөгтэй гэдгийг баталж байна.

Авлигын дэлхийн индекс Мексикт 30 оноо өгсөн бөгөөд 0 нь хамгийн муу үнэлгээтэй улс, 100 нь хамгийн сайн үзүүлэлт юм. Авлигатай холбоотой анхаарах асуулт бол: Конгресс тэр дундаа Usail авлигатай хэрхэн нүүр тулж чадах вэ? Транспэрэнси Интернэшнлээс санал болгож буй эхний алхам бол зөвхөн засгийн газрын үйл ажиллагааг хянах биш харин парламентын гишүүд өөрсдөө ёс зүйн дүрэм, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, шударга ёс, мэдээллийн эрх чөлөө, хяналт зэргээр дамжуулан шударга ёс, хууль ёсны өндөр стандартыг сурталчилж, дагаж мөрдөх ёстой. Ийм учраас Гуанахуато мужийн Конгресс нь төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэмтэй бөгөөд төрийн албан хаагчдад дотоод хяналт тавьдаг.

---o0o---

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Үр дүнд хүрэх зам-Хөгжлийн үнэлгээг үр дүнтэй удирдан явуулах нь” Линда Г.Морра Имас, Рей С.Рист 2011 он,
- ESCAP Monitoring and Evaluation Policy and Guidelines 2017 он,
- Parliaments in Europe Engaging in Post-legislative Scrutiny: Comparing the French, Italian and Swiss Experiences  
<https://www.researchgate.net/publication/342737680> Parliaments in Europe Engaging in Post-legislative Scrutiny
- [http://164.100.47.193/Refinput/Research notes/English/04122019\\_174605\\_102120495.pdf](http://164.100.47.193/Refinput/Research%20notes/English/04122019_174605_102120495.pdf)
- [https://www.wfd.org/wp-content/uploads/2020/02/WFD\\_DeVrieze\\_2020\\_PLSinEurope.pdf](https://www.wfd.org/wp-content/uploads/2020/02/WFD_DeVrieze_2020_PLSinEurope.pdf)
- **POST-LEGISLATIVE SCRUTINY GUIDE FOR PARLIAMENTS**  
[https://www.wfd.org/wp-content/uploads/2018/07/WFD\\_Manual-on-Post-Legislative-Scrutiny.pdf?fbclid=IwAR37-pesPGWx9pofQiGMVsVFVbyMZ9G1yVLPa0m4IqRJwvke4Iw6-S2MZi0](https://www.wfd.org/wp-content/uploads/2018/07/WFD_Manual-on-Post-Legislative-Scrutiny.pdf?fbclid=IwAR37-pesPGWx9pofQiGMVsVFVbyMZ9G1yVLPa0m4IqRJwvke4Iw6-S2MZi0)
- Applying Post-Legislative Scrutiny to the Analysis of Legislation and SDGs in South and Southeast Asia Journal of Southeast Asian Human Rights, Vol. 4 Issue. 1 June 2020 pp. 1 -22 doi: [10.19184/jseahr.v4i1.17611](https://doi.org/10.19184/jseahr.v4i1.17611)
- Post-Legislative Scrutiny in the Americas
- <https://www.parlament.ch/en/organe/committees/parliamentary-control-administration-pca> - Парламентын хяналтын газар (PCA)
- <https://www.parlament.ch/en/organe/committees/supervisory-committees> - Парламентын хяналтын газар (PCA) -ын хороод
- <https://www.parlament.ch/en/organe/committees/parliamentary-control-administration-pca/pca-evaluations> - Парламентын хяналтын газар (PCA)-ын Хяналтын хороо үнэлгээний алхам
- Handbook for Monitoring and Evaluation  
[https://www.measureevaluation.org/resources/training/capacity-building-resources/basic-me-concepts-portuguese/IFRC\\_Monitoring%20and%20Evaluation%20handbook.pdf](https://www.measureevaluation.org/resources/training/capacity-building-resources/basic-me-concepts-portuguese/IFRC_Monitoring%20and%20Evaluation%20handbook.pdf)

Anlage 1 zum Bericht vom 17.11.2008

## Übersicht zur retrospektiven Gesetzesfolgenabschätzung

### A. Grundlagen der Gesetzesfolgenabschätzung (GFA)

#### Definition: Was ist GFA?

Gesetzesfolgenabschätzung ist ein Verfahren zur Erkundung und zur vergleichenden Bewertung von Folgen beabsichtigter oder in Kraft getretener Rechtsvorschriften.

Sie dient

- der Entwicklung von Regelungsalternativen und der vergleichenden Folgenbeurteilung dieser Regelungsalternativen, um daraus optimale Lösungsmöglichkeiten zu ermitteln,
- der Überprüfung von Entwürfen von Rechtsvorschriften nach bestimmten Kriterien (wie z.B. Wirksamkeit, Praktikabilität und Kostenfolgen),
- der laufenden oder zu einem bestimmten Zeitpunkt durchzuführenden Evaluierung der tatsächlich eingetretenen Wirkungen bereits in Kraft gesetzter Rechtsvorschriften (Bewährungsprüfung).

#### Die drei Module der GFA: Wo setzt GFA an?

Aus den Anforderungen, die sich in den unterschiedlichen Stadien des Gesetzgebungsprozesses und anschließend beim Gesetzesvollzug ergeben, lassen sich drei GFA - Arten („Module“) ableiten:

Die *prospektive GFA (pGFA)* ist ein vorausschauendes Verfahren der Folgenabschätzung auf der Basis von Regelungsalternativen. Ausgangspunkt ist ein Regelungsvorhaben (eine Regelungsabsicht).

Die pGFA wird eingesetzt, um

- die Notwendigkeit einer rechtlichen Regelung zu ermitteln (besteht tatsächlich ein Regelungsbedarf?),
- Regelungsalternativen zu entwickeln und die wahrscheinlichen Folgen dieser Alternativen (welche Effekte sind wo, für wen und wann zu erwarten?) abzuschätzen, jeweils zu vergleichen und hinsichtlich ihrer Zweckmäßigkeit zu bewerten,
- die optimale Regelungsalternative auszuwählen.

2. Die *begleitende GFA (bGFA)* dient der Prüfung und dem Test von Entwürfen von Rechtsvorschriften. Grundlage ist ein Regelungsentwurf. Die Betrachtungsweise ist vorausschauend.

Die bGFA wird eingesetzt, um

- Regelungsentwürfe nach bestimmten Prüfkriterien zu analysieren (z.B.: Praktikabilität: Sind die geplanten Regelungen effizient, befolgbar und akzeptabel? Z.B. Kostenfolgen: Stehen Belastungen und Entlastungen insgesamt in einem angemessenen Verhältnis?)
- Regelungsentwürfe oder Teile davon realitätsnah zu testen
- Mängel, Lücken, Widersprüche oder ungewollte Folgen (Nebenwirkungen) aufzuspüren und den Regelungsentwurf zu optimieren.

3. Die *retrospektive GFA (rGFA)* soll die tatsächlich eingetretenen Folgen einer Rechtsvorschrift ermitteln. Grundlage ist eine bereits in Kraft getretene Rechtsvorschrift. Die Betrachtungsweise ist rückschauend.

Die rGFA wird eingesetzt, um

- den Grad der Zielerreichung einer bereits geltenden Rechtsvorschrift zu ermitteln
- weitere Folgen und Effekte (wie z.B. Kostenentwicklung, Kosten-Nutzen-Effekte, Akzeptanz, Praktikabilität) oder auch Nebenwirkungen zu erkennen
- einen etwaigen Novellierungsbedarf und den Novellierungsumfang der bestehenden Rechtsvorschrift zu ermitteln.